

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, Мягмар гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 8
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9 - 116
1.	“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	10 - 37
2.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	37 - 39
3.	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	39 - 57
4.	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй танилцах	57 - 73
5.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	74
6.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан	74 - 93
7.	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэл /үргэлжлэл/	94 - 111
8.	“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	111 - 116

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 23-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 54 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилоттой: Ш.Адъяаа, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж;

Чөлөөтэй: Б.Дэлгэрсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: С.Бямбацогт, Н.Учрал.

**Нэг. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Отгончимэг, А.Отгонцэцэг, Шүүхийн сахилгын хорооны гишүүн О.Номуулин, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дарга Л.Санжрагчаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Алтанхуяг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг, А.Отгонцэцэг, Н.Баасанжав нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан, Г.Амартүвшин, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын мэргэжилтэн Н.Ганбагана, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Даваатогтох, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Ц.Шинэбаяр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Л.Сүх-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Даваатогтох, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Л.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй танилцах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн эрх зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Ц.Мөнхцэцэг, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн эрх зүйн дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Таггалсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Хяналт шинжилгээ хариуцсан ахлах референт Д.Түвшинтөр, Сургалт хариуцсан референт Р.Нэнсэндэн, Хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Дэлгэрбаяр, Хэвлэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Оюу-Эрдэнэ, Тогтоол шийдвэр, бүртгэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Халиун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Болорсүх нар байлцав.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланд Улсын Их Хурлын Тамгын газрын

Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсээс хийсэн шинжилгээг хэлтсийн дарга Г.Болорсүх нар танилцуулав.

Танилцуулгуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэл
/үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Х.Мөнхзул, С.Дондов, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хяналт шалгалт, үнэлгээ хариуцсан референт Б.Дэлгэрмаа, “Мянганы сорилтын сан” улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл, “Монгол шуудан” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Тэлмэн, Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга Б.Алтанбадралт, цахимаар Ховд аймгийн Засаг дарга Э.Болормаа, Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг дарга Ө.Бат-Өлзий, Увс аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ц.Алимаа, Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Наранболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэлийн Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн зарим асуудал, Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал, Хүүхдийн эрхийн зарим асуудал, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал, Иргэний болон байгаль орчны чиглэлээр хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт, Хорих ял эдлэн суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны асуудал гэсэн сэдвийн хүрээнд хийсэн дүгнэлт болон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, “Монгол шуудан” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Тэлмэн, цахимаар Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг дарга Ө.Бат-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, Б.Энхболд, Х.Мөнхзул, Г.Нарантуяа, С.Дондов, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Ц.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Тогтоолын төслөөс 4-ийн “г” хэсгийг хасъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Тогтоолын төслөөс 9-ийн “а” хэсгийг хасъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 06 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
10 цаг 54 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Ганибалын Амартүвшин, гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Лхагвын Мөнхбаатар, гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн гэсэн ирцтэйгээр ирц 57.9 хувийн ирцтэйгээр ирцийн шаардлага хангагдсан байна.

Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёр. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Гурав. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудал байгаа.

Дөрөв. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй танилцах.

Тав. Байнгын хорооны тогтоолын төсөл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Зургаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэх.

Долоо. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл. Үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Найм. “Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн

гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Ийм асуудлуудыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Нэг. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүгдэд тараасан байгаа.

Тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Лхагвын Мөнхбаатар танилцуулна.

Л.Мөнхбаатар даргын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байна” гэсэн заалт нь 2021 онд шинэчлэн найруулан баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуульд

тусгалаа олж, уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэгт шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлоготой байх бөгөөд түүнийг Ерөнхий зөвлөл хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Улсын дээд шүүх, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжилна гэж тогтоосон.

Дээрх зорилтын хүрээнд Шүүх ерөнхий зөвлөлөөс бүх шатын шүүх, Шүүхийн сахилгын хороо, Улсын Ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, анхан болон давж заалдах шатын шүүхийн шүүгч, шүүхийн Тамгын газрын төлөөллийг оролцуулан Монгол Улсын шүүх хурлын хөгжлийн бодлогод тусгах саналыг боловсруулж 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Их Хуралд уламжилсан.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн “Монгол

Улсын шүүх эрх мэдлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах Байнгын хорооны санал, дүгнэлт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатараар ахлуулж, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Б.Энх-Амгалан нарын гишүүд ажиллалаа.

Мөн ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Улсын дээд шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбооны төлөөлөл орж ажилласан бөгөөд ажлын хэсэг 3 удаа, ажлын дэд хэсэг 5 удаа хуралдаж, Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон хавсралтын талаарх төслийг бэлтгэн Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төслийг 10 жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байх нь зүйтэй гэж үзээд нийтдээ

- 766.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй
- 7 зорилго,
- 16 зорилт,
- 79 арга хэмжээ,
- 103 шалгуур үзүүлэлт бүхий урт хугацааны хөгжлийн баримт бичиг байхаар боловсрууллаа.

Тухайлбал, шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангаж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх,

шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг хөгжүүлэх, шүүхийн хүний нөөцийн чадавхын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон тогтвортой нь тооцоолсон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг цогцоор нь тусгалаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3-д шүүхийн хараат бус байдал хангагдаж, “Хариуцлагатай, иргэн төвтэй шүүхийн тогтолцоо” руу хөгжинө гэсэн үйл ажиллагааг хөгжүүлэх нөхцөл бүрдэж дараах үр дүн гарна гэж үзэж байна. Тухайлбал,

- Шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал сайжирч, шүүхэд итгэх иргэдийн итгэл дээшлэх, иргэн шүүхэд хандахад нэхэмжлэлийг олон дахин буцаадаг хүндрэл чирэгдэл арилж, иргэний шүүхэд мэдүүлэх эрх баталгаатай хэрэгжинэ.
- Шүүгчийн албаны болон хувийн хараат бус байдлын түвшинд тогтмол үнэлгээ хийж, шүүгчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг бий болгоно.
- Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоо улам боловсронгуй болно.
- Шүүгчийн хараат бус бие даасан байдал хангагдаж, хариуцлагатай шүүх төлөвшинө.

■ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимжилт бүрэн нэвтэрч, шүүхийн үйлчилгээний шуурхай байдал, чанарт ахиц гарна.

■ Шүүхийн шийдвэрийн судалгааны эргэлтийг сайжруулах зорилгоор нийтэд нээлттэй барьсан, одоогоор 500 мянга гаруй болсон шүүхийн шийдвэрийн цахим санд боловсруулалт хийх хиймэл оюун ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

■ Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, шүүхийн дотоод мэдээллийн урсгалыг ил тод байлгах, ашиглах, хуульд заасны дагуу түгээх боломж бүхий программ хангамж нэвтрүүлнэ.

■ Шүүхийн захиргааны байгууллага хүний нөөцийг шилж олох, сонгон шалгаруулах, тогтвортой ажиллуулах эрх зүйн үндэс бий болно.

■ Шүүгчийн ачааллын зохист хэмжээнд нийцүүлэн орон тоог бодитой тогтоох эрх зүйн орчин хөгжиж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар дээшилнэ.

■ Шүүхийг стандартын байр, барилга байгууламжаар үе шаттайгаар хангана.

■ Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор шүүхийн зардлыг бүхэлд нь шүүхийн үйл ажиллагааны зардлын тодорхой хэсгийг үр дүнд суурилан санхүүжүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ гэж үзлээ.

Байнгын хороо, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгээс бэлтгэсэн танилцуулга болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Д.Цогтбаатар: Л.Мөнхбаатар даргад баярлалаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүд Л.Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ц.Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Н.Отгончимэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, А.Отгонцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, О.Номуулин Шүүхийн сахилгын хорооны гишүүн, С.Заяадэлгэр Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Л.Санжрагчаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дарга, Ц.Адъяахишиг Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга, Ш.Жолбарс Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга гэсэн бүрэлдэхүүн байна. Хуралдаанд оролцож байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Б.Энх-Амгалан гишүүн асуултаа асууя. Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг.

Б.Энх-Амгалан: Би ажлын хэсэгт байгаа юм.

Тэгэхээр би ганцхан. Ажлын хэсэг дээр орж ирсэн юм орсон уу гэдгийг л асуух гээд байна л даа.

Би хоёр санал хэлсэн. Энэ шүүхийн хөгжлийн асуудалд яалт ч үгүй шүүгч нарын ажлын байрны нөхцөл их муу байгаа юм.

Зарим анхан шатын шүүгч нь нэг байранд 3 дүүргийн шүүх орчихсон.

Шүүх хуралдааны танхим нь хүрэлцэхгүй, техник хэрэгсэл нь муу. Тэгээд үүнээсээ болоод судалгааны дүн гараад байгаа юм л даа.

Жишээлбэл, эдийн засгийн баталгаа хангагдахгүй байна гэдэг судалгааны дүн 67.1 хувьтай.

Дээрээс нь шүүхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар цаг хугацаа их алддаг гэдэг мэдээлэл 62.5 хувьтай байгаад байгаа юм.

Тэгээд энэ нь яаж байна гэхээр яалт ч үгүй л нөгөө ажиллах орчин нөхцөл маш муу байгаатай л холбоотой байгаа юм.

Яг нарийндаа аваад үзэх юм одоо энэ мөрдөн шалгах байгууллагуудын байр сав, тэр прокурор болоод Авлигатай тэмцэх газар эд нарын байр савыг шүүхийн байр савтай харьцуулах юм бол тэнгэр газар шиг ялгаатай байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал энд тусгагдсан уу? Үүнийг би оруулж байсан юм. Тэгээд сүүлийн бичиг баримтаа би хараагүй байна.

Тийм учраас үүнийг нэг асуух гэж байгаа юм.

Хоёр дахь нь, энэ асуудал дээр жил болгон улсын төсөв дээр тодорхой зардал суулгаж явъя гэж яриад байгаа юм л даа.

Хоёр дахь нь юу юм гэхээр Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо сургалт, судалгаа хийж гадагшаа их явж байгаа юм.

Тэгээд шүүхийн мэтгэлцээний зарчмуудыг тэд нар чинь нэлээн нарийн сураад үзээд, хараад, сургалтад хамрагдаад яваад байдаг. Манай шүүгч нар бол таг суугаад байдаг.

Тэгэхээр эд нарыг явуулахад, цаашдаа хүний эрхийг зөв хангаж, шүүхийг нээлттэй, ил тод, хараат бус байлгахад шаардлагатай хөшүүрэг хийж өгөх ёстой. Энэ бичиг баримт дотор гэж үзсэн. Энэ маань ер нь хэр явж байна гэдэг хоёр дахь асуудал байгаа юм.

Энэ хоёр асуулт дээрээ би нэг хариулт аваадахъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг. 2 дугаар микрофон өгье.

Л.Энхбилэг: Эрхэм гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Өнөөдрийн энэ хэлэлцэх асуудалд хүрэлцэн ирсэн гишүүддээ бас талархал илэрхийлье.

Б.Энх-Амгалан гишүүний асуултад хариулья.

Өнөөдрийн нөхцөл байдал бол байрны асуудал маш хүнд байгаа.

2013 оны Шүүх байгуулах хуулиар дүүргийн, тойргийн шүүхэд байгуулагдсан. Үүний дараагаар Үндсэн хууль зөрчсөнтэй холбогдуулаад шүүхийн бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо дахин өөрчлөгдсөн.

Цахим өөрчлөгдөхдөө шүүхүүдийг дүүрэг дүүрэгт нь буюу одоо харьяалж байгаа орон нутгийн дүүргийн шүүхүүдэд байр өгөлгүйгээр яг тэр байгаа байранд нь үлдээсэн.

Өнөөдөр нэг байранд 3 шүүх үйл ажиллагаа явуулж байгаа.

Хүний нөөц хэргийн ачаалал ихэссэнээс шалтгаалаад шүүх хуралдааны танхим хүрэлцэхгүй байх асуудал нэн тулгамдсан асуудал болж байгаа.

Бид энэ хөгжлийн бодлогодоо яг энэ байрныхаа асуудлыг оруулж өгсөн.

Өнөөдрийн байдлаар 116 шүүх анхан болон давж заалдах шатын шүүхэд шүүн таслах ажиллагаа явуулж байна.

Нийтдээ бид энэ төсөвтөө 43 байрыг шинээр барихаар 459 тэрбумыг суулгаж өгсөн.

Энэ асуудлыг багцаар нь шийдээд өгчих юм бол шүүн таслах ажиллагаа хэвийн, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн хугацаанд, иргэдэд чирэгдэлгүй, иргэдийн итгэх итгэл нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм.

Мөн түүнчлэн зардал мөнгөний хувьд хуульд байгаа. Урьд оны төсвөөс буурахгүй гээд. Гэхдээ энэ бол яг бодит байдал дээр бас хэрэгжиж чадахгүй байна.

Төсөвт 2 хувийг тусгаад өгчих юм бол бид ойрын хугацаанд 2-оос 3 жил дотор энэ байрны асуудлаа бүрэн гүйцэд шийдвэрлэх боломжтой.

Ер нь гишүүддээ хэлэхэд сүүлийн 10 жил шүүхэд хөрөнгө оруулалт огт байхгүй.

Сая харин энэ 2024 онд төсөвт цахимжилттай холбоотой 14.9, хөрөнгө оруулалт буюу байрны зардалтай холбоотой 5 тэрбумыг тавьсан.

Хан-Уул дүүрэгт байрлах цогцолбор барилга буюу шүүхийн байранд бид нийтдээ 75.9 тэрбумын цогцолбор барилга барихаар төсөвлөөд зураг төсөв нь хийгдчихсэн.

Энэ дээр сая 2024 онд 5 тэрбумыг л тавьж өгсөн. Уг нь бид 25-ыг тавьж өгөөч ээ гэж өгсөн боловч 5-ыг тавьж өгсөн.

Тэгэхдээ эндээ бид чамлахгүй байгаа. Ажлаа эхэлчихсэн явж байна. Аль болохоор мөнгөө буцааж хураалгахгүйн төлөө байшингаа ядаж хоёр, гурван давхар каркас барихын төлөө хичээж чармайж ажиллаж байна.

Гурав дахь асуултад манай ажлын хэсгийн ахлах Н.Отгончимэг хариулна.

Д.Цогтбаатар: Хэддүгээр микрофон билээ? 3 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: Та бүхний өглөөний амар амгаланг айлтгая.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого үндсэн 7 зорилго агуулж байгаа.

Тэгээд хамгийн эхний зорилго нь нэгэнт **“Алсын хараа-2050”** дээр “Иргэн төвтэй шүүх”-д тэмүүлнэ.

Энэ 10 жилийн хугацаанд шүүх бол шүүгч төвлөрсөн биш иргэн төвтэй байх зорилго агуулж байгаа учир эхний хэсэг нь иргэндээ зориулсан нээлттэй байх, ил тод байхад зориулсан зорилго байгуулж байгаа.

Харин хоёр дахь хэсэг нь энэ тогтолцоог авч явах гол хүмүүс нь шүүгч нар байгаа.

Шүүгч нарын хараат бус бие даасан байдлыг хангахад мэдлэг, ур чадварыг ерөөсөө байнга, тогтмол үргэлжилсэн сургалтын байдлаар мэргэшүүлж байх асуудал цаашдын 10 жилд мөн адил үргэлжлэхээр хийсэн байгаа.

Хоёр дахь зорилгын хүрээнд нийтдээ 9.2 тэрбум төгрөг санхүүгийн төсвийн хувьд тусгагдсан байж байгаа.

Энэ мөнгө 10 жилийн хугацаанд зарцуулагдах мөнгө байгаа.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Бид санхүүг нь шийдэж өгөөгүй, ажлын байрных нь нөхцөлөөр хангаагүй, эдийн засгийн баталгааг нь хангаагүй байж шударга цөөнхийн асуудал, шүүх нарын хараат бус байдлын асуудал яриад цаашдаа хэцүү.

Тийм учраас одоо энэ тавигдаад байгаа 459.0 тэрбум төгрөгийг нь үе шаттайгаар суулгаад явах юмыг яг энэ тогтоол дотор сайн тусгаад өгчих хэрэгтэй.

Тэгээд жил болгоны төсөв дээр яг тэр мөнгийг нь суулгаж явдаг л юм хийхгүй бол цаашаа явахгүй юм билээ.

Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого бол урт хугацааны бичиг баримт.

Шүүх тасралтгүй, хараат бус, тэгээд цогцоороо хөгжих ёстой гэдэг бичиг баримт учраас үүнийгээ нэлээн анхаарах ёстой гэдэг дээр би байр суурь нэг байна.

10 жил төсөв байхгүй байсан шүүх шүү дээ.

Тийм учраас одоо энэ дээр байгаа 25.0 тэрбумыг нь хэвээр үлдээгээд цаашаа явчихвал наад барилгын чинь нэг тал хувь нь ч гэсэн яваад өгнө.

Тэгэхээр үүнийгээ энэ дээр ингэж оруулах саналтай байна.

Д.Цогтбаатар: 1 минут Б.Энх-Амгалан гишүүнд.

Б.Энх-Амгалан: Тэр 9.2 тэрбум төгрөг 10 жилийн хугацаанд шүүгч нарынхаа боловсролыг дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах юманд зарна гэдэг бол маш бага мөнгө.

Тийм учраас үүнийгээ бас нэг жоохон нэмээч. Тэгэхгүй бол одоо ингээд яг нарийндаа хэлэхэд Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбооны гадна дотно явж байгаа,

тэгээд яг тэр гадна талын шүүх хуралд оролцож байгаа, шүүхийн мэтгэлцээний зарчимд оролцож байгаа энэ юмнууд маань шүүгч нь хоцрогдоод энэ Өмгөөлөгчдийн болон Хуульчдын холбооных нь хүмүүсийнх нь мэдлэг тэлээд яваад байгаа учраас энэ мөнгө арай багадна шүү. Үүнийгээ жоохон нэмсэн нь зөв байх гэж би ингэж санал хэлж байгаа юм. Дэмжиж байгаа.

Д.Цогтбаатар: Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би хоёр асуулттай, нэг эргэлзээтэй л хүн байна л даа.

Энэ биелэх юм уу? Тэгээд баахан цаас л үйлдвэрлэдэг боллоо л доо. Бид нар.

Хоёр асуултыг эхлээд асуучихъя.

Б.Энх-Амгалан гишүүнтэй би санал нэг байгаа. Үгүй энэ чинь орж ирээд бид нар 4 жил суулаа шүү дээ. 4 жил л баахан юм ярилаа.

Тэр нэг Хан-Уул дүүрэгт байдаг. Байдаг юу яах вэ. Газрыг нь 10 жилийн өмнө аваад тэгээд анхных нь суурыг тавиад эхлүүлсэн тэр барилга дахиад л дараачийн 10 жилд хийнэ гээд л явах юм.

Д.Цогтбаатар дарга, танай намынханд хандаж хэлж байна. Жаран хэдүүлээ арзайж суучхаад тэгээд юу ч хийхгүй.

Тэгээд одоо дахиад их том цаас баталж яах юм, та нар. Биелэх юм уу? Би итгэхгүй байна.

Одоо нэг асуулт нь, одоо тэр Яармагийн байшинг. Цогцолбор шүү дээ. Тэр чинь.

Иргэн төвтэй иргэнд үйлчилдэг шүүх гэдэг чинь байгууллага байна гээд арван хэдэн жилийн өмнө концепц нь гараад, зураг нь хийгдээд, газар нь олгогдсон юмыг одоо болтол босгодоггүй.

Одоо энэ ирэх жилийн төсөв дээр хэдэн төгрөг байгааг надад хэлмээр байна.

Тэгээд хэдэн жилд баригдах гэж байгаа юм. Одоо та нарын 10 жилийн юмаар бол.

Шүүхийнхэнд буруу байхгүй байх. Шүүхийн ерөнхий зөвлөлз буруу байхгүй байх л даа.

Энэ улс төрчид ерөөсөө энэ шүүх эрх мэдэл, мөрдөх, прокурорын эрх мэдэл бүх юмыг ингээд гартаа барих нэг новшийн хүсэл сонирхлоос болоод Монголд ерөөсөө юм явахгүй байна.

Нэг хэсэг Ч.Хүрэлбаатарын гарт орж баахан явсан.

Дараа нь бид нар энэ 4 жилийн өмнө ярьж байгаад Байнгын хороон дээр төсвийг нь авсан шүү дээ.

Тэгээд одоо болтол босгохгүй яаж байгаа юм бэ?

Тэгээд баахан шүүгчид рүүгээ бид дайрдаг. Шүүх гэж нэг ялзарсан байгууллага байна гээд л олон нийтэд солиорцгоогоод л. Ганц байшинг нь босгоод өгчхөж чадахгүй.

Тэгээд хоёр дахь асуулт нь.

Нэгдүгээр асуулт нь, тэр Яармагийнх хэзээ болсон юм?

Хоёрт нь, Баянзүрхэд бас нэг юм босгоё гэсэн юм. Нийслэлд одоо ингээд хоёр сайхан том цогцолбор барьчаад бүх барууны стандартыг хангасан, гэрч, нөгөө өмгөөлөгч, юу билээ сэжигтэн гээд бүх механизмууд нь байна.

Хоорондоо уулзахгүй, учрахгүй, орохгүй, гарахгүй гэдэг юм уу.

Үүнийг чинь хийчихсэн шүү дээ. Одоо үүнийг би дахиад үзлээ л дээ. 7 юман дотор чинь дахиад л бичээд л явж байна.

10 жил юу ч хийгээгүй нөхдүүд тэгээд дахиад 10 жилд юм хийх юм байх даа.

Хоёр дахь асуулт нь, сая тэр Хөгжлийн банк гээд явж байхад. Энэ Г.Амартүвшин анзаарсан уу, үгүй юу. Хавтаст хэрэг гэж нэг заваан юм байна.

Заваан гэдэг нь ямар ч стандарт алга. Одоо үүн шиг нэг материал тэр хэд байдаг юм. 50 хавтаст хэрэг л гэхэд материал 10 удаа давтагдаж байна.

Ямар их цаас үйлдвэрлэж байна. Хэзээ энэ стандартыг тогтоож, хэзээ цахим маягийн юм руу орох юм бэ? Хоёр дахь асуулт нь энэ.

Тэгээд Д.Цогтбаатар дарга ер нь, одоо тэгээд хэрэлдээд яах вэ дээ. Одоо угаасаа 4 жил чинь дуусчихлаа.

Нээрээ харамсалтай байгаа байхгүй юу. Юу ч хийхгүй юм. Цаас л үйлдвэрлээд байх юм. Цаас л үйлдвэрлээд байх юм.

Би одоо үүнийг чинь гараа өргөөд л дэмжчихнэ л дээ.

Хамгийн гол юм нь одоо цаас үйлдвэрлэхээ боль л доо. Ажил хий л дээ.

Тэгээд одоо бүгдээрээ сонгуульд мордоод давхичихсан. Ямар илэнцгийнх нь. Одоо энэ Байнгын хороо чинь хуралдах гэж цаг гаруй боллоо шүү дээ.

Тэгээд морин дэл дээгүүр юм одоо баталж хийж бас болох л юм байх даа. Та нар юундаа бас яараад байгаа юм. Дараагийнхаа парламент дээр үүнийгээ ярьж болохгүй байсан юм уу? Би үүнийг чинь ингээд бүгдийг нь уншсан л даа.

Зарим нь хэтэрхий деталь, зарим нь одоо нэг тийм их сайн зүйл биш л байна.

Уг нь би дэмжээд байгаа юм. Шүүх байгууллагын бие даасан, хараат бус.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би дэмжээд байгаа.

Үүнийг хараат бус болгомоор байгаа юм. Бүх бичиг цаас нь тэгж л явдаг байхгүй юу.

Амьдрал дээр ажил чинь ерөөсөө явж өгөхгүй юм.

Одоо энэ дотор хамгийн том нь Д.Цогтбаатар дарга байна. Д.Цогтбаатар даргыг л загная даа. Ямар ч арчаагүй цаас үйлдвэрлэсэн. Хуралдаа ч ирэхгүй.

Эсвэл одоо энэ хурлаа завсарлуулаад нэг мөсөн тэгээд тэр сонгуулийнхаа дараа ярьж болдоггүй юм уу. Д.Цогтбаатар дарга аа.

Яагаад ингээд яаран сандран морин дэл дээгүүр чухал чухал асуудлуудыг оруулж ирдэг юм бэ? Би бас жаахан гайхаад л байна.

Тэр хоёр асуултдаа нэг хариулт авчихъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг 2 дугаар микрофон. 2 дугаар микрофон Л.Энхбилэг даргын.

Л.Энхбилэг: Баярлалаа. Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулья.

Бид 2025 онд Хан-Уулын цогцолбор барилга дээр 36.9 тэрбумыг тавиулж байгаа.

2026 ондоо бас энэ хэмжээгээр тавиулаад, 2026 ондоо энэ барилгаа бариад дуусна гэсэн төсөөлөлтэй байгаа.

Ер нь шүүхийн байр хүнд байгаа гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр энэ асуудал дэмжигдээд явах байх.

Бид 2021 оны 01 сарын 15-нд Улсын Их Хурлаар баталсан 03 сарын 01-нээс дагаж мөрдөж одоо хүчин төгөлдөр болсон энэ хуулийн 5.11-д заасны дагуу хөгжлийн бодлогоо боловсруулаад ингээд Улсын Дээд шүүхтэйгээ зөвшилцөөд Засгийн газарт 2022 оны 10 сард ирүүлсэн байгаа.

Хоёр дахь асуудлыг манай Н.Отгончимэг гишүүн ажлын хэсгийн ахлах хариулна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулья.

Ер нь энэ хөгжлийн бодлого биелэх юм уу гэдэг ерөнхий асуулт асууж байна.

Би үүнийг биелэх бүрэн боломжтой гэж хэлнэ.

Үүнд хэд хэдэн үндэслэл байгаа юм. 24 жилийн өмнө Улсын Их Хурал “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ыг баталж байсан түүх байдаг.

Шүүхийн ерөнхий зөвлөл 24 жилийн өмнөх энэ бодлогод үнэлгээ хийсэн.

Үндсэндээ 92 хувь нь биелжээ.

2000 он гэхээр илүүтэй тогтолцооны шинжтэй өөрчлөлт хийхээр тухайн үед тусгаж байсан юм билээ.

Бид **“тогтолцооны өөрчлөлт”** гэдэг зүйлийг цөөн бичсэн байгаа. Үнэн. Энэ бол нэлээн деталь шинжтэй томъёоллууд орсон байгаа.

Яагаад деталь шинжтэй томъёолол орсон юм бэ гэдэг үндэслэл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг Их Хурлаас баталсан.

Энэ хуулийн дагуу урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулахад хэд хэдэн шаардлага байгаагийн нэг нь

■ *боломжит хэмжээнд биелэгдэхүйц;*

■ *биелэлтийг нь үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий;*

■ *хариуцах эзэнтэй байх ёстой*

гэдэг хэд хэдэн чухал шаардлагууд байгаа.

Тэгэхээр 24 жилийн өмнө баталж байсан энэ бодлогоос ялгаатай нь үүгээрээ байгаа юм.

- **Хариуцах эзэнтэй.**
- **Холбогдох санхүү, мөнгөтэй.**
- **Гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлттэй**

байгаа учир харьцуулсны үндсэн дээр бүрэн биелэгдэх боломжтой шүү гэж байгаа.

Яагаад яаран сандран батлуулах гэж байна вэ гэдэг дээр л зүйл хэлмээр байна.

Бид Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий зөвлөл Улсын Дээд шүүх, Засгийн газартай зөвшилцөөд энэ олон саналыг Их Хуралд уламжлах үүрэг хүлээсэн байгаа. Шүүхийн хуулиараа.

Үүний дагуу 10 сарын 02-нд бид үүнийг уламжилсан юм. 6 сарын өмнө.

Ажлын дэд хэсэг болон үндсэн ажлын хэсэг нэлээн олон хуралдсан. Нэлээн олон томъёолууд дээр бас найруулгуудад ингэж хийгдсэн байгаа.

Тийм учир үүнийг яаран сандран гэхээсээ илүүтэй бидэнд нэг амин чухал хэрэгцээ байгааг Их Хурлын гишүүд минь ойлгооч ээ гэж хүсэж байна.

Бид ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэлд саналаа 05 сарын 01-нд явуулах ёстой.

Энэ 10 жилийн хөтөлбөр үндсэндээ зорилго, арга хэмжээ байхаас гадна санхүүгийн асуудлыг шийдэж байгаагаараа маш их ач холбогдолтой байгаа юм.

Тийм учир 05 сарын 01-нээс өмнө батлаад өгчихвөл цаашдаа шүүх эрх мэдлийн байгууллага төсвөө тэр Сангийн яам руу явуулах, Засгийн газартай хэлэлцээрт ороход энэ амин чухал байгаа юм.

Хөгжлийн банкны хэрэгтэй холбогдуулаад хавтаст хэргийн нэлээн хүндрэлтэй цаасан баримт бичгийн асуудал ярьж байна.

Өмнөх төсвийн хуулиар Их Хурал бидэнд 14.8 тэрбум төгрөг баталж өгсөн.

Энэ мөнгийг та нар цахимж гэж баталж өгсөн.

Бид энэ ажлыг ид хийж байна. Бидний төсөөллөөр 12 сарын 31-н гэхэд ерөөсөө шүүх дээр цаасан хавтаст хэрэг байхгүй байдлаар программ хангамжийг хийж байна. Техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж байгаа.

Маш бага зэргийн мөнгө дутах юм билээ. Тэрийг Их Хурлын гишүүд маань ирэх ондоо шийдээд өгчихвөл **эрүү, иргэн, захиргааны хэрэг** нь үе шаттай шилжинэ.

Одоогийн байдлаар бидний төсөөлөл хамгийн түрүүнд **“захиргааны хэрэг”** **100 хувь цахимжих.**

Шүүх дээр цаас байхгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахимаар явуулахаар төлөвлөж байгаа.

6 сарын дараа “эрүү, иргэний хэрэг” 100 хувь цахимжих байдлаар төлөвлөлтүүд хийгээд явж байгаа.

Тийм учраас цаашдаа цаасан хавтаст хэрэг овоорох, нухлагдах энэ байдал та бүхний тусламжтайгаар шийдэж өгсөн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Түрүүн Н.Алтанхуяг гишүүн бас надаас асууж байх шиг байна. Яагаад ингэж яарч хийж байгаа юм бэ. Үүнийг дараагийн юу руу шилжүүлж болохгүй юм уу гээд.

Тэгэхээр би 12 сард л Байнгын хорооны удирдлагаар ирлээ. Энэ чинь 10 сард тавигдсан асуудал учраас.

Миний зүгээс барьж байгаа ганцхан л зарчим байгаа.

Нэг ч ажлыг Д.Цогтбаатар гэдэг хүний хүнд суртлаас болж гацааж арагш нь тавьж болохгүй. Ороод ирсэн ажлуудыг би бүгдийг нь дуусгаж өгөөд явахыг бодож байгаа.

Би Байнгын хорооныхоо хэдэн залуучуудад бас хэлмээр байна. Ёстой цаг наргүй ажиллаж байгаа шүү.

Энэ хэдэн залуучууд бол харин энэ их цаасан дунд чинь үнэхээр орж ирсэн асуудал болгоныг нь яаралтайг нь яаралтайгаар нь явуулаад зүтгэж байгаа.

Зүгээр би энэ дээр нэг юм хэлмээр байна.

Энэ чинь яарч байгаа биш. Харин оройтож байгаа. Таны хэлж байгаа яг

үнэн. Оройтчихсон байгаа асуудал байхгүй юу. Аль хэдийн хийгдчихсэн байх ёстой.

Шүүх дээрээ үнэхээр анхаарал тавиагүй. Бүр шүүхийн асуудал тэртээ ард хоцрогдчихсон. Муулбал хойд талын хар овоохой гэгчээр шүүхээ муулах шиг амархан юм байхгүй болчихсон байдалтай л байгаа.

Ийм сэтгэлгээтэйгээр Монгол төр тогтвортой, тэнцвэртэй явна гэж байхгүй.

Шүүхэд асуудал байхгүй байгаа гэсэн үг бол биш. Шүүхэд асуудал бий. Шүүгчдэд асуудал бий.

Тэгэхдээ үүнийг чинь засахын тулд засдаг хууль тогтоомжийг нь гаргадаг хүмүүс харин яг энэ талд бид нар сууж байгаа байхгүй юу. Бид муу ажиллаж байна л гэсэн үг.

Тэгээд энэ дээр одоо энэ хөтөлбөрийг оруулж ирж байгаа чинь харин тэр асуудлуудаа шийдэх нөгөө суурь шийдлүүдээ л оруулж ирж байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийг оруулж ирж байж л дараагийн сайжралтын тухай асуудал яригдана.

Энэ дээр би нэг зүйлийг хэлмээр байна. Манай гишүүд. Би бас Байнгын хорооныхоо гишүүдэд талархал илэрхийлмээр байгаа юм.

Яагаад гэвэл одоо яг энэ үед ихэнх Байнгын хороодын ирц бүрдэж өгөхгүй байгаа. Манай гишүүд бол харин ирцээ аягүй сайн бүрдүүлж байгаа шүү. Нээрээ энэ төрийн ажил тасрахгүй явж байх ёстой.

Тэгээд энд сэтгэл зовниулж байгаа хэд хэдэн асуудал байна. Жишээлбэл, энэ шүүхийг балбасаар байгаад юу болчихсон байна гэхээр шүүхэд шүүгч болох хүн чинь олдохгүй болчихсон байгаа.

Одоо бид энэ бүгдийг чинь сайжрууллаа гээд шалгалт явуулаад сая би Баянхонгорт очоод ажиллахад “Иргэний танхим”-ын шүүх нь 2 жил шүүгчгүй явж байсан. 2 жил.

Сая хамгийн сүүлийн удаа 3 дахь шалгалтаа аваад нэгдүгээрт шүүгчийн шалгалт явуулж байхад 4-хөн хүн ирж байна гэж байгаа юм. 4-хөн хүн.

Тэгээд нэг нь ч тэнцэхгүй. Тэр чинь цаанаа ямар процесс энэ нийгэмд явчихсан байна гэхээр шүүгч болж яах юм.

Түүний оронд өөр газар очоод ажиллавал илүү цалинтай гээд. Шүүгчийн ажлын албан тушаалын нэр хүндийг чинь энд балбасаар байгаад байхгүй болгочихсон.

Н.Алтанхуяг: Хэн балбасан юм?

Д.Цогтбаатар: Харин одоо бид нар л, энэ улс төрчид л балбаж байна шүү дээ. Яг үнэн шүү дээ.

Тийм. Үүнээс чинь болоод юу болчихсон байна гэхээр сая тэр шүүх дээр 2 жил эзэнгүй сууж байгаа. Тэгээд сэлгэнээр хүнийг авчраад ажиллуулж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ байдлыг чинь засахын тулд энэ хөтөлбөр орж ирэхээс өөр үггүй. Энэ хөтөлбөрийг нь тэгээд яаралтай харин баталж өгөөд явуулах ёстой л гэж би бодож байгаа юм.

Тийм учраас үүнийг би дэмжээд аль болох түлхээд явуулж байгаа юм.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Шүүх эрх мэдлийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэлэлцэж байна.

Барилга байгууламжийн асуудал бол нэг л асуудал нь байх.

Гол нь шүүх эрх мэдлийн асуудал цаашдаа яаж бодлогын хэмжээнд хөгжүүлэх юм бэ гэдэг асуудлууд нь чухал байх гэж бодож байна.

2022 онд батлагдсан Шүүхийн тухай хуульд нийцүүлж ингэж хөгжлийн бодлогынхоо баримт бичгийг оруулж ирж байгаа гэж ойлгож байна.

Би зорилтын 1.2-ын “нээлттэй, ил тод байдал”-аас асуух гэж байгаа юм. Та бүхэн шүүхийн үйл ажиллагаа иргэдэд ил тод, нээлттэй байх гэдгээ юу гэж ойлгож байна вэ?

Зөвхөн шүүх хуралдааныг хэвлэл мэдээллээр гэдэг юм уу, цахимаар камераар хэргийн оролцогч нарт шуудаар дамжуулснаар энэ ил тод, нээлттэй байдал уу? Аль эсвэл шүүгчийн шийдвэр хэрхэн яаж гарсныг, ямар нотлох баримтад тулгуурлаж хэрэгтэн гэм буруутан юм уу, аль эсвэл гэм буруугүй гэж үзсэн бэ гэдгийг тухайн шүүгдэгчид хэрхэн яаж ойлгуулж, хэргийн бүх шатанд явахаас иргэдийн шүүхэд итгэх итгэл, тухайн шүүгчид шударгаар асуудлаа шийдүүлэх энэ асуудлыг ойлгох юм болов уу.

Би бол хувьдаа бүх шатад шүүх тухайн хэргийн оролцогчдод нэхэмжлэл гаргахаас авхуулаад л бүх шатад таны асуудал ингэж явж байна. Энэ шүүх дээр ингэж хуваарилагдсан шүүгч дээр. Хэргийн нотлох баримт, материал дутуу байгаа учраас ингэсэн.

Ийм байгууллагаас ингэж нэмэлт тайлбар авхуулахаар болсон, албан бичиг нь ирсэн, ирээгүй гээд бүх талаар холбоотой, харилцаатай, мэдээлэлтэй байж бас энэ асуудлаа шийдүүлэх гэж байгаа улсууд шүүгчдээ, шүүхдээ итгэх итгэл юм уялдаа холбоотой байх ёстой юм болов уу гэж би хувьдаа бодож байна.

Энэ тал дээр Та бүхэн нээлтэй, ил тод байдлыг ер нь юу гэж бодож байна вэ?

Ер нь одоо ямар байгаа юм? Цаашдаа хөгжлийн бодлогын баримт бичигтээ ямар болгоно гэж оруулж ирж байгаа юм гэдгийг нэгд асууя.

Хоёрт, 2.1.4 дээр. Шүүгчийн цалингийн түвшингийн асуудлыг ярьж байна л даа.

Мэдээж нийгмийн асуудал чухал. Энэ шүүх гэдэг чинь зөвхөн шүүгчээс биш та нарт тусалж байгаа, шүүгч нарт тусалж байгаа захиргааны ажилтнуудын асуудал дандаа хамтдаа явж байх ёстой.

Гэтэл шүүгчийн асуудал, цалингийн асуудал ярихаар энд захиргааны ажилтнуудын асуудал огт байхгүй.

Ард нь захиргааны ажилтнуудын асуудал яригдахаар тэнд дандаа л хөгжүүлэх асуудал нь, сургах асуудал нь байгаа байхгүй юу.

Тэгэхээр шүүгчийн цалин, нийгмийн баталгааны асуудлыг ярих болгондоо тэр ард нь цуг хамт яваа тэр шүүгчийн захиргааны ажилтнуудын асуудлаа хамт авч яваач ээ.

Шүүгч нарын цалингийн асуудлыг нэмэх болохоор захиргааны ажилтнуудаа хаячихдаг.

Тэгээд л эргэж бусгаад л, ахиад л захиргааны ажилтнууд нь ингээд ч үлдчихсэн байна гээд л. Гэх мэтчилэн.

Би зарчмын юм хэлэх гэж байгаа юм.

Цаашдаа ерөөсөө цалин, нийгмийн асуудлыг ярих гэж байгаа бол хамтад нь авч явдаг байгаач ээ гэдэг нэг саналыг хэлэх гэж байгаа юм.

Дараагийн нэг асуудал. Энэ хөгжлийн бодлогын баримт бичигт бас нэг чухал асуудал харин 4.1.6 дээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх урт хугацааны хөтөлбөртэй болно гэсэн нэг гэрэл гэгээтэй заалт байна.

Наад шүүгч нар чинь 34 жил баллуурсаар байгаад үнэхээр сэтгэл зүйн хувьд ажилдаа сэтгэл ханамжгүй.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Хийж байгаа ажилдаа сэтгэл ханамжгүй.

Үнэхээр ажлын ачаалалтай. Тэгээд гаднын хөндлөнгийн нөлөөнд дарамттай. орчинд үнэхээр сэтгэл зүйн хувьд маш дарамттай ажилладаг нь ноднин шүүхүүдээр явж байхад, шүүгч

нартай уулзаж ярьж байхад харагдаж байсан.

Тийм учраас шүүгч нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгөх асуудал туйлын чухал болсон юм билээ шүү.

Үнэхээр тэр мэргэжилдээ үнэнч болсон хэдэн нөхдүүд л өнөөдөр ажиллая гээд сууж байгаа юм билээ.

Түүнээс биш цалин мөнгө хараад гэдэг юм уу, дарамтаас шалтгаалаад ажлаа хаяад явах нөхдүүд олон байгаа юм билээ. Олон байгаа юм билээ. Ажиллах орчин нөхцөл мөн адилхан нөлөөлж байгаа гэж ойлгож байгаа.

Тийм учраас сэтгэл зүйн зөвлөгөө, энэ шүүгч болоод шүүхийн захиргааны ажилтнууд энэ талын хөтөлбөр чинь бол туйлын чухал юм байна лээ шүү.

Энэ дээр харин хэзээ ямар төсөл, хөтөлбөр боловсруулж батлуулах гэж байгаа юм? Үүнийгээ нэг тодруулж өгөөч.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Н.Баасанжав: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав. Таны асуултад хариулья.

Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогодоо. Би хоёр дахь асуултаас нь эхэлчихье.

Шүүхийн захиргааны ажилтныхаа эрх зүйн байдал болон нийгмийн хамгаалал цаашид тогтвортой мэргэшиж ажиллахыг бид авч үзсэн. Шүүхийн захиргааны ажилтан бол

үнэхээр өнөөдөр хүнд байдалтай байгаа нь үнэн.

Тэгэхээр шүүхэд захиргааны ажилтан буюу шүүгчийн туслах, нарийн бичиг, бусад тэгээд захиргааны ажил хийхээр ирж байгаа ажилтнуудын маань ер нь хоёрны нэг нь хоёр жилдээ буцаад ажлаас гараад явчхаж байна.

Тэгэхээр тэнд ажиллах, хүн татах орчин нь өөрөө нэгдүгээрт залуучууд юуг хардаг болсон.

Одоо ер нь залуу ч гэлтгүй ажилд орж байгаа хүний нөөц юуг сонирхож байна гэхээр

- ажлын цагтаа ажлаа багтааж хийж чаддаг юм уу,
- ажлын байр нь хүн ажиллаж болохоор тав тухтай юм уу,
- компьютер, техник хангамж нь сайн юм уу,
- хэтэрхий их цаастай зууралдахгүй жоохон цахимжсан орчин үеийн тийм чиг хандлагатай юм уу,
- байгууллагын соёл нь ямар юм,
- би энд карьер хийх боломжтой юм уу,
- цалин хөлс маань хангалттай байх юм уу

гэдэг хамгийн наад захын нөхцөлүүдийг харж байгаа.

Тэгэхээр яг манай захиргааны ажилтны хувьд эдгээр 5, 6 критери ярихад ерөөсөө бараг ингээд бүтэн унаж байгаа байхгүй юу.

Тэр хүмүүс ажилдаа дур сонирхолтой нь өөрөө хуульчийн ажил, эрх зүйчийн ажил, шүүх эрх мэдлийн салбар өөрөө сонирхолтой байгаа ганц татах хүчин зүйл нь болохоос биш бусдаар залуучуудад, манай яг захиргааны ажилтанд энэ ажлын байр төдийлөн сонирхолтой биш тийм болчихсон байгаа юм.

Тэгэхээр бид одоо яг таны асууж байгаа 4.1, 4.2 дээр байгаа юм.

Бид захиргааныхаа ажилтныг мэргэшсэн, тогтвортой байхаар ангилал, статусыг нь өөрчилье.

Шүүгч бол “төрийн тусгай албан хаагч” гэж явж байгаа.

Тэгвэл яг энэ тусгай албан хаагчийн ангилал зэрэглэлд ажиллаж байгаа шүүхийн захиргааны ажилтан яагаад тусгай албан хаагч байж болохгүй вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид тэрийгээ дотооддоо яг тэр захиргааныхаа ажлын чиглэлээр карьер хийх боломжтой байя.

Тэр нь анх ороод харуулаас эхлээд шүүгч болдог биш захиргаа дотроо өөрийн гэсэн карьертай байх хэрэгтэй.

Тэгэхээр зэрэглэлтэй байх хэрэгтэй. Нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар. Тэр нь өөрөө цаанаа цалиндаа уягдсан, цалин нь бодитой нэмэгддэг байх шаардлагатай байна гэж байгаа юм.

Одоо цахимжуулалт ярьж байна. Цахимжаад ирэхээр тэр хүмүүс дээр үнэхээр шүүгч өөр хүн хийж чадахгүй техник, технологитой харилцах шаардлага гарна.

Үүгээр нь бид мэргэшүүлж тэр дотроо тэр чадварыг эзэмшчихсэн хүн тэр гадаад хэлтэй байхад илүү нэмэгдэл авдаг шиг техник, технологи дээр ажилладаг, цахимжилт дээр ажилладаг болгон нь өөрөө ур чадвар, тэр мэргэшсэн байдлыг нь нэмэгдэлтэй болгоно гэдгийг 4.1, 4.2-тоо багтаасан

байгаа. Энэ тогтолцоог бий болгоё гэж байгаа.

Тэр нь төрийн албаны хуульд болон төрийн тусгай болох Шүүхийн захиргааны хуульдаа “**мэргэшсэн захиргааны ажилтантай болох**” гэдэг энэ тогтолцооны шинжтэй өөрчлөлт хэрэгжинэ гэж харж байгаа.

Мөн 4.1.5 дээр таны асуугаад байгаа энэ хүмүүстээ анхаарч нийгмийн асуудлыг нь шийдэж байгаа юм уу гэдэг дээр 139.0 тэрбум төлөвлөсөн байгаа.

Энэ бол тэгэхдээ яах вэ шүүгч нь багтаж байгаа.

Гэхдээ бид захиргааныхаа ажилтны хүний нөөцийг тогтвортой ажиллахад чиглэсэн тодорхой мөнгө тавьж байгаа учраас түрүүн манай гишүүд хэлж байгаа нь биелэх боломжтой байх юм гээд.

Таны дараагийн асуусан нэг асуулт “ил тод байдал” гэдгээ юу гэж ойлгож байгаа юм бэ гэж байгаа.

Энэ бол өөрөө манай шүүх эрх мэдлийн бодлогын нэгд нь бид хэлж байгаа юм. Хүртээмжтэй байя, ил тод байя.

Ил тод байх бол ганцхан шүүхийн шийдвэрийг www.shuukh.mn гэсэн цахим хуудас дээр 500 гаруй шийдвэрийг нийтэлснээр төдийлөн бүрэн хангагдахгүй байна.

Энэ бол өөрөө том дэвшил байсан уу. Тийм. **Shuukh.mn** хамгийн өндөр хандалттай цахим хуудас. Тийм.

Яах вэ, энэ дээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофонд гүйцээгээд хариулах боломж өгье.

Н.Баасанжав: Тэгэхээр шүүхийн шийдвэрээс гадна “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал” гэж чухал юм байна гэдгийг бид ганц манайд ч биш бусад орны адилхан туршлага байна.

Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ил тод болохын тулд одоогоор бид хийчихсэн ажлууд байгаа. Цаашид гүнзгийрүүлэх хэрэгтэй.

Хийчихсэн ажил нь ганц шийдвэрээ ил тод тавиад байх биш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд болж байгаа процессыг шүүгчийг өөрийг нь тайлбарлаж тойм бич гэж байгаа юм.

Таслан сэргийлэх арга хэмжээ авчихсан. Тэгснээ буцаад цуцалчихсан, эсвэл цуцлахгүй байгаа.

Прокуророос нь үргэлжлүүл гээд байдаг. Шүүгч нь яачихсан юм бэ. Алга болчихсон юм шиг харагдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр **“процессын тойм”** гэж шүүгчид маань бичээд өөрийнхөө цахим хуудсуудад түүнийгээ тавьж байгаа. Одоо яг л нэг хуудас цаасанд энгийн, ойлгомжтой үг хэллэгээр

- таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгалаа,
- нэг сараар хорих боллоо,
- хилийн хориг тавилаа,
- хэн нэгэнтэй уулзах эрхгүй болголоо гээд.

Үүнийгээ яагаад. Яагаад ингэж шийдсэн юм бэ гэдгээ гол нь энгийн үг хэллэгээр. Нөгөө хуулийн тэдийн тэдийн тэд биш, аль болохоор энгийн үг хэллэгээр бичиж байгаа.

Шүүгчид энэ нь нэмэлт ачаалал өгч байгаа юу, өгч байгаа.

Үндсэн шийдвэрээ бичээд захирамжаа гаргахын хажуугаар дахиад тойм бичиж иргэдэд ойлгомжтой болгож байгаа.

Үүнийг нь нэмэлт ачаалал гэхгүй бид нарын ажлыг ойлгохгүй байгаа юм байна гэдгийг хийж байгаа.

Үүнийгээ бид илүү цааш нь сайн болгох гээд, илүү үүнийгээ ил тод болгох гээд Шүүхийн тухай хуулийн 12-т тодорхой өөрчлөлтүүдийг оруулж байгаа.

Яах вэ, Дээд шүүхийн шүүгчдээс бас энэ санаачилга илүүтэй гарсан. Түүний дагуу Шүүхийн тухай хуулийн 12 бол ил тод болохтой холбоотой.

Шүүх хуралдаан дээр чөлөөтэй ирж үз ээ.

Тэгэхээр нөгөө байр маань эргээд хөндөгдөөд байгаа юм. Ажиглагчаар чөлөөтэй ороо.

Ажиглагчаар орж чаддаггүй юм бол бид дамжуулья гэж байгаа юм. Шүүх хуралдааны зарим үйл явцыг.

Ялангуяа хяналтын шатын шүүх хуралдааныг дамжуулах бүрэн боломжтой байна. Түүн дээр тоног төхөөрөмж, нөгөө цахимжуулалтын асуудал маань яригдана.

Түүн дээр бид урт хугацаандаа 44.0 тэрбум төгрөгийг яг цахимжуулалттай холбоотой төлөвлөчихсөн байгаа чинь шүүх хуралдааны заал танхим маань хүнд аятайхан юм дамжуулчих хэмжээний тоноглогдож байж тэр чинь ойлгомжтой дамжуулагдана.

Тэгэхээр үүнийг бас бид хийж байна.

Мөн шүүхээр ирэхэд нь “**ШҮҮХИЙН ХӨТӨЧ**” гэдэг ч юм уу, тийм ажлын байруудыг бий болгож, нөгөө тайлбарладаг, ойлгуулдаг, тэгээд хэвлэл мэдээллийн гээд гэх мэт зүйлийг анхаарч байгаа.

Эцэст нь, сэтгэл зүйн үйлчилгээ гэдэг үнэхээр чухал.

Бид түүн дээр бас 4 гаруй тэрбум төгрөгийг сэтгэл зүйчтэй байх, сэтгэл зүйн үйлчилгээг авах гээд хэн нэгэнд ханддаг байх тэр соёл, тэр хандлагыг бас төлөвшүүлэх гээд байгаа юм. Тийшээ очих нь өөрөө энгийн зүйл гэдгийг бас шүүгч, тэр шүүхийн захиргааны ажилтандаа ч гэсэн бид ойлгуулах, хэвшүүлэх тийм байдлаар бодлогынхоо баримт бичгийг төлөвлөсөн байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Асуулт асуух гишүүд асуултаа асууж, хариултаа авлаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Ц.Сэргэлэн гишүүний микрофоныг.

Ц.Сэргэлэн: Баярлалаа.

Би ер нь үг хэлье ч гэж бодоогүй байсан юм. Сая энэ асуулт хариултын

явцад нэг асуудлыг сонсож байхад хэлэхээс өөр аргагүй нэг юм сонсогдлоо л доо.

Ер нь би дэмжиж байгаа. Энэ тогтоолын төсөл батлагдах ёстой. Үүнийг дэмжих ёстой.

Шүүхийн байгууллагын хараат бус байдлыг хангахад хамгийн их нөлөөтэй байдаг юм бол энэ төсөв хөрөнгийн асуудал байдаг. Ялангуяа хөрөнгө оруулалтын асуудлууд.

Ер нь шүүх өөрөө төрийн тусгай институцийн хувьд маш бие даасан, хэн ч халдашгүй, хараат бус л байх ёстой.

Тэгээд унаа гуйдаг. Магадгүй тэр шүүгдэж байгаа нөхрийнхөө унаанд дайгдаад шүүгч нь давхиж явдаг ч юм уу. Зүгээр би жишээ авч байгаа юм. Иймэрхүү байдлаар явахгүй.

Тэгэхээр бүх юм бүрэн хэмжээнд хангагдсан байх ёстой. Тэгж байж бид шүүхээс эцсийн үр дүн асуудаг, ярьдаг, шүүмжилдэг л байх ёстой. Ажиллах нөхцөл бололцоог нь дээд зэргээр хангаж өгөх ёстой гэж би хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр шүүхийн тухайн жилийн төсөв ороод ирэнгүүт янз бүрийн байдлаар хасаад байдаг л даа. Өнгөрсөн 4 жилийн байдлаас ингээд л харж байхад.

Тэгэхээр Улсын Их Хурлаас батлагдсан тогтоол, хөтөлбөр. Өөрөөр хэлбэл тэр төсвийг чинь батлах хамгийн гол эрх зүйн акт чинь болж өгнө.

Та нөхөд тэр Сангийн яам байдаг юм уу, Засгийн газар байдаг юм уу, Их Хурлын Байнгын хороо, Их Хурлын чуулган дээр төсвөө хамгаалах хамгийн

том баталгаа чинь болж өгнө. Хамгаалалт чинь болж өгнө. Үндэслэл чинь болж өгнө.

Энэ утгаар нь би шүүхийн хараат бус байдлыг дээшлүүлэхэд ач холбогдолтой гэдэг үүднээс нь дэмжиж байгаа юм. Нэг зүйл энэ.

Хоёрдугаарт, тэр цахим. Ерөөсөө л цахим шүүх л гэж яриад байна.

Цахим юмгүй юм байхгүй боллоо л доо. Нийгэм. Тэгэх ч ёстой л байх. Хүн төрөлхтний хөгжлийн үеийн байдлыг хараад үзэх юм бол цахим. Одоо хиймэл оюун ухаан гээд яриад явчихна.

Тэгвэл цахимын чинь эсрэг талд нэг юм байгаа юм. Энэ кибер аюулгүй байдал гэдэг юм.

Шүүх гэдэг өөрөө юу юм бэ гэхээр энэ гэмт хэргийн хамгийн эцсийн байдлаар тогтоосон нотлох баримтууд дээр үндэслэж эцсийн шийдвэр гаргадаг энэ процессууд. Энэ болгон чинь цахимд байх юм бол та нөхдүүд минь хэзээ нэгэн цагт тэр аюултай хакеруудын дайралтад өртөж хэрэг чинь байхгүй болчихсон байхад байг л гэхгүй болно.

“Хакер” гэдэг бол одоо хэнд ч дийлдэхээ байчихлаа. Одоо Америкийн Нэгдсэн Улсын Пентагон гэдэг бол хамгийн өндөр хамгаалалттай байгууллага. Гэтэл хакерын дайралтад байнга өртөж байна шүү дээ.

Би өөрөө насаараа төрийн тусгай албанд ажилласан хүн. Энэ кибер аюулгүй байдлын чиглэлээр бас ч үгүй нэлээн мэргэшчихсэн хүн.

Одоо бид цахим байх юм бол ядаж энэ хавтаст хэргийг цаасан суурьтай байлгахгаар нь хадгалах ёстой. Архивт цаасан сууриар нь.

Ц.Сэргэлэнгийн гарын үсгээр бичсэн бичмэлийн бичгийн хэв нь нотлох баримт болох ёстой. Энэ хэвээрээ хадгалагдах ёстой. Мөнхөд Монгол Улсын төр гэж л байгаа цагт энэ хавтаст хэрэг цаасан суурьтайгаа хадгалагдаж байх ёстой.

Одоо энэ дуулиант хэргүүд гэж бид нар яриад байдаг.

Дээрээс нь гэмт хэрэг зохион байгуулалттай хэлбэрт улам бүр шилжиж байна. Асар их мөнгөний оролцоотой болж байна.

Энэ этгээдүүд өөрсдийнхөө хэргийг баллах, нотлох баримтаа нуух, таслах, байхгүй болгох, устгах энэ чиглэлээр тэр мөнгийг бол хайр найргүй цацаж байна шүү дээ.

Тэгэхэд энэ хакеруудад асар их мөнгө төлөөд л тэрийг чинь хийчихнэ.

Би яагаад үүнийг хэлээд байгаа юм гэхээр өнөөдөр Монгол Улсын төрд өөрт нь маш сайн программист инженерүүд байхгүй. Бид төрийн албан хаагчтай ижил нөхцөлөөр цалинжуулж байгаа. Чадвартай программист инженерүүд бүгд хувийн салбар луу яваад өгсөн.

Тэгэхээр одоо яаж байна вэ гэхээр төрийн байгууллагууд хувийн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж программа зохиолгож байгаа шүү дээ.

Программ чинь хувьд байна гэдэг чинь та бүхний бүх юм тэр хувийн нөхрийн гарт байна гэсэн үг. Тэрэнд хэн

ч халдаж чадахгүй. Тэр нөхрийн толгой дотор цоожлоотой явж байгаа юм.

Тэр баталгаа байхгүй. Хувийн программист. Төрийнх байсан ч бас хэцүү.

Тэгэхээр шүүхийн, ялангуяа энэ гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой процессын асуудлуудыг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сэргэлэн гишүүний микрофоныг нэмж өгье.

Ц.Сэргэлэн: Саяын миний хэлсэн зүйлүүдийг цахим болгосон тохиолдолд энэ хамгаалалтаас гадна зөвхөн шүүх өөртөө зориулж хамгийн өндөр зэрэглэлд баталгаатай хийгдсэн программ дээр л явахгүй бол энэ эргээд миний түрүүний хэлдэг эрсдэл учирна шүү.

Тийм учраас ний нуугүй хэлэхэд хэргийн хавтаст хэрэг бол ер нь цаасанд хүртээгээд л байх ёстой л гэдгийг л би юм хэлэх гээд байгаа юм.

Дээрээс нь л энэ программистуудын асуудал.

Одоо цахимын 3 хууль батлагдсан. Энэ Их Хурал баталсан. Би энэ 3 хуулийн ажлын хэсэгт орж ажилласан хүн.

Их олон удаа хэлсэн, ярьсан, санал ч гаргаж үзсэн. Дийлэхгүй л байна лээ. Дийлэхгүйдээ ч гол нь биш. Бодит байдал тийм болчихоод байгаа юм.

Яагаад гэхээр маш өндөр чадвартай программистууд яадаг вэ гэхээр 5, 6 залуучууд нийлээд хувийн компани байгуулаад нийлэнгүүтээ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүн. Микрофоныг нь өгье.

Б.Энх-Амгалан: “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг би гишүүдийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа юм.

Яагаад тэгж байна гэхээр одоо ингээд олон жил явчихсан. Заавал ингээд нэг яарсан, даарсан, морин дэл дээр гарчихсан, сонгуульд явах гээд ингээд догдолчихсон үед нь үүнийг оруулж ирэх хэрэггүй. Тогтвортой суурьтай үзэж байгаад дараагийн парламентыг нь шийдэг. юм байж болохгүй байгаа юм л даа.

Энэ бодлогын бичиг баримт алдаатай, оноотой ч байж магадгүй. Тэгэхдээ үүнийгээ заавал энэ Их Хурлаар баталж авахгүй бол энэ 75.9 тэрбум төгрөгийн чинь нөгөө 25.0 тэрбум чинь гарахгүй. Намрын чуулганаар дахиад асуудал орно.

Тэгээд төсөв нэмэгдээд 2024 ондоо батлагдах уу, үгүй юу гэдэг хэцүү.

Тэгэхээр энэ чинь одоо Их Хурлын тогтоол болоод гарчихвал дараа нь Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гээд Засгийн газраа шахаад оруулаад авах бололцоотой байхгүй юу.

Тийм учраас энэ асуудлыг заавал дэмжих цаг хугацааны хөшүүрэг, шаардлага байгаа юм.

Тэгэхээр үүнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт нь, би юу хүсэх гээд байна гэхээр та бүхэн маань шүүхийн ажилтан, албан хаагч, шүүгч нарынхаа хүнээ бодох хэрэгтэй байгаа юм. Хүнээ хамгийн түрүүнд тавих хэрэгтэй. Тэд нарыгаа сургах, дадлагажуулах, албандаа итгэх итгэлийг нь бэхжүүлэх, дахин сургах, соён гэгээрүүлэх.

Энэ хүн гэдэг юм руугаа жоохон явахгүй бол эд нар чинь би одоо ингээд гараад нэг юм яачихвал тэгээд унана даа, ингээд унана даа гэдэг нэг айдсаасаа болоод нийгэмд нэг тусгаарлагдмал шинжтэй болчих гээд байгаа юм ажиглагдаад байгаа учраас хүнээ их сайн бодох хэрэгтэй байна гэж байгаа юм.

Хүнээ, боловсон хүчнийхээ асуудлыг шийдээд, тэгээд тэр хүмүүс нь эдийн засгийн баталгаа нь хангагдаад, хараат бус байгаад, албандаа итгэх итгэлтэй байгаад, цалин хөлс, нийгмийн хангамж нь хангалттай байгаад эхэлбэл дараагийн асуудал нь нийгмийн баталгаа л болж эхэлж байгаа юм.

Энэ ажиллах орчин нөхцөл гэдэг юм бид зөвхөн өнөөдөр байр савны тухай асуудал ярьж байгаа боловч сая гишүүдийн хэлээд байгаа тэр ажиллах нөхцөл, программ хангамж, техник хэрэгсэл энэ юмнууд.

Яг нарийндаа яривал та хэд сая Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлээр ингээд дамжуулъя гэж байгаа. Ирж үз гэж байгаа гээд л тэгдэг. Яг нарийндаа бичлэгээ ч авч чадахгүй юм билээ.

Тэр стандартынх нь шаардлага хангахгүй, дүрс муутай. Тэгээд л тэр сонсогдсон, сонсогдоогүй, юу ярьсан нь бүү мэд. Ингэсээр байгаад нөгөө юм чинь бүрдэхээ байчаж байгаа юм.

Тэгээд л нэг түмэн хавтас юм хараад л, үзээд л байдаг, үзээд л байдаг. Нөгөөх нь тэгээд эргээд хүний хувь заяа шийдэхэд буруугаар нөлөөлөх нөхцөл байдал болох учраас энэ өөрөө заавал хэрэгжиж байх ёстой ажил байна.

Хоёр дахь нь, эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаа, ажиллах орчны асуудал.

Гурав дахь нь, ёстой нөгөө бид нарын хэлээд байгаа тэр ил тод, нээлттэй байдаг асуудал нь явчих юм бол шүүхэд итгэх итгэл бий болно. Харин үүнийг бий болгохын тулд Монголын төр өөрөө энэ дээр санаачилга гаргаж, энэ төсөв мөнгийг нь баталж өгч ингэж явахгүй бол болохгүй байгаа учраас энэ асуудлыг маш яаралтай хийх хэрэгтэй гэж үзэж байгаа юм.

Би хоёрхон юм уншиж өгсөн. Эдийн засгийн баталгаа хангагдахгүй байгаагаас гэдэг юм 67.1 хувь, шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл гарч байна гэдэг юм 62.5 хувь.

Тэр нь нөгөө шүүхийн байр сав, нөгөө нөхцөл байдлаасаа болоод. Тэнд чинь 6 хүн ороод суух ч зайгүй юм билээ шүү дээ.

Ийм нөхцөл байдлууд байгаа учраас энэ юмнуудыг нэлээн сайн харж хийх нь цаашдаа Монгол Улсын шүүхэд итгэх ард түмний итгэлийг бий болгоход их хэрэгтэй болно гэж үзэж байгаа. Өөр юмгүй ээ.

Д.Цогтбаатар: Г.Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Баярлалаа.

Монгол Улсын шүүхийн эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай энэхүү баримт бичгийг гишүүд дэмжээсэй гэж би хүсэж байгаа.

Яагаад гэхээр манай шүүхийн институт гүн хямралд орсон гэж би хараад байна л даа. Олон жил хөрөнгө оруулалтаас гадна орхигдсон. Боловсон хүчний хөгжил нь хаягдсан.

Ингээд хараад байхад ер нь хөгжсөн орнуудад шүүгчийн албан тушаал карьер бол хамгийн нэр хүндтэй. Хууль, эрх зүйн салбарт карьераа эхлүүлж байгаа хүмүүс шүүгч болох юмсан гэж мөрөөддөг. Хаана ч явсан шүүгч гэдэг албан тушаалтай хүн шүүгч хийж байгаад тэтгэвэрт гарсан хүн нэр хүндтэй явдаг тийм албан тушаал, тийм мэргэжилтэй.

Тэгэхээр бид энэ шүүхийн институтээ буцаад нэр хүндийг нь өсгөж, ажиллах тэр нөхцөлийг нь хангаж өгөх заавал шаардлагатай.

Тэгээд энэ баримт бичгийн гол агуулга нь ерөөсөө л хамгийн наад захын дэд бүтэц, байшин барилга, тоног төхөөрөмж, ажлын нөхцөлийг нь сайжруулах асуудал байгаа юм.

Яагаад энэ асуудлыг яаравчлан шийдэх гээд байгаа юм бэ. Энэ нөгөө 2025 оны улсын төсөвтэй холбоотой процесс нь эхэлчихсэн байгаа болохоор бид энэ бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахын тулд 2025 оны төсөвт заавал суулгах ёстой тийм асуудлууд байгаа.

Би одоо энэ Шүүх байгуулах тухай хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллаж байгаа гишүүний хувьд энэ баримт бичиг болон тэр ажлын хэсгээс

гаргах саналууд бас уялдаатай юм гэдгийг хэлье.

Тийм болохоор шүүгчдийн хараат бус байдал, улс төрөөс хараат бус бие даасан байх гэдгийг байнга шаарддаг. Нэр хүндийг нь янз бүрээр хэлж ярьдаг боловч ер нь тэгэхдээ бид энэ шүүгчдийнхээ ажиллаж байгаа нөхцөл байдлыг харах л ёстой юм билээ.

Хан-Уул дүүргийн шүүх ч юм уу, зарим шүүхийн байшин барилгаар нь ороод үзээрэй. Үнэхээр тэнд яаж ажиллаж байгаа юм бэ гэмээр, нүд халтирмаар тийм нөхцөлд л ажилладаг юм билээ шүү.

Тийм болохоор гишүүд маань энэ оруулж ирж байгаа асуудлыг сайн дэмжээд өгөөрэй. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Би саналаа хэлье.

Дунд хугацааны хөтөлбөр юм чинь би ер нь энэ шүүхийг ил тод нээлттэй байлгах хүрээнд дунд хугацааныхаа хөтөлбөрт шүүх ер нь өөрийн бие даасан телевиз, телевизийн сувагтай байвал яадаг юм бол. Та бүхэн бас судалж үзээч гэсэн саналыг хэлэх гэж байгаа юм.

Яах вэ, зарим нэг нь юу, өөрсдөө суух орон байргүй байж байхад юу билээ гэх байх.

Гол нь иргэдэд ил тод, нээлттэй байх, шүүх хуралдаануудыг цаашдаа ер нь ил тод байх, шууд дамжуулдаг байх, шүүгчийн хараат бусаар ажиллаж байгаа, шударгаар шийдвэрээ гаргаж байгаа эсэхийг, шүүх хуралдаануудыг шуудаар нэвтрүүлдэг байх.

Анхаарал татсан томоохон хэргүүдийг шуудаар дамжуулдаг байх. Энэ тал дээр дунд хугацааны хөтөлбөртэй өөрийн гэсэн телевизтэй байвал яасан юм бэ гэдэг саналыг бас оруулж үзэж та нар хэлэлцвэл яасан юм бэ гэсэн нэг санал байна. Нэгд.

Хоёрт, бид шүүх, шүүгч гээд ярихаар нэг их аймаар ингээд тасарчихсан, иргэдээсээ хол хөндий болчихсон. Вакумжаад.

Ойрхон байж байж, уялдаа холбоотой харилцаатай байж л бие биедээ итгэлцэл төрнө.

Хол хөндий байх тусмаа л мэдээллийн суваг буруу явна. Нээлттэй биш байдалтай болно.

Та бүхэн хараарай. Энэ зурагт телевизээр спортын сувгууд хөтлөгчтэй, сайн тайлбарлагчтай байж байж л тэр нэвтрүүлэг, тэр спорт гоё үзэж байгаа биз дээ. Кайфтай үзэж байгаа юм. Ойлгож байгаа юм.

Яг түүнтэй адилхан шүүх хуралдааны, шүүхийн процедурыг яг хөтлөгчтэй. Түрүүн миний асуултад хариулж байгаа хүний хариултад **“хөтлөгч”** гэдэг үг гарч ирж байна лээ.

Энэ бүх процедурууд хөтлөгчтэй, тайлбарлагчтай явж байж тэр шүүхийн талаар огт мэдлэггүй, мэдээлэлгүй хүмүүст ямар шатдаа явж байгаа юм, шүүгч яагаад хорих шийдвэр гаргасан юм, яагаад таслан сэргийлэх арга хэмжээг авсан юм, яагаад шийдвэр гарсан юм гэдгийг цаг тухай бүрд нь хөтөлдөг, тайлбарладаг, зөвөөр ойлгуулдаг.

Тэгэхгүй бол одоо сүүлийн үед өмгөөлөгч нар. Ихэнх нь биш л дээ. Зүгээр мөнгөний хойноос болчихсон.

Ерөөсөө л шүүгчийн талаар гарсан шийдвэрийг үнэн зөв ойлгуулдаг ч юм уу, үгүй ч юм уу.

Тийм учраас шүүхийн процедуруудын асуудлыг хөтлөгчтэй, тайлбарлагчтай явуулдаг байх, мэдээллийг өгдөг байх тийм бүтэц, орон тооны асуудлуудыг хүртэл энэ дунд хугацааны хөтөлбөртөө оруулж явбал бас шүүхийн үйл ажиллагаа чинь нээлттэй байх, иргэнд зөвөөр ойлгогддог байх, эргээд итгэдэг байх энэ байдалд бас тус нэмэр болох юм болов уу л гэсэн хоёр санал байна. Надад. Тийм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ер нь тэр 75.0 тэрбум төгрөг энэ тэр бол аягүй бага мөнгө өө.

Одоо шүүхийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулаад харахад. Шүүх чинь уг нь засаглал биз дээ. Одоо энэ улс орны тулгын гурван чулууны нэг нь л гээд байгаа юм л даа.

Тэгээд хараат бус ажиллах энэ бүх юм бол одоо энэ Монгол Ардын намын үед үнэхээр хүнд болчихоод байгаа юм. Ерөөсөө хуучин яг Монгол Ардын намын тэр коммунистуудын хурал шүүх байгууллагыг орлодог үеийн сэтгэлгээ нь тэр чигээрээ хоцорчихсон. Үлдчихсэн.

Ингээд харж байхад шүүх болон шүүгчид хүндэтгэлтэй хандах хуулийн зүйл, заалттай л даа.

Тэгээд энэ хуулийн зүйл, заалтыг хэрэгжүүлж байгаа, энэ шүүгч нарынхаа өмнөөс дуугарч байгаа, хэлэх ёстой Шүүхийн ерөнхий зөвлөл тэр үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг юм уу, хэрэгжүүлдэггүй юм уу.

Шүүх чинь өөрөө дураараа энд тэнд гарч ирээд яриад байх боломжгүй л дээ.

Тэгэхээр Та бүхэн хэлж дуугарч байх ёстой.

Би бас ойлгохгүй байгаа юм. Одоогийн энэ Монгол Ардын намын удирдлага дуртай үедээ гарч ирээд л одоо яах нь вэ, шударга ёсыг тогтооё, энэ шүүхийг харья гэж байгаа байхгүй юу. Ингэж болдог юм уу. Энэ чинь нөлөөлж байгаа хэлбэр нь биш юм уу.

Нөгөө талаар манай сумдаар явахад улаан булангууд ч байхгүй. Больчихсон л доо. Шүүхийн байр энэ тэр бол сүүлийн 4 жил би байнга шүүхээр явлаа.

Хүний эрхийг байнга зөрчиж байгаа. Сэргээж байгаа юм ерөөсөө алга.

Тэгээд тэр хаалга үүд энэ тэр бол шал өөр байх ёстой шүү дээ. Байшин барилга, зориулалт энэ тэр бол. Тэгээд хэрэгтэн, өмгөөлөгч, шүүгч бүгдээрээ л нэг хаалгаар сугараад байна. байж болохгүй л дээ.

Энэ ардчилсан Үндсэн хуультай улс оронд тэр стандартыг хэрэгжүүлж байгаа юм алга.

Хан-Уулын шүүх гээд л дурдлаа. Яг социализмын үеийн манаачийн путкинд байгаа юм шиг байгаа байхгүй юу.

Тэрийг тойроод л одоо энэ Хууль зүйн яам, энэ прокурор, энэ Тагнуулын ерөнхий газрууд том том байшингуудтай. Орд харшид суудаг.

Гэтэл шүүх л байдалтай байдаг.

Шүүх яг жинхэнэ тэр Үндсэн хуульд заасныхаа дагуу хэдийд байж чадах вэ гэхээр ардчилал гараад ирсэн үед л арай дээр байдаг.

- Манай Н.Алтанхуяг дарга Ерөнхий сайд байхад,
- манай Х.Тэмүүжин Хууль зүйн сайд байхад,
- би Хууль зүйн байнгын хорооны дарга байхад,
- нөгөө Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж байхад

- шүүхийн цалин нэмлээ,
- хараат бус байдал нь сайжирлаа,
- Шүүхийн тухай хууль шинэчлэгдлээ,
- Шүүхийн ерөнхий зөвлөлийг байгуулж өглөө.

Ийм зүйлүүд ингээд явдаг.

Гэтэл дараа нь яаж байна. Сүүлийн 8 жилд.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл шууд хуралдаад шүүгч нарыг томилдог болчихсон. Тийм муухай хуультай байлаа шүү дээ. Энэ ардчилсан улс оронд.

Тэгээд дараа нь тэрийгээ цуцлав уу, яав.

Тэгээд энэ талаар хэлдэг, ярьдаг хүн ерөөсөө байхгүй. Ингэж болдоггүй юм гэж.

Одоо энэ Улсын Их Хурал бол бараг 70, 80 хувь нь эрэгтэйчүүл байна. Бид тэгээд сая сонгуулийн хуулиа жендэрийн нөхцөл байдлыг тусгалаа л даа.

Энд шүүх, шүүхийн байгууллагуудад бас жендэрийн асуудлыг ярих хэрэгтэй. Эрэгтэй шүүгч нар гэж бараг байхгүй. Иймэрхүү нөхцөл байдалтай байгаа юм.

Тэгээд ямар ч байсан энэ тогтоолыг батлаад ингээд явуулах хэрэгтэй.

Тэр **“Тахарын алба”** гэж байсан. Ардын нам гарч ирэнгүүтээ л татан буулгачихна.

Одоо энэ тусгай субъектийн асуудлыг Авлигатай тэмцэх газар хариуцаж байгаа. Бүрэн хонгил угсрах боломжтой. Байнга Монгол Ардын намын олонх, энэ Засгийн газрын дарамтад л байгаа шүү дээ. Шүүгч нар бол. Шүүхийн байгууллага.

Үүнийг засаж янзалж их олон ажил хийх хэрэгтэй л дээ.

Тэгээд ямар ч байсан энэ тогтоолыг батлаад, ингээд хэрэгжих боломжийг нь хангаад явах нь зүйтэй л гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би энэ Шүүхийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан.

Сая Д.Ганбат гишүүний хөндөж байгаа дээр тодруулга хийх хэрэгтэй.

2014 оноос хойш шүүхэд хөрөнгө оруулалт **“ТЭГ”** байсан байхгүй юу. 2014 онд таныг гишүүн байх үед.

Тэгээд сая 2020 онд гарч ирсэн Улсын Их Хурлын хамгийн эхний зун Хууль зүйн сайдаар ажиллаж байгаа Б.Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч болоод.

Бараг ажлын хэсгийн ахлагч болгох гэж бид нэг сар дотооддоо дайн шиг юм болсон шүү дээ. Шүүхийн хуулийн ажлын хэсгийн ахлагчийг тавихгүй гээд.

Тэгээд энэ дээр би ажлын хэсгийн гишүүнээр орсон. Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг гишүүн гээд байж байна.

Бид харин сүүлийн хэдэн жилд шүүхийн хөрөнгө оруулалтын асуудал, шүүхийн биеэ даасан байдал, **Шүүхийн сахилгын хороо**, **Шүүхийн ерөнхий зөвлөл** гээд бүгдийг нь шийдэж өгч байгаа.

Энэ урьд нь шийдэгдээгүй шүү. Харин жинхэнээс бодитойгоор.

Тэгээд анх удаа Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн шүүхэд очсон чинь Их Хурлын гишүүд анх удаа ирлээ гэсэн шүү дээ. Тийм. Анх удаа.

Дараа нь Хан-Уулд хүмүүс очсон байх.

Ер нь тэгээд шүүхийн хаалга татсан хамгийн олон гишүүнтэй Их Хурал гээд яригдаад байгаа. Бас яах вэ, муу юманд сайн юм байна.

Жишээлбэл, очоод үзэхэд хурал хийх заал байхгүй. Сая Соёлын төв

өргөөнд нэг өмнөх шүүх хурал болсон шүү дээ.

Тэгээд энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр бүхэл бүтэн улс шүүхийн хуралдаанаа хийх тийм нөхцөл, томоохон хэмжээний оролцогчтой тийм байр байхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр энэ нам гэхгүй ер нь энэ удаагийн Улсын Их Хурлын шүүх дээр бид анхаарал хандуулж байгаа. Зүгээр анхаармаар юм бол бий.

Хуучин ярьж байсан. Тэр **“компанийн шүүгч”** гэдэг юм.

Тэр анхан шат, дунд шат, дээд шатанд **“компанийн шүүгч”** нар байгаа гэсэн яриа одоо ч байна, **“улс төрчдийн шүүгч”** нар байгаа гэсэн яриа одоо ч байна.

Дээр нь жишээлбэл тодорхой хүмүүсийн нэртэй шүүгч нар ч байгаа.

- **“Хурцын шүүгч”**,
- **“Хурцын өмгөөлөгч”**,
- **“Хурцын прокурор”**,
- **“Хурцын мөрдөгч”** гээд.

Тэр яриа хүртэл арилаагүй л байгаа.

Тэгэхдээ яах вэ энэ асуудал шүүхийн хөгжлийн бодлогын 2000 оны стратеги төлөвлөгөөнөөс хойш анх удаа гарч байгаа.

Зүгээр тэр дүгнэж байгаа юмнуудыг би урьд нь уншиж байсан.

Нэг их өндөр хувьтай дүгнэсэн, 80, 90 хувь нь биелсэн гээд. Тэр худлаа байх.

Яагаад гэвэл Улсын Их Хурал сая сүүлийн 4 жилийн хугацаанд.

Энэ удаагийнх КОВИД-той байсан ч гэсэн бид шүүхийн чиглэлээр ажилласан.

Зүгээр нэг асуудал бий. Тодорхой хэмжээний шахалт шаардлага, дарамтууд бол тодорхой хэмжээнд байгааг мэдэж байгаа.

Би хувь гишүүний хувьд, та хэд ч гэсэн энд байж байгаа улсуудад хэлэхэд Засгийн газарт байхдаа ч хэлж байсан.

Шүүх эрх мэдэлтэй ноцолдсон ямар ч дарга, албан тушаалтан түүхэндээ дийлж байсан тохиолдол байхгүй.

Үүнийг шударгаар бас хэлэх хэрэгтэй. Султан хаан ч гэсэн шүүгч нараа солих гэж оролдоод тэгж болж байгаагүй.

Зүгээр нэг асуудал бий. Пакистан ч гэсэн Дээд шүүхийн шүүгч нар нь бас ажил хаялт зарлаад л явж байсан юм бий. Дарангуйлагч гээд байгаа улсад.

Тэгэхээр **“шүүх эрх мэдэл”** бол их зөв харилцах ёстой.

“Хууль тогтоох”, “гүйцэтгэх” эрх мэдлийн хэмжээнд өөрөө орж ирсэн үү гэвэл бас худлаа.

Монгол Улс **“шүүх эрх мэдэл”** нь **“хууль тогтоох”**, **“гүйцэтгэх”** эрх мэдлийнхээ баланс руугаа яг орж ирээгүй.

Зүгээр ажил хийгдэж байгаа. Одоо бол улс төрчдийн нөлөөллөөс алга болгох тухай бид их ярьчихсан.

Нэг юм дутуу байгаа. Дотоод.

Одоо жишээлбэл “Шүүхийн сахилгын хороо” ямар дарамт үзүүлж байна. Судалж үзэх ёстой. “Авлигатай тэмцэх газар” ямар дарамт үзүүлж байна. Судалж үзэх ёстой.

Шүүгч нар бас дарамтад байгаад байна гэж яриад байна шүү дээ. Бас сонсогдоод байна.

Тэгээд ер нь Монгол Улс чинь 500 гаруй шүүгчтэй гээд л. Одоо орон тоо нэмнэ гэж байна.

Орон тоо байгаад байгаад нөгөө орон байрнаасаа шалтгаалаад л хүн нэмж авч чадахгүй л байсан шүү дээ. Саяхан.

Тэгэхээр ер нь тэр орон байрыг яах вэ, Н.Алтанхуяг гишүүний үед нэг том байр барина гэж эхлүүлээд л тэгээд л дараагийнх нь хаячихсан юм бол байгаа.

Сүүлд Хууль зүйн сайд, Ерөнхийлөгч нар шүүхийн байр сав гээд бас яриад явж байгаа гэж би ойлгож байгаа.

Эхлээд шүүхийнхээ нэг орон байрны асуудлыг шийдье. Шүүгч нар луу их буруутгаад. Төр улсын оршин тогтнох суурь нь өөрөө “шүүх эрх мэдэл” байхгүй юу.

Шүүх гэдэг бол одоо энэ улсын өөрийнх нь. Шүүхийг хэт шүүмжлэх, шүүх рүү хэт халдан довтлох явдал бол өөрийгөө төр улсыг сулруулах аюултай.

Тэгэхдээ ялгаж харин тодорхой тодорхой шүүгч нартай хариуцлага тооцох, зарим нь бараг цэвэрлэгээ хийх юм яриад байгаа. Маш

болгоомжтойгоор хууль зүйн хүрээнд хийгдэх ёстой.

Миний хамгийн их санаа зовж байгаа юм бол “Шүүхийн сахилгын хороо” Авлигатай тэмцэх газрын шүүхэд үзүүлж байгаа нөлөөллийг судлах шаардлагатай. Судлах шаардлагатай.

Тэгээд ер нь гар хөл болоод байгаа тодорхой хүмүүсээс болж энэ асуудлууд үүсээд байгаа.

Тэгэхдээ үүнийг нэг юмнаас салгах ёстой. Шүүхийг бэхжүүлэх асуудлыг сөргүүлж тавьж болохгүй. Зарим нь цалин цавуу хасна барина ч гэж байх шиг. Ачаалал нь хэт ихэсчихсэн байхгүй юу даа. Маш их ачаалалтай ажиллаж байгаа. Мөрдөгч нар, энэ шүүгч нар.

Тэгээд асуудлын утгаар үүнийг баталж өгөөд дараагийнхаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Баярлалаа. Энэ дээр би бас хоёр үг нэмээд хэлчихье гэж бодож байна.

Би түрүүн хэлсэн. Энэ аль хэдийн хийгдэх ёстой юм. Харин ч бүр оройтоод явж байгаа.

Гэхдээ энэ ажлуудыг манай Их Хурал анхааралтай авч үзэж үнэхээр явуулж байгаа шүү.

Одоо би бол 12 сард л болсон. Тэгэхэд 10 сард өргөн баригдсан. Б.Энхбаяр сайд Байнгын хорооны дарга байхдаа үүнийг аль хэдийн эхлүүлчихсэн явж байгаа ажил.

Энэ ингээд гацахгүй яваад үр дүндээ хүрэх ёстой.

Гэхдээ гишүүдийн хэлээд байгаа нэг зүйлийг анхаараарай.

Нэг л цаас гаргаад, тэгээд тэр цаас нь зөвхөн хөрөнгө мөнгө, ажлын нөхцөл гээд тэрийг хүмүүс зөндөө ойлгоод ярьсны ард ажлын үр дүн л гарах ёстой шүү.

Түүнээс энд би гишүүддээ бас нэг юманд талархаж байна.

Ер нь Ордонд шүүхийг илүү буруутгах талдаа, аль болох шүүмжлэх талдаа л яриад байдаг байхад харин энд Хууль зүйн байнгын хороо асуудлаа мэдэж байгаа гишүүд сууж байна.

Тийм учраас та нарын зовлон жаргалыг сайн ойлгож, энд хэлэх үгнүүдээ бас хэлж байна. Танайд зөндөө дутагдал байгаа.

Түүний хажуугаар энэ дээр чинь шударга, зарчимч хандах ёстой. Энэ төрийн гол тулгуур гурван баганын ерөөсөө нэг. Энэ багана зогсоогүй байхад бусад багана тогтвортой зогсоно гэж угаасаа ойлголт байхгүй.

Тэгэхээр энэ дээр та нарыг дэмжих талдаа, бэхжүүлэх талдаа үг хэлж байна. Энд би талархаж байна.

Гол нь эцсийн дүндээ ажлын үр дүн шүү л гээд гишүүд хэлээд байна шүү дээ. Үүнийг л та нар сайн анхаараарай.

Сая гишүүд харин нэг зүйл хэлээд байна. Энэ шүүхийн ил тод байдалтай холбогдуулаад үг хэлж байна.

Яг энэ хууль санаачлагдаад явж байна. Шүүх хуралдааныг илүү ил тод

байлгах. Энэ бол бүр суурь зарчим. Угаасаа л байж байгаа шүү дээ.

Тэгэхдээ процессын хуулиудаараа энэ нэлээн хаагдчихсан.

Яг энэ зарчмаараа явахад хүндрэл гараад байгаа.

Үүнтэй холбогдсон хуулийн өөрчлөлтүүдийг Хууль зүйн сайдтай ярьж байгаад төсөл бэлэн болчихсон. Одоо ингээд өргөн барих гэж байгаа.

Тэгэхээр үүний бас нэг гол үр дүн бол нөгөө шүүхэд ард иргэдийн итгэх итгэлийг бэхжүүлж өгөхөд шүүхийнхээ ил тод байдлыг ямар ч эргэлзээгүй баталгаажуулж авах нь маш чухал.

Энэ ажил хийгдэнэ. Хуулийн төслийг би өөрөө санаачилж өргөн барина гээд явж байгаа. Үүнийг дурдаж хэлэх гэсэн юм.

Ингээд үг хэлэх гишүүд үгээ хэлж дууслаа.

“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

91.0 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй.

Тийм учраас би нэг санал дэвшүүлэх гэсэн юм. Юу гэвэл үүнийг ерөөсөө анхны хэлэлцүүлгээрээ батлаад явчихъя гэсэн санал гаргаж байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна.

Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

“Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.

Хоёр.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хоёрдугаар асуудал. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Материалыг гишүүдэд тараасан байгаа.

Тэгээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Та бүгд өөрсдөө харцгаачихсан байж байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Эцсийн хэлэлцүүлэг юм чинь. Д.Ганбат гишүүнээр тасалъя.

Би ажлын хэсгийг танилцуулчихъя. Г.Төгөлдөр Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга.

Д.Ганбат гишүүн нэрээ татаж байна. Н.Алтанхуяг гишүүнд микрофоныг нь өгье.

Н.Алтанхуяг: Гишүүд энэ, би бол хугацаагүй болж байгаа гэж ойлгож байгаа. Зөв үү? Тийм.

Энэ хэлмэгдүүлэлтийн асуудал дээр ер нь хугацаа тавьдаг бол буруу юм гэсэн.

Тэгэхээр энэ маань түүгээрээ гарч байгаа юм байна.

Дээр би бас Их Хурал дээр ярьсан. С.Одонтуяа ч гишүүн ч гэсэн хариулт өгсөн.

Одоо энэ хууль тогтоомжоо жаахан шинэчилмээр байна шүү дээ. Тийм ээ.

Та бол ингээд Солонгост нэг хэлмэгдүүлэлтийн ерөнхий шинжтэй хууль баталчхаад тухайн тухайн кэйс дээр нь дахиж хууль гаргаж цагаатгана гэх юм уу, нөхөн олговор өгнө гэх юм уу ингэж ярьдаг юм байна лээ.

Тэр ер нь хийгдэнэ биз дээ? Тэр дагуу энэ батлагдаж байгаатай холбоотой, энэ хуульд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор тогтоол гарч байгаа юу, гарахгүй байгаа юу?

Уг нь бид нарын тэр нэг яриад байсан юмыг Их Хурлын тогтоол болгоод оруулчихвал дээр юм.

Ер нь энэ хэлмэгдүүлэлтийн асуудал чинь би нэг ярьсан шүү дээ.

1990 оноор дуусчихсан юм биш ээ. 1990 оноос хойших энэ хэлмэгдүүлэлт шинэ үеийн гэх юм уу, шинэ маягийн гэх юм уу.

Одоо энэ асуудлыг бид авч үзэхгүй бол болохгүй юм байна лээ.

Та ахалж байгаа юм чинь энэ дээр би заавал зэрэгцүүлээд яах вэ.

Ер нь болохгүй бол тийм нэг тогтоол гаргуулж авсан нь дээр байх шүү гэдэг санал хэлж байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Н.Алтанхуяг гишүүний яг хэлж байгаа санааг би маш олон удаа ярьж байгаа.

Н.Алтанхуяг гишүүн ээ, яг танай нам. Би сөрөг хүчин учраас танай намын гишүүдэд хандаж би санал тавиад байгаа шүү дээ.

Юу гэвэл тэр хилс хэрэгт хүмүүсийг гүтгэж хохироосон хүмүүсийг бид орхичхоод байгаа байхгүй юу.

Одоо тэрийг Эрүүгийн хуульд бүр тусгай зүйл анги оруулж ирээд.

Энэ чинь авлига авсан хүнд 20 жил хүртэл ял өгөөд байна шүү дээ.

Тэгэхэд хүнийг хилс хэрэгт гүтгээд тэр шийтгүүлчхэж байгаа хүмүүсийг тэр хэмжээнд ял шийтгэл эдлүүлдэг байх ёстой.

Яагаад гэвэл энэ чинь ноцтой гэмт хэрэг бөгөөд энэ гэмт хэргийн цаад агуулга ихэнхдээ юу байдаг гэхээр хууль бусаар төрийн эрхийг авах оролдлого шүү дээ. Энэ чинь.

Өөрсдийнхөө өрсөлдөгчдийг намнаад, өрсөлдөгчгүй болж байгаад орж ирнэ гэдэг чинь төрийн том гэмт хэрэг байхгүй юу.

Тэгэхээр ял нь том байх ёстой. Тэгээд хуулийг та нар санаачлаад оруулаад ирээч ээ. Би дэмжээд өгье гээд яриад байгаа нь энэ шүү дээ. Би олон удаа энэ асуудлыг тавьж байгаа.

Тэгэхээр та нар бүлэг дээрээ ярьж байгаад нэг хууль санаачлаад оруулаад ирээч.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн

хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн

Дараагийн асуудалдаа орёе.

Гурав. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Б.Солонгоо Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Г.Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Н.Ганбагана Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн, М.Даваатогтох Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Д.Дуламсүрэн, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар, Ц.Шинэбаяр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар, Л.Сүх-Очир Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар.

Манай гишүүд бас байж байгаарай. Энд санал хураалт явуулна шүү.

Ингээд албан тушаалтнуудыг танилцууллаа.

Тогтоолын төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Б.Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч, ард түмний жаргалтай амьдралаас хулгайлагч хүчин зүйл болсон авлигатай тэмцэх, түүний шалтгаан нөхцөлийг арилгах нь Та бидний эрхэм зорилго билээ.

Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласан.

Энэ хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг арилгаж, бүх шатад авлигатай

тэмцэн, хүний эрхийг хангаж, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Засгийн газраас хууль эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлж, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгон иргэд, олон нийтийн оролцоо, хяналт тавих боломжийг өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас нэн тэргүүнд авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах өөрчлөлтийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь батлагдаж, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Авлигатай тэмцэх гол арга замын нэг бол төрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал бөгөөд энэ хүрээнд Улсын Их Хурлаас бүртгэлийн багц хууль, цахимын багц хууль болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, эдгээр хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

Үүний үр дүнд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг цахим засаглалын индексээр 18 байраар урагшлаад байна.

Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2023 онд дууссантай холбогдуулан авлигатай тэмцэх цогц арга хэмжээг агуулсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраас боловсруулсан бөгөөд төлөвлөгөөний төсөлд Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан 11 зорилго, 48 зорилтыг хангах чиглэлээр 2023-2030 онд 295 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэх болно.

Хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлснээр авлигагүй төр, нийгмийг цогцлоож, шударга ёсыг тогтоон, ард түмний алдагдсан боломж, эрхийг сэргээхэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Тогтоолын төслийг хэлэлцэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би нэг юмыг л илүү гол нь сонирхоод байгаа юм.

Сая “Transparency International”-ийн судалгаагаар манай байр ухарчихлаа гээд л. Тэгээд л хүмүүс янз бүрээр тайлбарлаад байсан.

Гэхдээ миний ойлгосноор мэдээлэл өгч байгаагаар харахаар төрийн өмчит компаниудын засаглалын орчныг сайжруулаагүй, Шүгэл үлээгчийн тухай

хууль батлагдаагүй гээд хэдэн гол юмнууд байх шиг байсан шүү дээ.

Тэгэхээр яг одоо энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргахад яг тэр нөгөө “Transparency International”-ийн нөгөө үзүүлэлтүүдтэйгээ хэр уялдсан бол?

Хуучин Х.Нямбаатар сайд энэ асуудлаар нэлээн танилцуулга юм хийж байсан.

Шинэ сайд энэ дээр яг яаж харж байна? Одоо бид чинь тэмцэл явуулаад байна, яриад байна, тэгээд байр чинь ухраад байна шүү дээ гэж.

Яг үнэндээ сүүлийн энэ удаагийн Их Хурал олон чиглэлээр ажилласан шүү дээ. Би Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан, Шүүхийн тухай хуулийн ажлын хэсгийн гишүүнээр ажилласан, хүний эрх хамгаалагч дээр ажилласан.

Тэгэхээр энэ юмнууд уг нь хийгдээд байдаг. Байр ухраад байна гээд байдаг.

Тэгэхээр энэ төлөвлөгөө гарахаар яг энэ “Transparency International”-ийн олон улсынхаа үзүүлэлт юмтайгаа яг уялдаад ингээд нэг ахиц гарсан байх ёстой шүү дээ. Яах вэ, одоо бол төр нэг хэсэг хугацаанд юм илрээд нэлээн яригдаад байгаа учраас байр ухарсан байх гэж ойлгож байгаа.

Гэхдээ хэд хэдэн гол юм хийгдээгүй байгаа. Тийм ээ. Төрийн болон орон нутгийн өмчид компанийн тухай хуулийг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг, тэгээд

Шүгэл үлээгчийн гээд энэ хуулиудыг бид яг хараахан баталж чадсангүй явж байна.

Шүгэл үлээгч дээр бид ярих байх л даа.

Тэгэхээр энэ асуудал дээр ойлгомжтой бас нэг мэдээлэл хүмүүст өгөх нь зүйтэй байх. Баахан төлөвлөгөө, хөтөлбөр юм уу, хуулиуд гараад байна. Тэгээд юу нь дутаад ингээд юмнууд нь хийгдэхгүй байгаа юм бэ гэдэг асуултууд байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Б.Энхбаяр сайд хариулах уу? Өөрөө. Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн гол агуулга бол авлигатай тэмцэхийг Монгол Улсын төр өөрөө манлайлж, тэгэхдээ энэ дээр дангаар биш иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл хамтарч үүнийг бүх нийтийн үйлс болгож. Хамгийн гол нь авлигатай тэмцэх, үүнийг үл хүлцэх иргэний нийгмийн суурийг бэхжүүлэхэд чиглэж байгаа.

Тэр утгаараа энэ их олон талын арга хэмжээ багтаж хөтөлбөр гарч байгаа. Таны хэлсэнчлэн бид олон улсын авлигатай тэмцэх “Transparency International” байгууллагын үзүүлэлтийг тусгасан. Тэр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийн тухайд манай улс өөрөө манлайлж ажиллаж байгаа.

2023 оны “Transparency International”-ийн дүгнэлт нь 2022 оны эцсийн байдлаар Монгол Улсын арга хэмжээнүүдэд өгч байгаа үнэлэлт байгаа.

Өөрөөр хэлбэл 2024 оны хавар зарлагдаж байгаа энэ үзүүлэлт бол 2022 оны жилийн эцсийн байдлаарх Монгол Улсын үнэлгээнд өгч байгаа үнэлэлт гэдгийг нэгдүгээрт хэлэх ёстой.

Хоёрдугаарт, бид дотооддоо бас ингээд Засгийн газраас, Улсын Их Хурлаас манлайлж олон арга хэмжээнүүдийг авч хэрэглэж байгаа хүргүүлж байгаа боловч гадаад талдаа үүнийгээ бас ойлгуулж мэдээлэл хүргэх дээр алддаг алдаа байдаг юм байна.

Үүнийг энэ байгууллагын олон хүмүүстэй уулзаж, зөвлөмжүүдийг ярилцаж байх үед энэ мэдээллээ гадагшаа тайлагнах тал дээр манайх нэлээн алддаг алдаа байдаг юм байна.

Жишээлбэл, Улсын Их Хурлаас авлигатай тэмцэх чиглэлд авлига, албан тушаалын гэмт хэрэгт орооцолдсон улс төрд нөлөө бүхий этгээд дээр Эрүүгийн хуульд заасан ялын хамгийн дээд хэмжээ буюу хээл хахууль авах хэргийн тухайгад бүх насаар хорих ялыг баталсан байгаа.

Энэ нь жишээлбэл энэ тайлангаас хойш хийгдсэн ажил байдаг. 2 удаагийн хөгжлийн банк болон нүүрсний сонголууд парламент дээр зохион байгуулагдсан. Энэ нь жишээлбэл энэ тайлан үнэлэлтээс хойш хийгдсэн ажлууд байх жишээтэй ч байдаг юм уу.

Энэ хүрээнд мэдээж өмчийн реформууд, төрийн өмчийн компанийн засаглалтай холбоотой асуудлууд хийгдэнэ.

Ер нь тал талын чиглэлд энэ олон арга хэмжээнүүд авч байж энэ асуудал сайжирна.

Хууль зүйн сайдын тухайгад гол анхаарч байгаа хэд хэдэн чиглэл байгаа.

Энэ бол авлигатай тэмцэх чиглэлд, гэмт хэргийг шалгах чиглэлд улс төрийн нөлөөлөл оруулахгүй байх. Ямарваа нэгэн байдлаар захиалгаар Н.Алтанхуяг даргын хэлээд байгаа шиг хонгилддоггүй байх, шантааж үүсгэдэггүй байх.

Энэ дээр би хууль, эрх зүйн хувьд ч ялын бодлогыг чангалах, эрх зүйн орчныг бүрдүүлэх дээр бас анхаарч ажиллаж байгаа зүйлүүд байна.

Ер нь ямар нэгэн байдлаар захиалгаар хонгилддог схем угсрагдсан. Энэ нь өв залгамжлах хэв шинжээ хадгалсан нөхцөл байдлууд байна.

Тэр байтугай Хууль зүйн сайдын нэрийг барьж тодорхой хэрэг учрал юман дээр шантааж хийсэн асуудлуудыг дотооддоо шалгаж байна.

Өөрөөр хэлбэл Хууль зүйн сайдаас захиалсан гэдэг байдлаар тодорхой мөнгө төгрөгийн байдлаар шантаажилсан асуудлыг хүртэл шалгаж байгаа юм.

Тийм учраас үүнийг ер нь тогтолцооны хувьд ч тэр нэлээн анхаарах хэрэг байна.

Ер нь энэ авлига бол өөрөө их тийм цар хүрээтэй өргөжсөн байна. Нэг улс төрчийг нэг хүн 500 сая төгрөгийн захиалга өгч захиалгаар сошиалд **“bullying”**¹ айлган сүрдүүлэх, дээрэлхэх¹ -дэж байна. Өртөг нь нэмэгдсэн байна.

¹ **“bullying”** - гар утас, цахим шуудан, сошиал медиа, мессеж гэх мэт цахим технологиор дамжуулан давтамжтайгаар хэл амаар доромжлох, айлган сүрдүүлэх, заналхийлэх, дарамтлах зан үйл.

Д.Цогтбаатар: Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр үүнийг сайд үргэлжлүүлээд ярина биз.

Ер нь энэ авлига чинь төрийн албан тушаалтнуудын хүрээнд байснаа хэвлэл мэдээлэл, цахим орчинд байдаг тодорхой хүмүүс улс төр, төрийн үйл ажиллагаанд шүгэл үлээж хяналт тавьж байна гэдэг нэрийдлээр шантаажилж байгаа байхгүй юу. Өөрсдөө гэмт хэргийн оролцогч болж байгаа юм.

Тэгээд бусдыг авлигачаар дуудаад байдаг. Өөрөө нөгөө хармаанаас төрөөс юм уу, төртэй хамааралтай хүмүүсээс мөнгө авдаг.

Энэ бол бас авлига өргөжиж байгаа байхгүй юу. Монголын нөхцөлд. Өөрөө бараг авлигын хамсаатан л байгаа байхгүй юу. Адилхан. Тэгчхээд авлигын тухай ярьж байгаа юм.

Энэ дээр нэг юм байгаа. Энэ төлөвлөгөөн дотор **“Олон нийтийн зөвлөл”**-ийн асуудал байгаа юм. Манай нөхдүүд байж байна.

Энэ “Олон нийтийн зөвлөл” маань яг “Олон нийтийн зөвлөл” байж чадаж байна уу? Өнгөрсөн хугацаанд харах хамгийн их улс төржөөд л, янз бүрийн шүүмжлэл өрнүүлээд байсан хүмүүсийг л авчраад л та нар чинь ингээд тавьчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ үйл явцыг нээлттэй, ил тод болгоно гэдэг дээр яг юу гэж ойлгож байна? Хэн шалгаруулах юм? Хэн нэр дэвшүүлэх юм.

Тэгэхгүй бол “Олон нийтийн зөвлөл” гэж байна. Энэ чинь иргэдийн

өмнөөс хяналт тавимаар байгаа байхгүй юу.

Авлигатай тэмцэх газрыг хэн хянах вэ гэдэг чинь Монголд тодорхойгүй болчихсон юм шүү дээ.

Хууль зүйн байнгын хороо нэг хянавал хянана. Тэгээд “Олон нийтийн зөвлөл” нэг жоохон юм оролцвол оролцоно. Ингээд Монголд өөр хяналт байхгүй.

Үндсэн хуулийн цэцийн хяналт ч байхгүй.

Шүүхийн хяналт ч байхгүй. Өөрөөр хэлбэл шүүхийг өөрөө шалгадаг газар болчихсон. Ингээд өөрөө хяналтаас гадуур болчихсон.

Тэгэхээр энэ “Олон нийтийн зөвлөл” чинь өөрөө чухал байгаа байхгүй юу. Бас.

Д.Цогтбаатар: 2 номерын микрофон өгье.

М.Даваатогтох: Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга М.Даваатогтох. Гишүүний асуултад хариулья.

Авлигын эсрэг хуулиар Авлигатай тэмцэх газрын дэргэд ажилладаг “Олон нийтийн зөвлөл”-ийн эрх зүйн байдлыг зохицуулсан байдаг.

Авлигын эсрэг хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч Авлигатай тэмцэх газрын дэргэдэх “Олон нийтийн зөвлөл”-ийн гишүүнийг 4 жилийн хугацаатайгаар томилох зохицуулалт байгаа.

Өөрөөр хэлбэл “Олон нийтийн зөвлөл”-ийн гишүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд томилдог.

Энд Авлигатай тэмцэх газрын зүгээс оролцох зохицуулалт байхгүй. Ингэж явж байгаа.

Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлын чиглэлийн ажлуудад хуулийн дагуу прокурор хяналт тавьдаг.

Прокурорын хяналтад мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажил явагдаад ингээд асуудал шийдэгдээд явдаг. Хяналтын тухайд байгаа.

Авлигын эсрэг хуулиараа Авлигатай тэмцэх газрын дэргэдэх “Олон нийтийн зөвлөл” 15 гишүүнтэй. Эдгээр гишүүд Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаалт, хэрэг бүртгэх, гүйцэтгэх ажлаас бусад үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалттай байгаа.

Үүнийхээ дагуу энэ хүмүүс бүрэн эрхээ хэрэгжүүлээд явах боломжтой байгаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг чухал багц сэдэв бол энэ улс төрийн намын санхүүжилт, улс төр дэх санхүүжилтийн шилэн, ил тод байх. Тэгээд нам ба нэр дэвшигч нарын хувиасаа гаргах энэ хөрөнгө мөнгөний нөлөөг багасгах явдал байгаа.

Тэгэхээр энэ Улс төрийн намын тухай хууль 2023 онд Улсын Их Хурал баталсан.

Хуулийн гол зорилт ерөөсөө улс төрийн өрсөлдөөнийг мөнгөний өрсөлдөөн биш бодлогын өрсөлдөөн болгох чиглэлд хийгдсэн юм.

Тэгээд улс төрийн нам, нэр дэвшигчдийн бүх санхүүжилтийг ил тод болгож, санхүүжилтийн зөрчлийн улмаас тухайн намд нэлээн хатуу санкцууд буюу шийтгэл оногдуулахаар заасан байгаа.

Тэгээд энэ хууль 01 сарын 01-нээс эхлээд хэрэгжиж эхэлсэн.

Тэгээд хуулийг баталснаас хойших хугацаанд харахад тодорхой намуудын хувьд хэрэгжихгүй байгаад байна. Жишээлбэл, Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д бид энэ сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намууд нэр дэвшигч нараасаа дэнчин мөнгө шаардахыг хориглосон.

Гэтэл өнгөрсөн хугацаанд Ардчилсан намын “Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо”-ны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээсээ 60 саяын дэнчин авсан гэсэн мэдээлэл яваад байгаа.

Үүнийг Авлигатай тэмцэх газар шалгасан уу, үгүй юу гэдгийг асуумаар байна.

Тэгээд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.4.4 дээр байгаа нам, эвсэл, нэр дэвшигчээс гарах сонгуулийн зардлыг бууруулах гэдэг энэ зорилтын хүрээнд 2 ажил хийхээр төлөвлөсөн байгаа.

Тэгэхээр нэгдүгээрт нам, эвслээс нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах

зардлыг бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж.

Энэ дээр яг тухайлан ямар зохицуулалтыг хийхээр ер нь ажиллах вэ?

Ер нь бид сонгуулийн холимог системийг нэвтрүүлсэн нь нэр дэвшигчээс гарах зардлыг багасгах буюу намын бодлогын өрсөлдөөнийг дэмжих зорилт байсан.

Тэгээд энэ удаагийн сонгуулиар нөгөө тойрог томорсонтой холбоотойгоор бас нэр дэвшигчээс гарах зардал ерөнхийдөө улс даяар нэмэгдэж байна.

Тэгэхээр бид нэр дэвшигч буюу хувийн мөнгийг багасгах, төрийн санхүүжилт нэмэгдүүлэх гэдэг алтернатив хувилбар ер нь бодож байна уу, үгүй юу? Ер нь яаж нэр дэвшигчдийг мөнгөний өрсөлдөөнөөс ангид байлгах вэ? Сонгуулийг яаж бодлогын өртөөн болгох вэ? Энэ тал дээр Хууль зүйн яам болон манай Авлигатай тэмцэх газраас ямар эрх зүйн өөр хувилбар дэвшүүлж байгаа юм бэ?

Ер нь энэ жилийн байдлаар сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ асар нэмэгдэхээр байна.

Тэгэхээр бид улс төрийн хувьд цаашид сонгуулийн системийн өөрчлөлт, эсвэл улс төрийн намаас гарах зардлыг бүрэн багасгах, сонгуулийн зардлын үлэмж хэсгийг төрөөс даах буюу бусад улс орнуудын, Европын болон Азийн улс орнуудын жишиг рүү орох ер нь шаардлага байна гэж би бас энэ улс төр судлаач, эрдэмтний хувьд үзээд байна.

Энэ тал дээр манай Хууль зүйн яам болон Авлигатай тэмцэх газрын саналыг сонсмоор байна.

Ер нь бид энэ улс төр дэх хөрөнгө мөнгөний өрсөлдөөнийг багасгаж байж Монголын улс төрийн авлига багасна. Энэ чиглэлээр.

Түрүүн Хууль зүйн сайдын хэлсэн төрийн өмчит компаниудын хувьд авлигалын индексийг асар хойш нь татаж байгаа асуудал байгаа. Энэ ажил дээр бид анхаарч байж авлигалын төсөөллийн индексийг бууруулах боломжтой болно.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ?
Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр үнэхээр авлигын эх ундарга гэж ярих юм бол шийдвэр гаргагчид, ялангуяа дээд түвшний шийдвэр гаргагчдад оролцоотой асуудлууд байна гэдэг зүйл парламентын Хөгжлийн банк болон нүүрсний хоёр удаагийн сонсголоор ил болсон.

Энэ бол тодорхой болсон. Улс төрийн нам, намын удирдлагууд, шийдвэр гаргагч нар, банк санхүү, хууль хяналтын байгууллагын сүлжилдсэн схемтэйгээр энэ ажлууд хийгддэг ээ гэдэг.

Тэр ч утгаараа энэ их ундаргатай тэмцэх асуудал бол авлигатай тэмцэх бодлогын тэргүүн эгнээнд байх учиртай.

Тэр ч үүднээс улс төрийн нам болон улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг шилэн болгох, тодорхой бизнесийн тэр гэр бүлүүдээс хамааралгүй болгох чиглэлд парламент манлайлал үзүүлж хууль тогтоомжийг баталж байна.

Мэдээж баталж байгаа хуулиуд хоорондоо уялдах ёстой. Улс төрийн сонгуулийн дүрмийг цэвэр парламент өөрөө тогтоодог.

2024 оны сонгуулийг 2020 оны сонгуультай харьцуулах юм бол жагсаалтаар нэр дэвших 48 хүний хувьд ямарваа нэгэн зардал мөнгө гарахгүйгээр, хэн нэгэнд барьцаалагдахгүйгээр парламентын гишүүн болно.

Яг тойрогт үзэх хүмүүсийн тухайд сонгуулийн зардал тойрогт томорсонтой холбоотойгоор хэд дахин нэмэгдсэнийг та бид бүгд мэдэж байгаа.

Зүгээр тайлангийн сэтгүүл тараах гээд л тооцоо хийж үзэхэд, 2020 онд би анх удаа нэр дэвшиж байсан. Тухайн үед сэтгүүл хэвлүүлж байх зардлаас 5 дахин их зардал одоо сэтгүүл хэвлүүлэхэд гарахаар байна.

Тэгэхээр энэ бол одоо үлэмж хэмжээгээр нэмэгдсэн байна. Тэр ч утгаараа жишээлбэл, одоо миний тухайд тэгэхэд тойргийнхоо бүх айл өрхүүдэд тайлангаа тавих бололцоо байхгүй. 20 орчим хувьд нь л хүрэхээр тайлан сэтгүүл хэвлүүлж байх жишээтэй байна.

Тэгээд энэ асуудал манай бүх улс төрчид сонгуульд нэр дэвшихийг горилж байгаа хүмүүсийн тухайтад зовлонтой нүүр тулж байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна.

Ер нь томоохон хэдхэн бизнестэй, мөнгөтэй хүмүүс л ер нь ачааг нь даахаар хэмжээний яг тойрогт үзэж байгаа хүмүүсийн тухайд л тогтолцоо байна.

Тэгэхээр таны хэлж байгаа асуудал дээр сонгуулийн хууль тогтоомжийг баталж байгаа парламентын

гишүүд Их Хурлын гишүүд өөрсдөө энэ асуултад хариулах ёстой байх гэж бодож байна. Энэ бол олонхынхоо саналаар парламент өөрөө шийдвэрээ гаргадаг.

Тийм учраас сонгуулийн зардлыг бууруулах чиглэлд цаашдаа сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход зайлшгүй анхаарахгүй бол энэ болохгүй болчихсон гэдгийг би бол. Одоо би ч яах вэ дээ. Ер нь манай парламентын гишүүд бүгд л яриад байгаа. Үнэхээр дааж давшгүй их зардалтай болчихсон.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Д.Дуламсүрэн: Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга Д.Дуламсүрэн.

Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Одоогийн сонгуулийн хувьд энэ намуудын дэнчин тавих, мөнгө төгрөг шаардахгүйтэй холбоотой асуудал хууль тогтоомжоор зохицуулж өгсөн нь давуу тал байгаа.

Одоогийн байдлаар манай байгууллага дээр дэнчин нэхсэн, ингэсэн тэгсэн хэргийн талаар юм шалгагдаж бүртгэгдээгүй байгаа.

Сая Б.Энхбаяр сайдын хэлсэнтэй Авлигатай тэмцэх газар санал нэг байгаа. Нам эвсэлд нэр дэвшигчдийн хувьд бас сонгуульд гарах зардал өсөж байгаа.

Гэтэл Улс төрийн намын тухай хууль шинэчлэгдээд энэ оноос мөрдөгдөж эхэлж байгаа учраас энэ хууль батлагдах үед тойрог томсготой холбоотой асуудал яригдаагүй байсантай

холбогдуулаад энэ зардал буурч байна гэсэн дүгнэлтийг бид хийчихсэн байсан.

Гэтэл нөхцөл байдал өөрчлөгдсөн учраас нэгдүгээрт томсгосон тойргийн асуудал.

Хоёрдугаарт, инфляцын түвшин ямар байгаа гэдэгтэй бас холбогдуулаад зардал өсөх нь тодорхой байгаа.

Ийм учраас сонгуулийн хууль тогтоомж энэ зардлыг бууруулахтай холбоотой асуудлыг дахиж авч үзэх ёстой болчхож байгаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ арга хэмжээний төлөвлөгөөний төсөл дээр энэ сонгуульд зарцуулах зардал буурсан эсэхэд бас дүн шинжилгээ хийхээр тусгагдчихсан байгаа.

Тэгэхээр сонгуулийн дараа холбогдох дүн шинжилгээнүүд хийгдэнэ. Мөн сонгуульд өрсөлдсөн намууд мөн сонгуулийнхаа зардлын тайланг аудитын байгууллагад гаргаж хүргүүлэх ёстой байгаа.

Түүн дээр мөн иргэний нийгмийн байгууллагуудыг дүн шинжилгээ хийх боломжийг олгохоор бас хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд бас тусгачихсан байгаа.

Тэгэхээр энэ бүгд уялдаад Үндэсний Аудитын газар, Авлигатай тэмцэх газар, иргэний нийгмийн байгууллагуудын хөндлөнгийн хяналттайгаар дүн шинжилгээ хийсний эцэст зардал өмнөх сонгуулиасаа хэд дахин өссөн бэ. Мөн түүнээс яаж бууруулах чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх вэ гэдэг нь тодорхой болох байх гэж харж байгаа. Хариулж дууслаа.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би сая энэ 2 сард авлигын индексийн үзүүлэлт гараад. Тэгээд манайх 5, 6 байраар ухарчихлаа гээд гайхаад байсан л даа.

Өнгөрсөн жил ч Улсын Их Хурал авлигатай тэмцэх чиглэлээр бүхий л байж болох арга хэмжээнүүдийг авсан.

“Таван Ш” ажиллагаа үндэсний хөтөлбөрийг баталсан. Эрүүгийн хууль дахь авлига албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангалсан.

Ингээд байхад чинь эсрэгээрээ авлигын индекс өсөөд байна гэдэг чинь юу гэсэн үг вэ гээд.

Тэгээд сая Б.Энхбаяр сайдын ярианаас энэ авсан арга хэмжээнүүд, хууль эрх зүйн тогтоол юмнууд ороогүй юм байна л даа.

Тэгэхээр ирэх жил бас авлигын индексийн үзүүлэлтэд эд нар бас нөлөөлөх юм байна, буурах юм байна гэж ингэж хувьдаа бодож байна. Нэгд.

Нөгөө талаар авлигачид айхгүй л байна л даа. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад ялын бодлогыг чангаллаа гээд. Ялын бодлогыг чангалах болгонд хэрэг буурдаггүй гэдэг бас харагдаж л байна.

Тийм учраас ноднин баталсан үндэсний хөтөлбөрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд 2024-2030 оны хугацаанд.

6 жилийн хугацаанд хэрэгжүүлэх энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн

хүрээнд Та бүхэн авлигын индекс хэдтэй байна гэж үзэж байгаа вэ?

Авлигатай тэмцэх ажил ямар үр дүнд хүрсэн байна гэж үзэж байгаа вэ?

Авлигатай тэмцэх газар хэрхэн бэхэжсэн байна гэж үзэж байгаа вэ?

Иргэд олон нийтийн дунд авлига авбал үнэхээр ялын дээд хэмжээ авдаг юм байна гээд энэ соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр ямар ойлголт хандлагатай болсон байна гэж үзэж байгаа вэ?

Энэ төрийн байгууллагуудын албан тушаалтнуудын үйл ажиллагаа хэрхэн ил тод, нээлттэй болсон байна гэж үзэж байгаа вэ?

Энэ хөтөлбөрийг батлагдаад хэрэгжээд дууссан тохиолдолд.

Хэмжих нэгж нь юу юм бэ? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайд хариулах уу?

Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Авлигатай тэмцэхэд мэдээж энэ тасралтгүй хүчин зүтгэлийн, тэгэхдээ зориг, цуцаж болохгүй, мөнгөнд няцаж болохгүй тэмцлийн үр дүнд бид хамтдаа ялна.

Авлигачдаасаа өөрсдөөс нь мөнгө авдаг. Тэгээд мөнгө авч тэр өрсөлдөгчдийг намнах ажил хийж байгаа хүмүүс бол авлигачид өөрсдөө.

Яагаад гэхээр хулгайн мөнгөөр гараа зүсчихсэн гэсэн үг. Нүүрсний

сонсгол дээр анзаарах юм бол маш цөөн тооны хэвлэл мэдээлэл дуугарсан.

Энэ бол Монголын сэтгүүл зүйг нүүрсний мөнгө бүхэлдээ худалдаж авсан байна гэсэн үг.

- Иргэний нийгмийн байгууллагыг худалдаж авч байна.
- Хуулийнхныг худалдаж авч байна.
- Төрийг худалдаж авч байна.
- Өрсөлдөгч намаа худалдаж авч байна.

Худалдаж аваагүй зүйл үлдээхгүй нь.

Тийм учраас иртэй байна, бяргай байна.

Энэ тэмцэлд манлайлж байгаа хүмүүсийг Улсын Их Хуралд нэр дэвшүүлэхгүй ээ гэж хуурай агсамнадаг болтлоо даварсан байна.

Тийм учраас энэ тэмцэл амархан хялбар биш.

Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Ардын намын дарга жагсаалын үеэр хүчин мөхөствөл ард түмэнтэйгээ би нэгдэнэ гэдэг үгийн учиг одоо ойлгогдож эхэлж байгаа.

Энэ үг хоосон үг байгаагүй. Сэтгэл хөдлөл байгаагүй.

Авлигатай тэмцэх тэмцэл намын журмын нөхдүүдээсээ эхэлнэ гэдэг үг ч хоосон үг байгаагүй. Амаргүй гэдгийг өөрөө ойлгож байсан.

Миний бие ч гэсэн Монгол Улсын Ерөнхий сайдын шударга ёсыг тогтоох дээр хуулийн илд нь болно гэдэг үг өөрөө сэтгэлийн хөдлөл байгаагүй.

Энэ ухамсартай, ямар тэмцэл явагдах гэж байгаа, ямар үр дүнд хүрэх гэж байгаа гэдгийг ойлгосон улс төрийн байр суурь байсан.

Тийм учраас Ерөнхий сайдын энэ улс төрийн манлайлал дээр хүч өгч дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гэж ухамсарлаж ажиллаж байгаа.

Авлигатай тэмцэх энэ бодлогын бичиг баримт бол маш их өргөн хүрээний бичиг баримт.

Бид зөвхөн олон улсын үнэлгээнд нэг, хоёр байраар урагшилсан юм уу, ухарсан асуудал дээр сэтгэл ханахгүй. Сэтгэл ханахгүй.

Хуулийн байгууллагууд ч гэсэн. Би хуулийн сайд байр сууриа тодорхой илэрхийлээд байгаа. Тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд би хөндлөнгөөс оролцохгүй гэдэг.

Оролцохгүй гэдэг нь нүдээ таглаад, чихээ бөглөөд байгаа гэсэн хэрэг биш.

Тодорхой шалгагдаж байгаа хэрэг дээр нөлөөлөл үзүүлчих гээд байгаа учраас Үндсэн хуульд заасан Үндсэн хуульдаа үнэнч байх тэр зарчмаа баримтлаад байна гэсэн үг.

Одоо хүртэл тодорхой болчихсон 100 тэрбумын авлигын асуудал нь яригдчихаад байгаа хэрэг дээр хуулийн байгууллага таг дүлий байгаад байгаа.

Ард түмнийг тэнэг мунхаг, мартдаг, гөлөг төөрүүлэх ажиллагаанд автдаг гэж бүү итгэ.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Нэмж асууя.

Ц.Сандаг-Очир: Манай Хууль зүйн сайд зоригтой байгаа юм байна. Шийдэмгий байгаа юм байна. Мэдээж амаргүй гэдгийг ойлгож байгаа.

Би тодорхой асуулт асуусан. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрэх юм бэ, хэмжих шалгуур нь юу юм бэ?

Ард түмэн энэ Засгийн газраас, энэ Их Хурлаас авлигад авлигатай тэмцэх ажлыг эхлүүлснийг мэдэж байгаа. Эцсийн үр дүнг хүлээж байгаа.

Та нар тэмцэж байна. Авлига, хулгай бөөн нүүрс, Хөгжлийн банк ярилаа. Эцсийн үр дүн чинь хаана байгаа юм? Тэгвэл. Хэн ял авсан юм, хэн хариуцлага хүлээсэн юм гээд яривал зөндөө олон юм байна.

Иргэдтэй уулзахаар л юм хүсэж байна. л юм асууж байна.

Илрүүлж байгаа, тодруулж байгаа, шүгэл үлээж байгаа чинь сайн хэрэг байна.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайд хариулах уу? Б.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Д.Цогтбаатар дарга их чухал хууль санаачилж байгаа. Энэ дээр Засгийн газар санал, дүгнэлтээ яаралтай бэлдэж өгч байгаа.

Тэр нь авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдсон нийтийн албан тушаалтны шүүх хурлаар орж байгаа хэргийг хаалттай хэлэлцэхгүй гэдэг хуулийн өөрчлөлтийг бас ярьж байгаа.

Шүүхийн ил тод байдал нээлттэй байдлыг хангах зорилгоор.

Энэ бол шударга ёсыг нээлттэй байлгах гэж байна гэсэн үг.

Сая жишээлбэл нүүрсний сонголт нь ил яваад, нөгөө шүүх хурал нь болохоор хаалттай явчхаж байгаа юм.

Ингээд олон түмний дунд асуудал үүсгэжхэж байгаа юм.

Тэгээд юу болсон юм. Шүүх дээр нь яг гэм буруугийн асуудал дээр нь ямар ямар нотлох баримтууд яригдаад байгаа юм.

Нөгөө хүмүүс нь болохоор гэмт хэрэг үйлдээгүй, хүн хэлмэгдүүлж байна гээд л ордноор шүгэл үлээгээд л, хэвлэлийн хурал хийгээд л.

Тэр шүүх хурал дээр нэн тодорхой нотлогдсон асуудлууд яригдсан учраас л би ял авсан гэж ойлгоод байгаа шүү дээ.

Тэгээд тэр нь ил болохгүй болохоор энэ олон түмний шударга ёсонд итгэх итгэл.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Би нэг асуулт асууна.

Энэ бичиг баримтад дунд шатныхантай ер нь яаж тэмцэнэ гэж, авлигыг тэр шатанд яаж бууруулах вэ гэдэг энэ бодлого яаж тусаж байгаа вэ?

Би яагаад үүнийг асууж байна гэхээр Эрүүгийн хуульд ч гэсэн өөрчлөлтүүд оруулахдаа улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн ялыг чангатгаад, ялын бодлогыг нь илүү хатуу болгоод өгсөн байгаа шүү дээ. Улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн. Тийм ээ.

Гэтэл авлига чинь бас дунд шатад байхгүй байгаа юм шиг бид орхичхож байгаа байхгүй юу.

Тэгтэл яг ард иргэдтэй өдөр болгон нүүр тулж байгаа, тэд нарыг чирэгдүүлж байгаа, чирэгдүүлснээрээ цаагуураа жоохон юм төлчихвөл юмыг чинь илүү хурдан хийгээд өгнө өө гээд яг нөгөө **Rent-Seeking**² гэж ярьдаг л даа.

Тэр төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг өөрийн хувийн үйлчилгээ, бизнес болгоод хувиргачхаж байгаа энэ практик яг дунд шатад байж байгаа шүү дээ.

Тэгээд хавтгай байгаад байна.

Үүнийг ярихгүй зөвхөн дээд шатад тэмцээд байвал. Дээд шаттай тэмцэх ёстой. Хатуу тэмцэх ёстой. Тэгэхдээ зөвхөн дээд шатад тэмцээд байхаар нөгөө дунд шатынханд энэ огт хамаагүй юм шиг. Энэ дээд шат.

Нөгөөдүүл харин өөрсдөө авлига сууж байж энэ дээд шатынхаа авлигачид гээд яриад сууж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэд нар луу чиглэсэн ямар бодлого, ямар арга хэмжээ энэ бодлогын бичиг баримтдаа тусгасан байгаа вэ?

3 дугаар микрофон.

Л.Сүх-Очир: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга Л.Сүх-Очир.

² **Rent-Seeking** - бизнес бүтээмжид харилцан хувь нэмэр оруулахгүйгээр нэмэлт баялаг олж авахыг эрэлхийлэх үед үүсдэг эдийн засгийн ойлголт. Төрөөс санхүүжүүлдэг нийгмийн үйлчилгээ, нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүд орно.

Д.Цогтбаатар даргын асууж байгаа асуулт зөв л дөө.

Ер нь бид бас энэ шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтантай холбоотой эрх зүйн акт, үүнтэй холбоотой хууль, дүрэм журмыг хэрхэн яаж зохицуулах вэ, энэ дээр ямар арга хэмжээ авах вэ гэдэг заалт руугаа нэлээн явж байгаа.

Гэтэл дунд шатын албан тушаалтнууд хэрхэн яаж энэ асуудлыг шийдвэрлэх вэ гэдэг энэ асуудал хөтөлбөр дээр үндсэндээ тусгагдсан.

Юу вэ гэхээр энэ дээр төрийн албан хаагч нарыг төлөвшүүлэх буюу энэ хөтөлбөрийн арга хэмжээний 2 дугаар зорилго дээр тусгагдсан байгаа. Энэ дээр төрийн албан хаагч нарыг төрийн албанд томилогдоход урьдчилсан мэдүүлэг хянуулахад төрийн албан хаагч авлига, ашиг сонирхлын зөрчил байна уу, үгүй юу. Энэ төрийн албан хаагч энэ төрийн албыг хэрэгжүүлэхэд төлөвшсөн байна уу гэдэг юм уу. Энэ талаасаа.

Төрийн албаны зөвлөл энэ төрийн албан хаагч “мерит” зарчмын дагуу томилогдож байна уу. Мөн авлига, ашиг сонирхлын зөрчил болон төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагч энэ ажил үүргийг гүйцэтгэх нь үү гэдэг тал дээр энэ арга хэмжээний төлөвлөгөөн дээр тусгаж өгсөн байгаа.

Энэ дээр мөн ашиг сонирхлын зөрчлийн хуульд төлөвлөгөөний арга хэмжээ нэлээд зүйл тусгагдсан. Төрийн албан хаагчийг авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нөхцөлд ямар арга хэмжээ авах вэ, цаашид ер нь арга хэмжээ хэлбэрээр аваад яваад байх уу, эсвэл энэ хүнийг тэр тухайн албанаас нь шууд чөлөөлөх хүртэл арга хэмжээ ногдуулах уу гэдэг асуудал хүртэл энэ арга

хэмжээний төлөвлөгөөний явцдаа энэ асуудлыг судлах, шийдвэрлэх зүйлүүд бас нэлээдгүй энэ арга хэмжээнд байгаа гэдгийг хэлье.

Мөн төрийн албан хаагч нарын асуудал дээр хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраас шалгадаг.

Дээр нь зарлагын асуудлыг бас хянах. Ер нь зарлагаараа энэ төрийн албан хаагч нар бас хэрхэн хөрөнгөжиж байна. Энэ нь хууль ёсны байна уу, үгүй юу гэдэг асуудлыг бас хариуцлагажуулах хэлбэрийн асуудал бас энэ төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариултаа авч дууслаа.

Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрс өгнө үү.

Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр яах вэ бид ингээд түрүүний хэлдгээр хуулиуд олон юман дээрээ манай энэ удаагийн Их Хурал нэлээн сайн ажиллаж байгаа.

Авлигатай тэмцэх газрын тухайд сүүлийн хэдэн жилд маш их хэрэг илрүүлж байгаа, амжилттай ажиллаж байгаа.

Ер нь Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны яг тэр, би хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг ярих юм бол маш их тийм хэрэг илрүүлэлт гэдэг юм уу, ажиллаж байгаа нь сайн байна лээ. Бараг би биеэрээ ч гэсэн танилцаад явж байгаа.

Гэхдээ би түрүүн хэлээд байгаа. Энэ мөрдөн байцаалтын ажиллагаа хийж байгаа процессын асуудлууд дээр анхаарах юмнууд үнэхээр байна лээ. Ачааллыг нь. Мөрдөгч нарын ачааллыг анхаарах хэрэгтэй байна.

Тэгээд ер нь тэр хэргийг нэг бодлын зарим дээр удаашруулна. Зарим улсууд дээр нь маш хурдан явуулдаг. Тэгээд дутуу юм их хийдэг.

Тэгээд би энэ тухай ярихгүй.

Зүгээр ямар ч байсан энэ протокол дээр Их Хурлын гишүүн байгаа үед үүнийгээ хэлье гэж бодож байгаа юм.

Хоёр дахь юм нь, Ерөнхий сайдын хэлээд байгаа. “Системийн авлига” гэж яриад байгаа юм.

Тэгээд үүний хамгийн гол юм бол хүмүүсээр дамждаг асуудлууд байж байгаа.

Сая Улсын Их Хурал Ашиг сонирхлын зөрчлийн хууль гээд Х.Тэмүүжин гишүүн бид хоёр, 13 жилийн өмнө Ж.Энхбаяр бид гурав үүнийг санаачилж батлуулж байсан. Одоо та нар үүнийг мөрдөж байгаа.

Сая би сүүлийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан.

Энэ төрийн өндөр албан тушаалтан аймаг, нийслэлийн Засаг дарга гэсэн улсуудын гэр бүлийн улсуудыг янз бүрийн төсөл, хөтөлбөр, тендерт оролцуулахыг нь хориглож байгаа.

Тэгэхээр үүнийгээ та хэд анхаарах ёстой шүү.

Энэ хүмүүст Ерөнхий сайд нэг том мэдэгдэл хийчихсэн. Бид сая хууль гаргачихсан.

Тэгээд энэ дээр та хэд хэрэгжүүлэх асуудлууд одоо энэ 2024 оны сонгуулийн дараа явна. Тэгээд энэ дээрээ анхаарна биз.

Яах вэ, мань мэтийн юмыг ч гэсэн жишээн дээрээ ашиглах ёстой шүү дээ.

Сая би төсвийн ерөнхийлөн захирагч гээд миний хариуцсан хүрээнд асуудал үүсэнгүүт би ёс зүйн хариуцлага хүлээж байгаа байхгүй юу.

Одоо тэгэхэд Америкийн Нэгдсэн Улсын сенатор Р.Менендес /Robert Menendez/ гээд алдартай сенатор хээл хахуулийн хэрэгт холбогдоод авчихсан мөртлөө ажлаасаа буухгүй дахиад үргэлжлүүлж өрсөлдөнө гээд л жишээлбэл явж байх жишээтэй байгаа шүү дээ.

Гэтэл бид нарт, манай парламент дээр ямар нэгэн хэмжээгээр төсвийн ерөнхийлөн захирагч гээд би шууд тэрийг хариуцахгүй ч гэсэн тэнд хариуцлагаа би өөрт жишээлбэл үүрсэн.

Яагаад гэвэл авлигатай тэмцэх энэ олон хууль тогтоомж дээр оролцож байсан учраас надаас хойш энэ бүхэн тогтоосой гэж.

Гэтэл төсвийн ерөнхийлөн захирагч нарын өчнөөн хэрэг тэр доор дунд, анхан шатад чинь зөрчлүүд гарлаа гээд тэр ерөнхийлөн захирагч нар чинь хариуцлага хүлээдэггүй байхгүй юу.

Гэтэл манай хуулийн байгууллагын хүн та чинь хуулийн

хариуцлагаас чөлөөлөгдөхгүй юм байна шүү дээ гэж.

Хэрвээ тэр логикоороо үзвэл төсвийн ерөнхийлөн захирагч хариуцаж байгаа сайд болгоны доор янз бүрийн хэрэг зөрчил гарч байгааг сайд болгон үүрдэггүй байхгүй юу даа.

Тэгээд жишээлбэл тэгэхээр мэтийн юмнуудаа бас ямар үед нь яаж ашиглаад байна гэдгээ бодох хэрэгтэй.

Тэгээд ер нь хамгийн гол юм бол хүмүүсийн хувьд одоо хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гэж байна. Энэ мэдүүлгүүдийг авч байна.

Монгол жижигхэн орон учраас ер нь төвөгтэй л дөө. Ямар нэгэн юманд холбож болно.

Гэхдээ энэ асуудлууд дээр ер нь цаашдаа 2024 оны сонгуулийн дараа шинээр бүрдэх Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүдийн тэр ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх юмыг илүү бодитой харуулж, тэр хүмүүст ил тод, нээлттэй болгож явах хэрэгтэй.

126 гишүүн байгаа учраас цаашдаа олон асуудлууд гарна. Хэчнээн сайн сайхан байсан ч гэсэн.

Сая энэ 76 дотор чинь арван хэдэн хүний асуудал хэрэгт холбогдонгуут Монгол Улсын парламентын ажиллах чадамж нөлөөлж байгаа байхгүй юу.

Уг нь дэлхийн улс орнуудад “халдашгүй байдал” гэдэг нь парламентын гишүүн ажлаа хийж байхад прокурорт дуудагдаад юм уу, шүүх

дээрээ шүүхийн үүд сахиад сууж байдаг юм буруу байхгүй юу. Уг нь.

Уг нь шалгараад л иргэдийн ард түмний итгэлийг хүлээсэн байх ёстой. Их Хурлын гишүүн иргэн хоёр адилхан гэж байгаа боловч Их Хурлын гишүүн нь ард түмнийг төлөөлж байгаа мандат эзэмшиж байгаа учраас байгаа учраас тэр мандатыг хамгаалах шаардлагатай байдаг байхгүй юу.

Гэтэл одоо миний ажлын цагийг тасалсан гээд гаргаад тавьчихаж байгаа юм. Үгүй ээ. Би тэнд чинь дуудагдаад явж байгаа байхгүй юу. Ажлаа хийж чадахгүй. Би Ж.Сүхбаатар гэдэг нь хэн ч биш байхгүй юу. Ард түмний төлөөлөгч гэдэг чинь хамгийн том мандат байхгүй юу даа.

Тэгэхээр энэ авлигатай тэмцэж байгаа энэ үйл ажиллагаан дээр бид их олон юмыг ярих ёстой.

Ер нь дандаа нэг тийм олон нийтийн сэтгэл зүй бодлоор. Баримтаар ялладаг байхгүй юу. Баримтыг мэргэжлийн тусгай мэдлэг чадвартай хүн үнэлж чаддаг.

Түүнээс баримт болгоноос логик дүгнэлт хийгээд явах хүн болгоны, иргэн хүний юм уу, хэн нэг хүний асуудал.

Тэгэхээр энэ хэрэгжиж байгаа үйл ажиллагаанууд дээр бид дараагийн шинэ шатад гаргах цаг болчхоод байгаа.

Ер нь сая Хууль зүйн сайд хэлж байна шүү дээ.

Өнөөдөр өчнөөн олон хулгайч, луйварчин гэж хэлэгдсэн өчнөөн олон хүчтэй хүмүүс хэвлэл мэдээлэл дээр хэн мөнгө зарж байгаа юм.

Жишээлбэл, одоо би асуудалд холбогдлоо гэхэд өөрийгөө хамгаалах чадваргүй байгаа байхгүй. Их Хурал дээр үг хэлж ч болохгүй. Бас санаа зовоод. Хэвлэл мэдээллээр гэхэд мөнгө байхгүй.

Тэгсэн хэрнээ мөнгөтэй холбоотой хэрэгт хутгалдчихсан. Тэгсэн хэрнээ битүү ингээд мөнгөөр хүн нүдээд байдаг. Би тэрийгээ хамгаалж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Л.Мөнхцэцэг гишүүнд микрофоныг өгье.

Л.Мөнхцэцэг: Тэгэхээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дэмжиж байна.

Энэ дээр тухайлан илүү нарийвчилсан тодорхой ажлуудыг хийх шаардлага байгааг бид ер нь анхаарч харж байна.

Тухайлбал, одоо энэ сонгууль дахь мөнгөний нөлөөг багасгах, хувь нэр дэвшигчээс гарах зардлыг бууруулах, мөнгөтэй хүмүүс сонгогчдын саналд нөлөөлөх, хөрөнгө мөнгөний өрсөлдөөнийг багасгах энэ чиглэл дээр дараагийн Их Хурал илүү анхаарах шаардлагатай. Энэ бол яах аргагүй улс төрийн шийдэл, улс төрийн юу байна.

Бид Улс төрийн намын тухай хуулийг батлах. Энэ ажлыг хийхийн тулд бас их олон удаагийн хурал, арга хэмжээнүүд хийж байсан.

Япон болон Солонгосын улс төрчид, Элчин сайдын яамтай хамтарч тэдний улс төрийн санхүүжилтийг шилэн болгосон талаар бид хурал хийхэд яг Монголын өнөөдрийн улс төр бол яг 1980, 1990-ээд оны эхэн үеийн Япон, Солонгосын улс төр шиг байгаа юм.

Хөрөнгө мөнгөний нөлөө ихтэй. Авлигатай тэмцэх, авлигалын том хэргүүд гарсан.

Тэгээд гурав, дөрвөн том сонгуулийн санхүүжилтийн хуулиудыг шинэчилсэн байгаа.

Ер нь сонгуульд мажоритар систем он удаан жил хэрэглэж хувь нэр дэвшигчийн нөлөө өндөр байгаа энэ систем чинь өөрөө яг тэр хөрөнгө мөнгөтэй, нутаг усанд танигдсан, цөөн олигархуудыг оруулж ирдэг гэдгийг яг тэр 80-аад оны Япон, Солонгосын улс төр харуулж байгаа.

Тэгээд гол гол хуулиудын шинэчлэлийг хийгээд санхүүжилтийг ил тод болгосон. Хувь нэр дэвшигчийн нөлөөг багасгасан гол оролдлого бол энэ “сонгуулийн холимог систем” гээд.

Өөрөөр хэлбэл мажоритар системийн нөлөөг багасгаж байж намын тэнд бодлогын өөрчлөлтийг явуулах механизм хийсэн байгаа.

Тэгээд Японы парламентын 475 гишүүний 180 нь намын жагсаалтаар, 295 нь мажоритар системээр гарч ирдэг.

Тэгээд Солонгосын эрдэмтэд ингэж ярьж байгаа байхгүй юу. Солонгосын өнөөдрийн улс төрийн авлига бол бид Японтой адилхан сайн тэмцэж хийж чадахгүй байгаа юм.

Яагаад гэхээр манай парламентын мажоритар системээр гарч ирдэг нэр дэвшигчийн тоо их өндөр гэж.

Өөрөөр хэлбэл Солонгосын улс төрийн намуудын парламентын нийт 300 гишүүний 253 нь мажоритар сонгогдоод,

47 нь яг Монгол шиг намын жагсаалт байгаа юм.

Өөрөөр хэлбэл намын жагсаалттай бодлогын улс төр хийх энэ механизм бол тэр сонгууль дахь мөнгөний нөлөөг багасгадаг, авлигалыг багасгадаг гэдгийг Солонгосын эрдэмтэд хэлж байсан.

Тэгэхээр бид яг дараагийн Улсын Их Хурал дээр юм уу, дараагийн парламентад ер нь энэ нэр дэвшигчийг давамгайлдаг хөрөнгө мөнгөний энэ мажоритар системийг улам цөөлөх шаардлага байна.

Түрүүн Хууль зүйн сайд Б.Энхбаярын хэлсэнчлэн миний хувьд ч гэсэн энэ жил сонгуулийн нэр дэвшигчийн хувьд санхүү асар хүндрэлтэй байгаа.

Гишүүнийхээ тайланг ард иргэддээ би хэвлэмэл байдлаар өгөх боломжгүй байгаа. Санхүүгийн хувьд бол.

Тийм учраас зөвхөн онлайн хэлбэрээр интернэт орчиндоо тайлангаа тавьж байна. Энэ бол сонгуулийн зардал нэмэгдсэн асар том бэрхшээл бол Их Хурлын гишүүд бид нарт тодорхой харагдаж байгаа.

Тэгээд төлөвлөгөөн дээр нэг санал байна. Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч байдаг.

Тэгээд хувь эзэмшдэг компанитай холбоотой хуулийн төсөл өргөн барих, санаачлах гэдэг энэ асуудлыг хориглож байгаа. Энэ зөв.

Дахиад яг өөрийнх нь эзэмшдэг компанитай холбоотой хууль Их Хурал

дээр ажлын хэсэг байх юм бол тэнд ажилламааргүй байгаа.

Энэ нь өнгөрсөн 3 жилийн хугацаанд Боловсролын багц хуулиудыг хэлэлцсэн.

Хувийн сургуультай, хувийн ашиг компанитай тодорхой төлөөллүүд бас л их маргаантайгаар хуулийн энэ юун дээр орж ирсэн.

Тэгэхээр ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах асуудал дээр илүү нарийн заалтуудыг хийх шаардлага байна. Үүнийг Улсын Их Хурлын дэгийн тухай хууль өөрчлөгдөж байгаа. 126-тай холбоотойгоор. Тэр хуульд тусгах ёстой гэдгийг бас хэлмээр байна.

Ингэж байж бид ашиг сонирхол, авлигалын нөлөөг хязгаарласан энэ эрх зүйн хөтөлбөрийг боловсруулах, авлигалыг багасгахад хувь нэмэр оруулна.

Түүнээс биш хөрөнгө мөнгөний нөлөө өндөртэй, ашиг сонирхлын нөлөө өндөртэй байгаа тохиолдолд бид мянга яриад манай авлигалын индекс буурахгүй.

Д.Цогтбаатар: Би ганц үг хэлнэ.

Энэ дээр би түрүүн төрийн дунд шатын албан хаагчдын тухай ярьсан.

Төрийн өндөр албан тушаалтнууд бол угаасаа бүх юм нь ил тод, олон нийтийн нүдэн дээр, хаа ч явсан олны нүдэнд явж байгаа.

Тэглээ ч гэсэн энэ дээр бүх юмыг чангалаад, хариуцлага тооцоод явах нь маш чухал. Энэ дээр өөрөөр хэлбэл анхаарлыг ерөөсөө сулруулж болохгүй.

Гэхдээ энэ завсар энэ рүү бүх анхаарал яваад төрийн дунд албан шатынхныг орхичих юм бол энэ чинь тэнд ёстой жинхэнэ нөгөө авлига цэцэглэх. Тэгээд дараа нь буруугаа тэр дээшээ өөр хүмүүс рүү чиглүүлээд байх орон зайг үүсгэж өгч байгааг бодох хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл бид энэ нийгэмд байгаа авлигатай бүхэлдээ тэмцэх гээд байгаа болохоос биш нэг хэсэг хүн рүү нь анхаарчхаад нөгөө хэдэд илүү анхаарлыг нь нөгөө тийшээ явуулчихлаар.

Ер нь хармааны хулгайч анхаарлыг нэг тийшээ сарниулж нөгөө хармаанаас нь хулгайлдаг шүү дээ.

Тэгэхээр төрийн өндөр албан тушаалтнуудыг анхаараад явлаа гэхэд нөгөө талдаа сулруулчих юм бол нийгэмд авлига чинь зогсохгүй л байгаа байхгүй юу. Нийгэмд авлига зогсох ёстой.

Одоо тэр зүгээр нэг төмөр замын нэг хэлтсийн дэд даргын өрөө билүү. Тийм ээ. Гэрээс нь гарч байгаа мөнгө гэхэд хүний толгойд багтахааргүй тооны мөнгө л гарч ирдэг болсон байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр би юу хэлмээр байна гэхээр авлигач хүн тэр албан тушаал өндөр, бага ерөөсөө хамаагүй шүү.

Түрүүн хариулт дээр ч гэсэн гарч байна лээ.

Би тэр төрийн дунд албан тушаалтнуудын тухай ярихад ажлаас нь халах тухай л. Үгүй шүү дээ. Энэ дээр чинь халаад зогсохгүй.

Мэдээжийн хэрэг өнөөдөр Эрүүгийн хуулиараа ял үүрүүлээд л явж байгаа. Тэр чинь ч чанга байх ёстой. Түүн дээр анхаарал маш онцгой анхаарч ажиллахгүй бол болохгүй байгаа шүү.

Тийм учраас авлигын индекс буурна гэдэг юуг би яриад байна гэхээр бүх түвшиндээ, авлига авч болзошгүй бүх л этгээдийн хувьд тэр авлига авах нүх сүв хаалттай байх ёстой.

Энэ дээр Авлигатай тэмцэх газрын зүгээс миний нэг хүсэж байгаа юм төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нэгийг ч нэмж байгуулахгүй ээ. Энэ чинь гол эх үүсвэр нь байгаа шүү гээд би яриад байгаа шүү дээ.

Харин танай энэ юун дээр энэ орж өгсөн байна лээ. Энэ аягүй чухал. Энэ үзэл санаа энд орж, үүнийгээ зогсоож. Харин танайх бүр цөөлбө гэсэн байна лээ.

Би хаширлаад улс төрийг яаж явахыг мэдэж байгаа учраас энэ байран дээр нь зогсооё гэхэд үүнийг чинь зөвшөөрөхгүй гацаагаад байгаад байна шүү дээ. Юун буулгах. Та нар буулгана. Сайн байна. Буулгана гэсэн байна лээ.

Гэхдээ наадах чинь тийм амар ажил биш байна лээ. Энэ байдалд нь зогсоох гээд дийлэхгүй байхад чинь юун буулгах. Асуудал чинь бодит байдал дээрээ тийм байгаа.

Тэгэхээр энэ дээр бодлогын тэр экспертийн түвшний дэмжлэгийг манай тогтоолыг гаргахад үзүүлж, холбогдох баримт бичгүүдийг бид нарт нэмж гаргаж өгөөрэй гэдэг юмыг хүсмээр байна.

Ингээд энэ тогтоолтой холбогдуулан үг хэлэх гишүүд үгээ хэлж дууслаа.

Одоо ингээд санал хураалт явуулъя. Манайхан анхааралтай байгаарай.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн гишүүн танилцуулчих уу? Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.

Дөрөв.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй танилцах

Дөрөвдүгээр асуудал. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй танилцъя.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газраас хийсэн эрх зүйн дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Б.Болдбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын дарга.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн эрх зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар танилцуулна.

Б.Болдбаатар даргад микрофон өгье.

Б.Болдбаатар: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Эрх зүйн дүгнэлтийг танилцуулъя.

Эрх зүйн дүгнэлт 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр. Дугаар 01. Улаанбаатар хот.

Эрх зүйн дүгнэлт гаргах үндэслэл, хүрээ, хязгаар.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэн дэмжсэн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар уг төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр Байнгын хорооны гишүүд төсөлтэй холбогдуулан эрх зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэж үзээд Хууль зүйн байнгын хорооны даргаас 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай албан бичиг ирүүлсэн.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу эрх зүйн дүн шинжилгээ хийж Монгол Улсын Үндсэн хууль бусад хуультай нийцэж байгаа эсэх, төслийн зүйл, хэсэг, заалтад хоорондоо зөрчилдсөн эсэх, төслийн хэрэгжих боломжийн талаарх дараах эрх зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Нэг. Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээ конвенцтой нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д “Монгол Улсын иргэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гэж заасан.

Мөн хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

Энэхүү эрх, үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах, эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хил заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээн авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.” гэж.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 19 дүгээр зүйлийн

1-д “хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”.

2-т “хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”. Энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайж, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

3-т энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг хариуцлага оногдуулна.

Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой.

а.Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

б. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах гэж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн агуулга, хэрэгжих орон зай, арга хэлбэрийг тодорхой зохицуулсан байна.

Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх арга бөгөөд нөгөө талаас Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалан бэхжүүлсэн эрх чөлөө юм.

Үг хэлэх эрх чөлөө нь өөрийн бодол санааг амаар болон бичгээр, бусад сонгосон арга хэлбэрээр илэрхийлэх хүний үндсэн эрх юм.

Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжил нийгмийн сүлжээ нь энэ эрхийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг баяжуулсаар байна.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрхэн илэрхийлээс хамаарч бусдын эрх эрх чөлөөг хөндөж болох учраас уг эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу

- 1-д нь, *Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх,*
- 2-т нь, *Үндэсний аюулгүй байдал,*
- 3-т нь, *Нийгмийн дэг журам,*
- 4-д нь *Хүн амын эрүүл мэнд,*
- 5-д нь, *Ёс суртахууныг хамгаалах*

шаардлагын үүднээс хязгаарлаж болох юм.

Тухайлбал, хувь хүн, байгууллага, улсын нууцыг хамгаалах үүднээс Нууцын тухай хуулиар болон шүүхийн шийдвэрээр төр болон хэсэгчлэн хязгаарлалт тогтоож болно.

Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад байгаа Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь хүн хуулийн этгээдийн Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд гагцхүү нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх харилцааг хөндсөн байна.

Өөрөөр хэлбэл уг хуулийн төсөл нь Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа хэдий ч олон улсын гэрээгээр зохицуулсан шүгэл үлээгчийг хамгаалах механизмыг бүрэн тусгасан эсэхийг анхаарах нь зүйтэй юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг конвенцыг Монгол Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталжээ.

Тус конвенцын 33 дугаар зүйлд мэдээлэгч этгээдийг хамгаалах талаар оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах тухай заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ гэж заасан байдаг.

Мөн Европын зөвлөлийн Авлигын эсрэг эрүүгийн эрхийн конвенц, Авлигын эсрэг иргэний эрх зүйн конвенц, Шүгэл үлээгчийг хамгаалах талаар зөвлөмж, Америкийн улсуудын холбооны Авлигын

эсрэг Америкийн конвенц, Африкийн холбооны авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх конвенц, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хахуулийн эсрэг конвенц, Олон улсын бизнесийн хэлцэлд хахуультай тэмцэх тухай зөвлөмж, Төрийн албан дахь ёс зүйн дүрмийг сайжруулахтай холбоотой зөвлөмж зэрэг баримт бичгүүдэд мэдээлэгч этгээд буюу шүгэл үлээгчийг хамгаалахдаа олон улсын стандартыг тогтоож өгсөн гэж үздэг.

Эдгээр баримт бичигт авлигатай тэмцэх хүрээнд шүгэл үлээгчийг хамгаалахдаа хууль тогтоомжийн болон зохион байгуулалтын хувьд дараах асуудалд зайлшгүй анхаарах ёстой гэж үзжээ. Үүнд:

Нэгдүгээрт,

-Шүгэл үлээгчийг хэрхэн тодорхойлох;

Хоёрдугаарт,

-Ямар мэдээлэл өгөхөд шүгэл үлээгчийг хамгаалах;

Гуравдугаарт,

-Шүгэл үлээгч хэнд мэдээлэх;

Дөрөвдүгээрт,

-Шүгэл үлээгчийг хэн хэрхэн хамгаалах.

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод мэдээлэгч этгээд буюу шүгэл үлээгчийг явцуу хүрээнд тодорхойлохоос зайлсхийж дараах этгээд шүгэл үлээгч байж болохоор зохицуулжээ. Үүнд:

Нэгд, төр, хувийн салбарт ажиллагч;

Хоёрт, олон нийтийн төлөөлөл;

Гуравт, гэрч, хохирогч;

Дөрөвт, шинжээч.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэлтэй холбоотойгоор төрийн байгууллагад хандаж шүгэл үлээх боломжтой байхаар тусгасан нь олон улсын дээрх баримт бичгийн зарчимтай нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл дээрх олон улсын гэрээ, конвенц, баримт бичгүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул учруулах, эрх мэдлээ урвуулан ашиглах, төсвийн хөрөнгийг хууль бусаар ашиглах болон эдгээр үйлдлийг нуун дарагдуулах зэрэг нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал үүссэн талаарх мэдээллээр шүгэл үлээх эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй талаар дурджээ.

Шүгэл үлээх үндсэн зорилго нь хууль бус үйлдлийг зогсоох, тэрхүү хууль бус үйлдэлд арга хэмжээ авах бөгөөд шүгэл үлээх буюу мэдээллийг илчлэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үздэг байна.

Жишээлбэл, хууль бус үйлдлийг мэдээлэх гурван үндсэн арга зам байх нь зүйтэй талаар “Европын Зөвлөл”-ийн зөвлөмжид:

- 1.Ажлын байрандаа буюу дотооддоо мэдээлэх;
- 2.Эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- 3.Гадагшаа буюу олон нийтэд мэдээлэх гэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.6.5-д авлига, албан тушаалын гэмт хэргийн

мэдээлэл хүлээн авах, нууц хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна гэж Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын тогтоолын хавсралт⁸ Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 92-т Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төслийг Хууль зүйн дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар хамтран боловсруулж Засгийн газар өргөн барихаар заасан.

Ингэхдээ хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны товч утгыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлага татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болгох гэж тус тус тусгажээ. Иймд:

1. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг Улсын Их Хурлын тогтоол, олон улсын гэрээ, конвенцод заасан зарчим, зөвлөмжийн хүрээнд нийцүүлэх асуудлыг анхаарах шаардлагатай.

2. Хуулийн төсөл бусад хууль тогтоомжтой болон төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо нийцэж байгаа эсэх.

Нэг. Төслийн хамрах хүрээ нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох,

нийтийн эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих талаар.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан.

Өөрөөр хэлбэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар зүйлийн 3.1.1-д зааснаар “нийтийн ашиг сонирхол гэдэг нь нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид, тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг” гэж.

Нийтийн албан тушаалтан гэдэг нь мөн хуулийн 3.1.4 дэх заалт болон Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан төрийн, улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч, бүх шатын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, эрх бүхий байгууллагаас баталсан

жагсаалтад заасан албан тушаалтан болно.

Уг хуулийн төслөөр шүгэл үлээгч, мэдээлэл гаргагч нь зөвхөн дээр дурдсан төрийн албан тушаалтнуудтай холбоотой нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдлийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдээлэл гаргаж болохоор хүрээ хязгаарыг хумьсан бөгөөд энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгаагүй байх гэсэн хуулийн төслийн агуулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангах нь зөв юм.

Учир нь шүгэл үлээх нь хүн бүрд нээлттэй байхын зэрэгцээ нийгмийн аль ч салбар тухайлбал, төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллага, хувийн хэвшилд үйлдэгдэж буй хууль бус үйлдэл, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл мөн адил хамаарах нь зохистой юм.

Хоёр.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтын Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан төрийн нууцыг хамгаалах ажилтан танилцах эрх бүхий этгээдийн танилцсан төрийн нууцад хамаарах мэдээлэл нь уг хуулийн үйлчлэх харилцаанд хамаарахгүй гэсэн нь төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 болон Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй гэж.

Мөн зүйлийн 8.2 дахь хэсэгт энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамаарах

тухай хуулиар тогтоосон хязгаарт хамаарахгүй гэсэнтэй мөн зөрчилдөж байна.

Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалтын зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх гэснийг, мөн зүйлийн 29.1.10 дахь заалтын шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэнтэй нийцэхгүй байна.

Гурав.Төслийн хэрэгжих боломжийн талаар.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд төрийн болон албаны нууцтай холбоотой мэдээллийн цар хүрээг өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд холбогдох мэдээллийг төрийн нууцад хамруулах шалгуур эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатайгаас гадна нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн хөндөж буй мэдээллийг төрийн нууцад хамааруулсан гэх нөхцөл байдлын улмаас Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль бүрэн утгаараа хэрэгжихгүй.

Учир нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн нууцтай холбоотой асуудлаарх Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлсон бөгөөд уг зүйлийн 11.5-д мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах зэрэг нь Засгийн газрын бүрэн эрхэд хамаарахаар хуульчилсан.

Гэвч Засгийн газар төрийн болон албаны нууцын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-д төрийн болон албаны нууцтай холбоотой журам зааврыг батлах гэж заасны дагуу аливаа мэдээллийг

нууцад хамруулах хуульд заасан бүрэн эрхээ Засгийн газраас журам гаргах замаар доод шатны байгууллагууд руу шилжүүлсэн байдаг.

Ийнхүү журам гаргах үндэслэлд хүрээ хязгаарыг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу Засгийн газрыг нууцтай холбоотой зарим иргэн хуулийн этгээдээс урамшуулах журам, 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу нууцын мэдээллийн сан байгуулах, ашиглах журам, 16 дугаар зүйлийн 16.7-д заасан нууцын зэрэг тогтоох журам, 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу нууцыг ил болгох журам, нууцын хамгаалалтыг хянан шалгахтай холбоотой журам зэргийг батлахаар хуульчилжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг баталсан бөгөөд энэ журмын 1 дүгээр хавсралтын 3.1.1-д байгууллага нь өөрийн үйл ажиллагааны явцад боловруулсан, бүтээсэн буюу хүлээн авсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.2, 14.1-д заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны батлан гаргасан нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг үндэслэн нууцална гэж заасан.

Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг үндэслэн аливаа мэдээллийг нууцад хамруулах шийдвэр гэж гаргаж болохоор тусгажээ.

Тодруулбал, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад оруулах мэдээллийн жагсаалтыг Засгийн газар батлах эрхтэйгээс гадна энэ жагсаалтын хүрээнд багтаж байгаа гэх мэдээллийн хүрээнд аливаа төрийн

байгууллага тус бүр мэдээллийг нууцад оруулах шийдвэр гаргах эрхтэй байх журмыг Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан нь төрийн байгууллагын удирдлага ямарваа нэг мэдээллийг төрийн нууцад оруулах шийдвэрийг бие даан дур мэдэн гаргах эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.

Иймд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2.2-т заасан Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан төрийн нууцыг хамгаалах ажилтан танилцах эрх бүхий этгээдийн танилцсан төрийн нууцад хамаарах мэдээлэл нь уг хуулийн харилцаанд үйлчлэхгүй байхаар тусгасан нь Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Засгийн газраас тогтоосон уг хуулийг дагаж мөрдөх журмын дагуу шүгэл үлээгчийн гаргасан аливаа мэдээллийг тухайн төрийн байгууллага төрийн нууцад хамруулах.

Ингэснээр уг асуудал нь хуулийн шаардлагад нийцээгүй гэх үндэслэлээр шүгэл үлээгч хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй шүгэл үлээх мэдээллийн хүрээ хязгаарыг хумьсан.

Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн талаарх олон улсын зарчим буюу Тшваны зарчимд /The Tshwane Principles/ нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь мэдээллийг нууцлах сонирхлоос илүү чухал байгаа тохиолдолд тийнхүү мэдээллийг нууцлах үүргээ зөрчсөн гэх төрийн албан хаагчийг шүгэл үлээгчтэй адилтган үзэж хамгаална гэж заасан.

Энэ зарчим нь Данийн эрх зүйн эрүүгийн хууль, Канадын мэдээллийн аюулгүй байдлын тухай хуульд тус тус баталгаажсан байдаг.

Мөн Европын Зөвлөлөөс шүгэл үлээгчийг хамгаалах хүрээг хязгаарлах нь хуулийн зохицуулалт үл итгэх байдлыг нэмэгдүүлнэ гэж онцолсоныг харгалзан үзэх шаардлагатай.

Дүгнэлт.

1. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үйлчлэх хүрээ буюу шүгэл үлээгч нь зөвхөн төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдлийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдээлэл гаргана гэж мэдээллийн хүрээ хязгаарыг хумьсан нь.

Мөн Төрийн алба болон Албаны нууцын тухай хуульд заасан төрийн нууцыг хамгаалах ажилтан танилцах эрх бүхий этгээд танилцсан төрийн нууцад хамаарах мэдээлэл нь уг хуулийн харилцаанд үйлчлэхгүй байхаар тусгасан нь дээр дурдсан Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцтой бүрэн нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т заасан Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэснийг даган биелүүлж, хуулийн төслийн хэрэгжих боломж, хүрээ хязгаарыг нээлттэй болгох, шүгэл үлээгч нь төрийн болон албан нууцад хамаарах асуудлаар мэдээлэл гаргасан тохиолдолд хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй бус харин энэ талаар зохицуулалтыг уян хатан болгож боловсруулах шаардлагатай.

2. Авлига албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууц хадгалах тогтолцоог бэхжүүлж энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдүүлж, авлигаас урьдчилан

сэргийлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулах бодлогын хүрээнд гаргасан Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52, 2021 оны 12 дугаар тогтоолуудад нийцүүлж хуулийн төслийг боловсронгуй болгох шаардлагатай.

3. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн агуулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангах, шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зарчмыг баримтлан Авлигын эсрэг хууль болон төслийн зүйл, хэсэг, заалт хоорондын зөрчлийг арилгах шаардлагатай.

Эрх зүйн дүгнэлтийг танилцуулж дууслаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Болдбаатар даргад баярлалаа.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Л.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би нэг л юм яах гэж байгаа юм.

Ер нь манайхан гол юм нь нууцын журамтай л холбоотой асуудал дээр асуудал байна.

Нууцын журмыг ер нь тодорхой хэмжээнд уян хатан болгож нууцтай холбоотой юмыг шүгэл үлээж болохоор зохицуулах ёстой гэж хэлээд байх шиг байна. Тийм ээ. Үүнийг тодруулж байна.

Ер нь яах вэ улс орнуудын хувьд маш нууцын зэрэглэлтэй юман дээр бас

шүгэл үлээгчийг хориглож байгаа л даа. Жишээлбэл, одоо тэр Ассанж /Julian Assange/, Сноүдэн /Edward Snowden/ эд нарыг Америкчууд араас нь хөөцөлдөөд байгаа шүү дээ.

Тэр чинь шүгэл үлээсэн үү. Үлээчихсэн. Гэхдээ Америкийн Нэгдсэн Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлсөн гэдэг.

Тэгэхдээ иргэдийн төлөө юу. Төлөө. Дэлхий дахины олон хүний эрхийг хамгаалах талаасаа бол зөв юм хийсэн. Гэтэл нөгөө Америкийн төр араас нь хөөцөлдсөн хэвээрээ байж байгаа.

Тэгэхээр яг энэ асуудал дээр л нууцыг бид энэ нууцын тухай хуулийг л бид өмнө нь яриад байсан юм л даа. Байнгын хороон дээрээ хэд хэдэн удаа.

Нууцын хуулиа ер нь яг яаж одоо зөв зүйтэй зохицуулах юм бэ. Төрийн нууцын асуудлыг. Албаны нууцыг гээд.

Тэгэхээр энэ дээр мэдээж хэрэг “маш нууц”-ын зэрэглэлтэй тохиолдолд мэдээж энэ бол байж болно, үлээж болно гэж хэлж болохгүй байх.

Тагнуул, сөрөг тагнуулын үйл ажиллагаа, гадаад бодлоготой холбоотой асуудлууд гээд ингээд юмнууд байж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ асуудал дээр ингээд яг та хэд уян хатан болгоно гээд ингээд хэлчихээр яг үүнийгээ яг ямар хүрээнд хийчихвэл болчихно гээд байгаа юм?

Ямар ч байсан зарим зүйлийг нь ингээд шүгэл үлээж болно гээд нэмэгдүүлээд хэлчихвэл энэ хууль батлагдаж болно гээд байгаа юм уу?

Яг дүгнэлтийг нь ингээд уншихаар ерөнхийд нь нэг тийм юм ингээд харахад бол зөрчил арилгах шаардлагатай. Яг одоо бол ингээд баталж болохгүй гэхихсэн мөртлөө асуудал нь бол жоохон нууцын асуудал дээр байна гээд нэг хэлчихсэн ингэж уншигдаад байна.

Энэ дээр юугаа хэлэхгүй юу? Тийм ээ. Дүгнэлтийнхээ юмыг тодруулж хэлэхгүй юу?

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон өгье.

Б.Болдбаатар: Ж.Сүхбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ бас нэг тийм юм байгаад байгаа юм.

Яагаад гэхээр зэрэг түрүүн би бас дүгнэлт дээр уншиж байсан. Энэ иргэний эрх болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 19 дүгээр зүйл дээр 3 дугаар зүйлд нь хүн бүр санаа бодлоо чөлөөтэй эрх, эрхтэй боловчиг энэ хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг хариуцлага ногдуулна.

Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас хөндөн гарсан байх ёстой гээд энэ дотор одоо түрүүний таны яриад байсан үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах гэсэн хүрээ хязгаар заагаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ мэдээж төрийн болон албан ёсны тухай хуульд байсан маш нууцын зэрэглэлтэй, тэр дундаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар шүгэл үлээх талаар нэлээн нарийвчилж зохицуулж өгөх шаардлагатай гэж үзээд байгаа.

“Transparency International”

байгууллага зэрэг олон улсын байгууллагад гаргасан тэр шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын талаар гаргах олон улсын зарчим гэж байдаг юм билээ.

Түүн дээр бас энэ үндэсний хууль тогтоомжид заасан төрийн болон нууцын хуулиудыг яг шүгэл үлээж байгаа тохиолдолд тэр нууц байх энэ чанар нь алдагдах байж болно гэсэн энэ тайлбарыг, бас зарчим өгсөн байдаг.

Гэлээ гэхдээ саяын дурдсан иргэний болон олон улс төрийн эрхийн тухай фактад хязгаарлалтаа тавиад энэ зохицуулалтаа уян хатан байдлаар зохицуулж өгөх нь зайлшгүй шаардлагатай юм.

Тэгэхгүйгээр бас ингээд ил тавиад өгчихвөл бас хэн болгон ажиллахгүй.

Төслийн тухайд гэвэл төслийн тэр 3.2-т заасан байгаа. нууцыг хадгалж байгаа ажилтан энэ талаар шүгэл үлээж болохгүй гэсэн хязгаарлалт тавьчихсан байгааг энэ дотор бас зохицуулалт хийх маягаар. Үүнээс бусад төрийн албан тушаалтан шүүж үлээж болох ч гэдэг юм уу силкийг хийж өгөөд ингээд явах бас боломж байгаа болов уу гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье. 1 минут.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр энэ бол манай нөгөө индекст нөлөөлж байгаа хууль мөн л дөө.

Тэгэхдээ ерөөсөө манайд чинь бүгд мөнгөний хойноос явж байна. Авлигыг шүүмжилж байна гээд л авлига аваад л, авлигыг илчилж байна гээд л бас нэг талаас мөнгө аваад л.

Ерөөсөө энэ системийн авлига гэдэг чинь нэг зовлонтой болчихсон.

Тэгээд жишээлбэл нууцын ажилтнаас бусад хүмүүс гэж байхад өөрсдөө хууль бус юм хийж хийж явж байснаа сүүлд нь шүгэл үлээж байгаа нэрийдлээр тэрийгээ задалж тавиад л хариуцлагаас зугтах гэдэг ч юм уу, янз бүрийн байдалд орох бас магадлалтай гэдэг ч юм уу.

Тэгэхээр энэ шүгэл үлээлтийн явцад бид нарын нөгөө юу харагдаад байна вэ гэхээр нууцын тэр журам гэхээс гадна албан үүрэгтэй яг хариуцлагатай, ёс зүйн кодиксын асуудлууд. Сая бид ёс зүйн тогтоолоор дүрэм журмаа нэлээн сайжруулчихсан.

Энэ юмнууд ер нь нарийсах шат руу орж ирж байгаа.

Тэгэхгүйгээр үүнийг дандаа урвуулан ашиглах байдлууд энэ цаг үед нэлээн байгааг бас бид анхаарах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон өгье.

Б.Болдбаатар: Тийм.

Тэгэхээр яг түрүүний Ж.Сүхбаатар гишүүний хэлснээр бас нууцын тухай хуулиуд дээр яг энэ тохиолдолд шүгэл үлээгч шүгэл үлээсэн тохиолдолд тэр нь хэн үлээж байгаагаасаа хамаараад, хаана яаж үлээж байгаагаасаа хамаараад бас нууцын асуудлаа нарийн зохицуулах шаардлага байгаад байгаа юм л даа.

Ерөнхий зарчим бол шүгэл үлээхэд хэн үлээх вэ, хэнд үлээлгэх вэ, хэзээ хаана үлээх вэ гэдэг энэ шаардлагууд байж байгаа.

Зүгээр яг хуульд зааснаар манай өргөн барьсан хуулийн төсөлд 5 субъект шүгэл үлээж байгаа мэдээллийг хүлээж авахаар зааж байгаа.

Зааж байгаа хүрээнд энэ байгууллагуудын нууцтай холбоотой асуудлууд дээр хэрхэн ямар эрх хэмжээгээ хэрэгжүүлэх юм бэ гэдгийг нь зохицуулалт нь бас тодорхой зааж өгөөгүй байгаа.

Тэгэхээр үүнийг Төрийн болон албаны нууцын тухай хууль. Энэ хууль дээрээ нэмэлт зохицуулалт орох маягаар оруулбал бас болох байх л гэж бодож байна. Тийм.

Д.Болдбаатар: Л.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Л.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ шүүгдэгчийг хамгаалах хуулийн ажлын хэсгийн ахлагчийн хувьд хууль эрх зүйн дүгнэлтийг хүлээж авч байна.

Дүгнэлтэд тодорхой олон улсын гэрээ конвенцыг үндэслэн тодорхой хуулийн явцуурсан заалт энэ тэрийг гаргаж тавьсан нь их зүйтэй байна.

Тэгээд нэг асуулт байгаа юм.

Энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.2-т заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх ёстой гээд.

Энэ заалтад Шүгэл үлээгчийн хуулийн маань 3.1.4, 3.1.1 дэхэд нийцэхгүй байна буюу зөвхөн мэдээлэл гаргагч маань төрийн албан тушаалтны холбоотой нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар мэдээлэл гаргаж болохоор байгаа юм.

Энд их олон асуудал байна.

Тухайлбал, байгаль орчны асуудлаар.

Мөн нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон асуудлуудаар дандаа төрийн албан тушаалтантай холбоотой шүгэл үлээхээр байгаа. Төслийн хүсэл маань ингэж орж ирсэн.

Зүгээр эрх зүйн дүгнэлтээр энэ төслийн агуулга маань явцуу байгаа учраас бүх салбарт шүгэл үлээж болохоор өргөжүүлээч ээ.

Тухайлбал, төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил зэрэгт үйлдэгдэж байгаа үйлдэл гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг мөн адил хамрах нь зохистой гэсэн байна.

Үүнтэй санал нэг байна.

Энэ дээр нэг асуулт байгаа юм. Ингэж хуулийн үйлчлэх хүрээгээ өргөжүүлснээр яг тэр бүх салбарт хууль хэрэгжүүлэх төрийн гол институт маань хүрч ажиллах боломж нөхцөл хэр байгаа бол?

Ер нь хувийн компаниудад. Жишээлбэл, манай хуулийн ажлын хэсгийн ажиллаж байх хугацаанд үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас тодорхой өргөдөл, гомдлууд ирж байгаа юм.

Жишээлбэл, олон ажилчинтай тодорхой хувийн компаниуд үйлдвэрчний эвлэлийнхээ тавьсан шаардлагуудыг биелүүлдэггүй.

Эсвэл тухайн үйлдвэрчний эвлэлийн гишүүний өгсөн шаардлагыг хүлээж авчхаад тухайн үйлдвэрчний

эвлэлийн нөгөө эрх зүйн байдлыг дордуулах буюу ажлаас нь чөлөөлөх, эсвэл ажлынх нь цех, тасгуудын хороонд шилжүүлэх зэрэг юмнууд одоо хүртэл байгаа.

Энэ тал дээр бид үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтарсан хуралдаан хийж байсан юм.

Тэгэхээр ер нь хувийн компаниудад энэ шүгэл үлээх боломжийг өгөх нь манай төрийн холбогдох байгууллагуудын нөөц боломж хэр байх вэ? Энэ тал дээр ямар дүгнэлт ер нь байгаа юм бэ?

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон өгье.

Б.Болдбаатар: Л.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын зохицуулалтын хувьд мэдээлэгч этгээд буюу шүгэл үлээгч гэдгийг явцуу хүрээнд тодорхойлохоос зайлсан байдаг юм билээ.

Тэгэхээр энд ямар хүмүүс байх вэ гэхээр төр, хувийн салбарт ажиллагч олон нийтийн төлөөлөл, гэрч, хохирогч, шинжээч гээд энэ бүх хүмүүс хамарч болно гэсэн үзэл баримтлалтай.

Тэр хүрээндээ зөвхөн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан тушаалтан биш хувийн сектор, төрийн бус байгууллагад ажиллаж байгаа хэн бүхэн энэ шүгэл үлээх эрхийг эдлэх ёстой.

Түүнээс гадна энэ хуульд зааснаар зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтантай холбоотой асуудлаар шүгэл үлээх биш мөн төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцдог

хувийн секторын байгууллагууд, мөн түүнчлэн бусад өмчийн хэлбэрийн байгууллагууд, хувь хүний талаар өргөн хүрээнд шүгэл үлээх, тэр дундаа нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн асуудлаар шүгэл үлээх энэ боломжийг нь олон улсын байгууллагын зарчмуудад тунхаглаад заачихсан байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ манай өнөөдөр өргөн барьсан хэлэлцэж байгаа хуулийн төсөл зөвхөн төслийнхөө хамрах хүрээг заасан хэмжээнд биш түүгээр өргөн хүрээнд үүнийг бас зохицуулах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Зүгээр яг энэ төслийг хэрэгжүүлэх боломжийн тухайд гэвэл би энэ эрх зүйн дүгнэлтээр дурдаагүй учраас үүнийг хариулахад түвэгтэй байна.

Энэ дээр нэмэлт тодруулга хийж өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Тийм.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүний микрофон өгье.

Б.Энх-Амгалан: Монгол Улс 1930-аад онд бие биеийгээ матаж баахан шоронд хийсэн байгаа юм.

Тэгээд нөгөө матаасчингууд матсаар байгаад тэгээд их олон хүний эрх ашгийг хохироож, их олон хүний эрх ашиг хөндөгдөж, олон хүний амь нас хохирч, одоо өнөөдөр бид хэлмэгдүүлэлтийн хууль гаргаад нөхөн төлбөр олгоод явж байна л даа.

Энэ шүгэл үлээгчийн тухай хууль дээр нэг юм байгаа юм. 6 дугаар зүйл дээр.

Шүгэл үлээгч мэдээллээ, одоо жишээлбэл монгол хүн бол монгол хэл дээрээ, гадаад хүн бол өөрийн эх хэл

дээрээ, эсвэл сайн мэддэг хэл дээрээ бичгээр өгч болно, цаасаар өгч болно, цахимаар өгч болно гэж.

Тэгээд гадаадын иргэн цахимаар монгол хүнийг матаж болох юм уу? Тэгээд түүнийхээ араас тэр хүн чинь урамшуулал Монголын төрөөс авч болох юм уу?

Тэгээд үүнийх нь араас монгол төрийн эрх бүхий байгууллага шүгэл үлээсэн мэдээлэлд 30 хоногийн дотор хяналт шалгалт явуулж, хяналт шалгалтын үр дүнгийн хариуг өгнө, хойшлуулшгүй ажиллагаа явуулна гээд хуулийн байгууллагууд нь юмны араас хөдлөөд байж болох юм уу?

Энэ чинь монгол хүний үндсэн эрх, эрх ашиг хохирохгүй юу? Хүний эрх8 эрх чөлөө зөрчигдөхгүй юу?

Тэгээд тэр шүгэл үлээсэн нөхөр чинь өөрийнхөө мэдээллийн эх сурвалжаа нууна гэж байгаа юм.

Хэн өгсөн нь мэдэгдэхгүйгээр хуулийн байгууллагууд нь хөдлөөд ингээд дараагийн хэлмэгдлийн эх сурвалжийг, эх үүсвэрийг тавьчих вий дээ. Нэг дэх нь би юм асуух гээд байгаа юм.

Хоёр дахь нь. Энэ 11 дүгээр зүйлд нь байгаа юм. Шүгэл үлээгчийг хариуцлагад татахгүй ээ гэж.

Төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад авлига, ашиг сонирхлын талаар олж авсан мэдээллийн нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээсэн гэж үзвэл төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний мэдээллийг хамгаалах хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалт хамаарахгүй гэж байгаа юм.

Энэ чинь тэгээд төрийн нууцыг, албаны нууцыг, хувь хүний нууцыг ингээд задалж болох юм уу? Энэ хууль дээр.

Тэгвэл нөгөө хүний эрхийг хамгаалсан хүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байгуулсан гэдэг Үндсэн хуулийн зарчим нь хаачих юм?

Яг энэ заалт чинь бол аймаар заалт байна шүү дээ.

Тэгээд бас нэг асуудал байгаа юм. Одоо энэ хуулийн дагуу явах юм бол шүгэл үлээсэн тэр хүнийг тухайн байгууллага, хуулийн байгууллагууд хамгаалалтад авна гэж байгаа юм.

Тэгвэл шүгэл үлээснээс болоод Монгол хүний эрх, эрх ашиг зөрчигдвөл яах вэ? Хэлмэгдвэл яах вэ? Шорон оронд орчихвол яах вэ?

Тэгвэл дараа нь тэрний эрх ашгийг хэн хамгаалах вэ гэдэг гурван юмыг маш тодорхой хариулаадахъя.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Б.Болдбаатар: Б.Энх-Амгалан гишүүний асуултад хариульа.

Тэгэхээр Б.Энх-Амгалан гишүүний асууж байгаа асуулт нь яг энэ эрх зүйн дүгнэлттэй дурдагдаагүй л дээ.

Тэгэхдээ энэ өргөн барьсан хэлэлцэж байгаа төслийн хүрээнд яг Б.Энх-Амгалан гишүүний хэлж байгаа санаа байж байгаа юм.

Цаасан эсвэл цахим хэлбэртэй бичгээр өгөх мэдээллээ гаргана. Эсвэл өөрийн сайн мэдэх өөрийн эх хэл, эсвэл

сайн мэдэх хэл дээрээ бичгээр өгнө гэсэн юм байж байгаа.

Тэгэхдээ энэ бол яг төслийг ингээд уншихад бас гадаадын иргэн өгнө гэж би бас яг тодорхойлсон гэж харахгүй байгаа юм. Тийм.

Тэгэхээр манай Монгол Улс чинь бас үндэсний цөөнхтэй болохоор зэрэг тэрийг л би хэлж байгаа юм болов уу гэж би хувь хүнийхээ хувьд ойлгож байгаа. Тийм. Тийм байгаа.

Зүгээр яах вэ олон улсын зарчимд ер нь хэн бүхэн л шүгэл үлээж болно гэсэн байгаа л даа.

Тэр байтугай тухайн байгууллагадаа дадлага хийж байгаа оюутан ч хүртэл шүгэл үлээх, хууль зөрчсөн нийтийн эрх ашгийг хохироосон асуудал, үйлдэл байх юм бол шүгэл үлээж болохоор тийм зарчимтай юм билээ.

Зүгээр тэндээ зүгээр гадаадын иргэн гэж яасныг бол би сайн мэдэхгүй байна.

Хоёрт нь, тэр 11 дээр төрийн болон албаны нууцтай холбоотой асуудлаар ингээд хамаагүй үлээгээд байх юм уу гэдгийг энэ хууль дээр нэлээн хатуу хаагаад өгчихсөн байгаа.

Тийм учраас эрх зүйн дүгнэлт дээр үүнийг харин илүү их уян хатан нарийн зохицуулж өгөх шаардлагатай гэж дүгнэсэн байж байгаа. Тэр зохицуулалт нь тодорхойгүй учраас.

Тухайлбал, Засгийн газар өөрт олгогдсон эрхийн хүрээнд нууцыг хамгаалах тэр журам батлах хүрээндээ тухайн байгууллага өөрт байгаа мэдээллээ.

Жишээлбэл, шүгэл үлээгчийн хөндөж байгаа мэдээллийг байгууллагын нууцад оруулаад батлуулчих юм бол энэ асуудал нь шүгэл үлээх мэдээлэлд хамаарахгүй болоод ингээд явчих эрсдэлтэй байна гэдгийг бол харин эрх зүйн дүгнэлтэд дурдаад өгчихсөн байж байгаа.

Гуравдугаар асуултын хувьд би хариулж мэдэхгүй байна.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүний сая асууж байгаа зүй ёсны асуултууд л даа.

Хамгийн хэцүү нь, энэ чинь эрх зүйн дүгнэлт.

Байнгын хороогоор бид санаачлаад манай Байнгын хорооноос гаргаж байгаа болохоор.

Таны асууж байгаа асуулт бол хууль санаачлагчаас л асуух асуултууд байгаад байна л даа.

Хэлэлцэгдэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Б.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Эрх зүйн дүгнэлттэй танилцлаа.

Эрх зүйн дүгнэлтээр нэг хөндөгдөж байгаа асуудал бол төрийн болон албаны нууцын асуудлаар шүгэл үлээж болохгүй гэдэг хууль санаачлагчийн үзэл санаан дээр дүгнэлт гаргасан байна.

Яг энэ дүгнэлтээр аваад үзэх юм бол төрийн болон албаны нууцаар шүгэл үлээж тэгээд болно гээд байгаа юм уу, болохгүй гээд байгаа юм уу гэдгийг Улсын Их Хурлын Тамгын газрын эрх зүйн дүн шинжилгээ хийх энэ нэгжээс давсан асуудал л даа.

Үүнийг бид Засгийн газар Хууль зүйн яам хүний эрхийн багц хуулийн төслийг боловсруулж дуусаад одоо Засгийн газар дотроо яамдаасаа санал авах ажил хийгдэж байгаа юм.

Энд нэг хөндөгдөж байгаа 30 хуулийнх нь нэг нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төсөл байгаа.

Ялангуяа албаны нууцыг байгууллагын дарга, гүйцэтгэх эрх мэдэлд байгаа удирдах алба хашиж байгаа албан тушаалтнууд ямар мэдээллийг албаны нууцад авах вэ гэдгийг өөрсдөө дангаараа мэдэж байгаа нь энэ иргэдийн мэдэх эрхийг хязгаарлаад байна гэдэгтэй санал нэг байгаа.

Энэ хүрээ хязгаарыг бол цэгцлэх шаардлагатай гэдэг ойлгомжтой.

Харин төрийн болон албаны нууцын асуудал бол нарийн асуудал. Энд онц чухал нууц, маш нууцын асуудлууд байдаг.

Үүнийг улс болгон болгон нууцаа дэлгээд гаргаад байдаг бол энэ тусгаар улс гэж байхын хэрэг байхгүй.

Өнөөдөр дэлхийд хамгийн том шүгэл үлээгч гэж байгаа Эдвард Сноүденийг бидний эрх, хүний эрх, ардчиллын баталгаа болгож, загвар болгодог Америкийн Нэгдсэн Улсын төр бол “эх орноосоо урвагч гэмт хэрэгтэн” гэж үзсээр байгаа.

Энэ тусгай албаны мэдээллийг задалсан. Дайсагнагч улсад орогносон.

Мөн хамгийн том шүгэл үлээгчийн нэг Эдвард Сноүденийг мөн улсын маш нууц мэдээллийг задалсан эх орноосоо урвагч гэж тэр ардчилсан гээд байгаа улсууд үзээд байгаа.

Тийм учраас олон улсын тэр зөвлөмж, хүний эрхийн асуудал гэдгийг улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр задгай байдлаар тооцоо судалгаагүйгээр, ялангуяа энэ эрх бүхий байгууллагуудын санал, дүгнэлтийг авахгүйгээр хууль тогтоогчид задгай байдлаар ярихад төвөгтэй байх гэж би бодож байгаа юм.

Тийм учраас энэ хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн явцад хэт энэ улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийн аюулгүй байдал, мэдээлэл алдагдах энэ боломж, үүд хаалгыг янз бүрийн санаа зорилгоор, эсвэл мэдэхгүйгээр алдах вий гэдэг дээр миний хувьд санаа зовж байгаа.

Тийм учраас энэ асуудлыг нь тусдаа, шаардлагатай гэвэл хаалттай байдлаар ажлын хэсгийн түвшинд ярьж байж Байнгын хорооны хэлэлцүүлэгт оруулахгүй бол задгай байдлаар ярихад төвөгтэй байна.

Яг энэ төрийн нууцтай холбоотой хэсгийг нь гэдгийг би протоколд тэмдэглүүлж байна.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Энэ хуулийн төсөл дээр байж байгаа мэдээллүүдийг л би яриад байгаа юм л даа.

Шүгэл үлээгч нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж мэдээллийг монгол хэл дээр, эсвэл өөрийнхөө хэл дээр эсвэл сайн мэддэг гадаад хэл дээрээ бичгээр, цаасаар, цахимаар, зайнаас өгч болно л гэж байгаа юм.

Тэгэхээр гадаадаас цахимаар мэйл явуулчхаж болох нь л дээ.

Тэгээд үүнийхээ төлөө Монголын төрөөс 100 мянгаас 1 тэрбум 500 сая төгрөгийн урамшуулал нөхөн төлбөр авах юм байна.

Тэгээд тэрийг нь бүр ингээд заагаад заагаад явчихсан.

- Үүнийхээ төлөө эрх зүйн хамгаалалтад орох юм байна.
- Үүнийх нь төлөө хууль хяналтын байгууллага хойшлуулшгүй арга хэмжээ авах юм байна.
- Үүнийх нь төлөө хууль хяналтын байгууллага 30 хоногийн дотор асуудлыг нь шалгаад таны ирсэн мэдээллийг бид шалгаад ингэлээ гэх юм байна.

Үүний нөгөө талд тэр мэдээллийг хүлээж авчхаад шалгагдаж байгаа иргэний эрх ашиг яаж хамгаалагдах вэ л гэдэг юм би яриад байгаа байхгүй юу. Энэ талаар нэг ч юм байхгүй. Нэг дэх асуудал нь энэ.

Нэг ёсондоо бид матаасчингийн эрх ашгийг 100 хувь хамгаалсан юм гаргах гээд байна шүү дээ.

Тэрний нөгөө талд хүний эрх эрх ашиг гэж юм бас байгаа шүү дээ. Монгол хүний эрх эрх ашиг гэдэг юм байгаа.

Хоёр дахь нь. Одоо хэлээд байгаа энэ төрийн албаны нууц болон байгууллагын нууц, хувь хүний мэдээллийг хамгаалах хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалт энэ хуульд хамаарахгүй ээ л гэж байгаа байхгүй юу.

Би шүгэл үлээсэн юм. Тэгээд наад хуульд чинь төрийн нууц хамаарахгүй, албаны нууц хамаарахгүй, хувь хүний нууц хамаарахгүй гээд ингээд 9 шидийн юм яривал энэ чинь яг цаашдаа юу болох вэ?

Энэ хуулиар эрх ашгаа хамгаалуулна гэдэг Үндсэн хуулийн зарчим хаачих вэ?

Би хоёр дахь нь үүнийг протоколд тэмдэглүүлэх гээд байгаа юм.

Гурав дахь нь юу юм бэ гэхээр энэ хүн чинь тэгээд шүгэл үлээхэд чинь сэтгэл зүйн болоод хууль зүйн зөвлөгөөг Монгол Улсаас авах нь байна шүү дээ.

Жишээлбэл, би өөрөө хэлмэгдэж байна гэж үзэж байгаа хүн яах вэ? Тэгвэл. Тэрний эрх ашгийг, тэрний сэтгэл санааны хохирлыг, тэрний эрхийг яг хэн хамгаалах вэ?

Түүний дараа нөхөн төлбөрөө авчхаад тэгээд сүүлд нь яваандаа тэр хүн хэлмэгдсэн байна гэвэл тэр хэлмэгдүүлсэн хүмүүс нь яах вэ? Тэр нь хэлмэгдсэн хүн нь яах вэ?

Монголын төр хууль эрх зүйнхээ хариуцлагыг хүлээж байна гээд одоо энэ хэлмэгдэгчдийн хуулийн дагуу хэдэн төгрөг өгөх байх.

Тэр хохирсон цаг хугацаа, эд хөрөнгө, нэр төр, нийгэмд эзэлж байгаа байр суурь, удам судар яах вэ?

Ийм юмнуудаа бид бас нэг бодож үзэж байж юманд хандах ёстой шүү. Гадаадад ингэдэг юм гээд байдаг.

Хэзээ гадаад улс оронд улсынхаа нууцыг задлаад зогсож байсан юм.

Хэзээ гадаад улс оронд хувь хүнийхээ нууцыг, иргэнийхээ хувийн нууцыг задлаад зогсож байсан юм.

Хэзээ гадаад оронд гаднаас ирсэн цахимын юмаар ингээд сан бүрдүүлээд түүнийхээ араас шуурхай ажиллагаа явуулж шалгаад зогсож байсан юм. Би л лав тийм юм мэдэхгүй юм байна.

Тийм учраас энэ дээр их онцгой анхаараарай л гэж би хүсэж байна.

Д.Цогтбаатар: Хэлэлцүүлэх явцдаа энэ юмнуудаа манай гишүүд сайн яриарай.

Яг энэ дүгнэлтийнхээ хүрээнд, энэ эрх зүйн дүгнэлтээ л гаргах ёстой хүрээндээ гаргасан байгаа. Байнгын хороо маань.

Гэхдээ хэлэлцүүлэх явцад яах аргагүй энэ нууцын асуудлууд яригдана. 1937 оны хэлмэгдүүлэлттэй орон 90-ээд оныг хүртэл бие биеийгээ матан бахархдаг байсан соёл нь ясанд нь.

Тэнд яаж байна? Хахаж цацаад сандарч байх чинь юу болж байна? Би яг л үнэнийг хэлчих үү? Энэ нийгмийн? Тийм.

Тэгэхээр тэр соёл тийм амар салаагүй, алга болоогүй байгаа шүү.

Тэр коммунизмын сүүдэр байсаар байгаа. Хүмүүсийн тархи сэтгэхүйд гүнзгий шингэчихсэн байгаа.

Би үүнийг юун дээрээс хамгийн их тод харж байна гэхээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг би цөөлөхгүй зүгээр хязгаарлая гэхэд л хязгаарлуулахгүй сандарцгааж байгаа хүмүүс шүү дээ.

Тэгэхээр энэ талаасаа үнэхээр авч үзэх хэрэгтэй.

Б.Энхбаяр сайдын түрүүний тэр хэлдэг Эдвард Сноуден нар бол нээрээ улсынхаа дотоод нууцыг гадагшаа гаргаад л цацчихсан байгаа хүмүүс шүү дээ.

Тэгэхээр тийм үүд хаалгыг нээх эрсдэл байгаад байгаа. Энэ юмнуудаа сайн бодох хэрэгтэй.

Тэгэхээр тэр шүгэл үлээгч байх нь энэ нийгэмд ил тод байдал нь аягүй чухал.

Тэгэхдээ нээж байна гээд өөр хамаагүй юмнууд бас задлаад хаячихав уу гэдэг бол асуудлууд байгаа.

Ингээд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх эрх зүйн дүгнэлтийг хэлэлцэж ийнхүү дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орёе.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Тавдугаар асуудал.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Тэгэхээр тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байхгүй байна.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

80.0 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан

Дараагийн асуудал.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцье.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан

сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан болон Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсээс тус тайланд хийсэн шинжилгээг гишүүдэд тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож

байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор Ядамжавын Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хууль зүйн доктор Шагдарын Үнэнтөгс, Хяналт шинжилгээ хариуцсан ахлах референт Далхсүрэнгийн Түвшинтөр, Сургалт хариуцсан референт Ренчингийн Нэнсэндэн, Хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Гиваасамбуугийн Дэлгэрбаяр, Хэвлэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Даваанямын Оюу-Эрдэнэ, Тогтоол шийдвэр, бүртгэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Ганболдын Халиун гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг орж ирсэн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Ядамжавын Цэлмэн танилцуулна.

Я.Цэлмэн гишүүнд микрофон өгье. 2 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга,

Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилье.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд

танилцуулж хэвлэн нийтэлнэ гэж хуульчилсны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хоёр дахь тайланг 2023 онд хийж хэрэгжүүлсэн хяналт шинжилгээ, сургалт сурталчилгаа, олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн ажил, төрийн байгууллагуудын албан ёсны статистик судалгаа, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт болон бусад эх сурвалжид үндэслэн боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 29-нд Хууль зүйн байнгын хорооны даргад өргөн барьж, Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооноос D-Parliament.mn-д байршуулан олон нийтэд танилцуулах, санал авах арга хэмжээг авч ажиллаж байгаад талархал илэрхийлье.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2023 оны тайланг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хууль эрх зүйн орчны шинэтгэл, урьдчилан сэргийлэх хяналт, шинжилгээ, Сургалт, сурталчилгаа, үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажил, Иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлсэн байдал, Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын онцлог, статистикт хийсэн дүн шинжилгээ, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд шийдвэрлүүлэх асуудлууд гэсэн 5 бүлэг дүгнэлт саналын хамт боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар

зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны буюу анхны тайланд хийсэн дүн шинжилгээгээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж хуульд заасан чиг үүргээ богино хугацаанд хэдий ч үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн болно.

Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн тус шинжилгээний үр дүнд тулгуурлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт, түүний үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн 6 асуудал бүхий зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд уг зөвлөмжүүдийг 2023 онд анхаарч заалт бүрийг биелүүлэхэд зорьж ажиллалаа.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаар танилцуулья.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээг хийж байна.

Өөрөөр хэлбэл хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй нөхцөл байдалтай 800 орчим газарт давтагдсан тоогоор жилд 100 мянга орчим иргэн урт, богино ямар нэгэн хугацаагаар байрлаж байгааг холбогдох байгууллагуудаас

авсан статистик дүн мэдээнээс тодорхойлж, түүн дотроос нэн тэргүүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн 37 мянга гаруй хүнд тогтмол хүрэлцэн очиж хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хууль, олон улсын гэрээнд зааснаар хийхийг эрмэлзэж ажиллалаа.

Тайлант хугацаанд хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй Улаанбаатар хот, 21 аймгийн 48 газар тархан байрласан байршилд 17 мянга орчим километр замыг туулан хүрэлцэн очиж, хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж, эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх бүхий л боломжийг нэгтгэн судаллаа.

Хяналт шинжилгээний хүрээнд өөрийн хүслээр гарч байх боломжгүй нөхцөлд байгаа 9542 хүнээс олон улсын жишиг стандарт, өөрийн улсын хууль эрх зүйн орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж авч хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон, баривчлагдсан 675 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийж, 337 ажилтан алба хаагчидтай өөрсдийнх нь хүсэлтээр уулзаж, 2739 хүнд зөвлөгөө өгч, харьяаллын дагуу 66 гомдлыг шилжүүлэн шалгууллаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төв орон нутагт байрлах нээлттэй, хаалттай хорих анги, цагдан хорих анги, байр, төв, баривчлах байр, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, цагдаагийн байгууллагын төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, түр саатуулах байр, баривчлах байр, хүүхэд, ахмад настан, хөрш, хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүсийн асрамжийн газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, цэргийн сахилгын байр зэрэг хуулиар харьяалуулсан бүх газарт хүрч сургалт сурталчилгаа явуулж, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийдэх ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 25 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг тооцон, дүнг талуудад болон олон нийтэд мэдээлж ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны онцлогийг зөвөөр ойлгож, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүний эрхийг хангах, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвх санаачилгатай хамтран ажилласан дээрх албан тушаалтнуудад талархаж байгааг хамт олныхоо өмнөөс уламжилж байна.

Зөвлөмжийн биелэлтийн зарим онцлог үр дүнгээс дурдвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хорих ял эдэлж байгаа хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгайлсан чиг үүргээ биелүүлэхэд шаардагдах зардал буюу цалин хөлс, тээвэр, шатахуун, хорих ял эдэлж байгаа хүмүүсийн хоол хүнс, нормын хувцас, түлш, халаалт, гэрэл цахилгааны зардал болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг Сангийн яамны төсвийн тухай хуулийн хүрээнд тооцон хянаж 38.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр 2024 оны улсын төсвийн төсөлд тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан алба хаагчдын албан

тушаалын ангилал, цолны зэрэглэлийг шинэчилснээр офицер бүрэлдэхүүний үндсэн цалинг 44 хувь, ахлагч бүрэлдэхүүний үндсэн цалинг 48 хувиар тус бүр нэмэгдүүлж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын цалинтай дүйцүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 85 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинээр томилогдсон алба хаагчид 6 сар ажилласны дараа ээлжийн амралт авах, ээлжийн амралт хоорондын хугацаа 6 сараас багагүй байх, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох зэрэг зохицуулалтуудыг тусгаж, хөдөлмөрийн хуульд нийцүүлэн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 218 дугаар тушаалаар “цахим уулзалт” зохион байгуулах журмыг баталж, хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын эргэлт, уулзалтыг цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч цахим хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулсан.

Хорих ангид хорих ял эдэлж байгаа хоригдлуудыг удаан хугацааны турш нэг газар буюу улаан шугамд шаардлагагүйгээр суулгах зөрчлийг таслан зогсоосон.

Хорих ял эдэлж буй хүмүүсээс албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдлыг шуурхай шилжүүлдэг болсон зэрэг онцлох үр дүнг танилцуулж байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах,

хамгаалах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах хуулиудын төслийн хамт боловсруулсан.

Уг хуулийн шинэчлэлд асрамжийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн онцлог, хэрэгцээ шаардлага, нас, бие даах чадвар, эрүүл мэндийн байдлыг харгалзан ангилж төрөлжүүлэн зохион байгуулахаар.

Мөн асрамжийн төлбөртэй үйлчилгээг бий болгох, эсхүл түр хугацаагаар үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 188 дугаар тушаалаар төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журмыг шинэчлэн баталсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 191 дүгээр тушаалаар төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журмыг баталсан.

Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэгсэл, эмийн зардлын норм, нормативын хэмжээг инфляцын түвшин, зах зээлийн бодит үнэ ханш, асрамжийн газруудын саналд нийцүүлэн шинэчлэн боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 130 дугаар тушаалаар баталсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, насны хишгийн мөнгийг өөрөө захиран зарцуулах эрхийг бодитоор хангах хүрээнд Нийгмийн

халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэгт заасан асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журмыг шинэчлэн боловсруулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 154 дүгээр тушаалаар ажлын байрны үнэлгээ хийх журам, үнэлгээ хийх жишиг үнийг баталсан.

Ажлын байрны үнэлгээ хийх журамд шаардлагатай тохиолдолд ажил олгогч, ажилтны хүсэлт, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж болно гэж зааснаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх асрамжийн газруудад ажлын байрны үнэлгээ хийлгэхэд шаардагдах төсвийг 2024 оны төсөвт тусгасан.

Төв аймгийн Батсүмбэр сумаас тус сумын нутаг дэвсгэрт байрлах Ахмад настны үндэсний төв хүртэлх 10.7 километр авто замыг улсын төсвийн хөрөнгөөр барих ажлын өртгийг 2024 оны төсөвт суулгасан зэрэг үр дүнг танилцуулж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, ажиллагсад, эмчлүүлэгчдийн эрхийг хангах, хамгаалах хүрээнд хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйл Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д заасны дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, сэтгэл зүйн болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан тогтоох, гарсан гомдлыг шийдвэрлэх, дарамт үзүүлсэн алба хаагчид хүлээлгэх хариуцлага, авах

арга хэмжээг нарийвчлан тусгаж төвийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 258 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, ажилтны төлөөлөгч болон төвд байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмэгтэй хүмүүсийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах албан тушаалтныг томилон, түүний нэр, харилцах утас, цахим шуудангийн хаягийг эмчлүүлэгч нар болон нийт ажилтанд харагдахуйц газар байршуулсан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд байгууллагын сэтгэл зүйчийн албан тушаалыг бий болгон уг албан тушаалд мэргэжлийн сэтгэл зүйчийг томилон ажиллуулж эхэлсэн байна.

Төвийн 4 клиникт засвар хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангасан түр амрах, хооллох зориулалтын өрөөг тус тус тохижуулсан.

Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ажилтнуудын нормын хувцас, зөөлөн эдлэлийн худалдан авах тендерийн төсөв 2023 онд 69.0 сая төгрөг байсныг 2024 онд 90.0 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Түүнчлэн тендерийн ажлын даалгаварт эмч, ажилтнуудын эрхэлж буй ажлын нөхцөл, ажил үүргийн болон улирлын онцлогт тохирсон ажлын гадуур хувцсаар хангах талаар оруулсан.

Эмч, эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудын цалин хөлсийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгасны дагуу сар бүр тогтсон өдөр болгож хэвшсэн.

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, үр дүнтэй явуулахад цэвэрлэгээний бараа материал, хог хаягдлын уут, аюулгүйн хайрцаг худалдан авах тендерийн хөрөнгө 2023 онд 20.0 сая төгрөг байсныг 2024 онд 85.0 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.

Асрамжийн тасагт байнгын хэвтэн эмчлүүлэгч 200 гаруй өвчтөний нийгмийн халамж, тэтгэврийн тэтгэмжийн мөнгөний зарцуулалтад тавих хяналтыг бий болгож, өөрсдийн хэрэгцээнд бүрэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн төрөлжсөн асрамжийн төвийг байгуулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргаснаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 200 орчим ор суларч, 500 орны бүрэн хүчин чадлаар нийт хүн амд сэтгэцийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа нь хуульд зааснаар идэвхтэй, чиг үүргээ эмнэлгийн удирдлагаас хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, үндэсний ажиллагааг сурталчлах, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлага төлөвшүүлэх, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх 37 удаагийн сургалтыг нийт 19 аймаг, 4 сум, алслагдсан 1 дүүрэг, нийслэлийн 3 дүүргийн төрийн албан хаагчид шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настан, хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын болон түр хамгаалах байрны ажилтнууд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага, эмч, ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, иргэдийг хамруулан нийт 4858 хүний дунд зохион байгуулсан.

Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах 73 сургагч багшийг анхлан бэлтгэсэн бөгөөд сургагч багш нар тус тус өөрсдийн байгууллагын албан хаагч, иргэд, сурагчдын дунд сургалт зохион байгуулж, 1304 хүнийг хамруулсан байна.

Эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн чиглэлээр төрийн албан хаагч нар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын албан хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газраар үйлчлүүлэгч, ажилтнууд, дотуур байрны хүүхдүүд болон эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нийт 675 иргэн, хуулийн этгээдтэй ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн албан өрөөнд давхардсан тоогоор нийт 28 иргэн өөрийн биеэр хүрэлцэн ирж уулзалт хийж, зөвлөгөө авсан байна.

Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан **“Эрүү шүүлтгүй**

Монголын төлөө” сэдэвт зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг хоёр дахь жилдээ холбох төрийн байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, нийт 50 хүний дунд зохион байгуулсан.

Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан **“Шогч бийр”** шог зураачдын холбоотой хамтран ажиллаж эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлүүд, тэдгээрийн хор аюулыг таниулан сурталчилсан 74 гар зургаар үзэсгэлэн гаргаж Улаанбаатар хот, 21 аймагт олны хүртээл болгожээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа цахим хуудсыг үүсгэн байгуулж, тухайн цахим хуудсаар үйл ажиллагаагаа сурталчлан ажилласнаар нийтдээ давхардсан тоогоор 211 мянган иргэдэд мэдээлэл хүрсэн бөгөөд одоогийн байдлаар 50 гаруй мянган байнгын дагагчтай болсон байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний чиг үүргийн дагуу нийтэд мэдээллийг тухай бүр олон нийтийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудаар хүргэж ажилласан.

Хүүхэд, өсвөр үеийнхэн дунд зориулсан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анимэйшнийг бүтээн мөн социал орчинд түгээж ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийсэн ажил.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүргийнхээ хүрээнд зөвлөмжийн

хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа Эрүү шүүлтийн эсрэг конвенц нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн явуулахад анхаарч, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай олон талт түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллалаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын албаны Монгол Улсыг хариуцсан ажилтан Себастьян Гиёотой уулзаж Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон эрүү шүүлт тулгах бусад хэлбэрээр хэрцгий буюу хүнлэг бусаар харьцах, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үйл ажиллагааг хамтран зохион байгуулах талаар санал солилцсон.

ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хүний эрхийн чиглэлээр албан хаагчийг Япон Улсад сургасан.

КОЙКА олон улсын байгууллагатай хамтран ажиллахаар санал солилцож хамтран сургалт хэрэгжүүлэх төсөл хүргүүлж ажиллаад байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд хамтран ажиллах боломжтой олон улсын байгууллагын мэдээллийн санг үүсгэн хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон бөгөөд харилцан туршлага солилцох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх шинэлэг арга барилаас судлах, нутагшуулах зорилгоор Бүгд Найрамдах Словени Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нэмэлт протоколоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлж буй

амжилт ололтоос туршлага судлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийдэх, түүнтэй тэмцэх зорилгоор олон улсын хүний эрхийн байгууллагуудын дунд Копенхаген хотноо зохион байгуулагдсан хурлаар Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцож ажилласан байна.

Нийт иргэд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шалгуулсан талаар.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд анх үйл ажиллагаа эхэлж байхад 6 гомдол ирж байсан бол өнгөрсөн жилийн хугацаанд нийт 66 гомдол, мэдээллийг эрүү шүүлтийн улмаас хохирсон талаарх мэдээлэл зонхиллоо.

Иргэд хуулийн этгээдээс ирүүлсэн тэдгээр гомдол, мэдээллийг хүлээн авч танилцан эрх нь зөрчигдсөн гэх 19 иргэнтэй биечлэн уулзаж эрх зүйн туслалцаа үзүүлэн зарим санал, хүсэлтийг эрх бүхий албан тушаал дээр даруй шийдвэрлүүлсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад зохих хугацаанд нь албан бичгээ шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Тухайлбал,

- Улсын Ерөнхий прокурорын газарт

болон холбогдох албан тушаалтанд
15 гомдол, мэдээлэл,

▪ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт болон харьяа газрын холбогдох албан тушаалтанд **13** гомдол, мэдээлэл,

▪ Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтанд **12** гомдол, мэдээлэл,

▪ Цагдаагийн ерөнхий газрын болон харьяа албадад **2** гомдол, мэдээлэл,

▪ Шүүхийн сахилгын хороонд **1**,

▪ Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төвд **1**-ийг тус тус шилжүүлэн шалгуулжээ.

Гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтэд бид мөн хяналт шинжилгээ хийж ажилласан.

2022 оны статистик байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл буюу хууль бусаар баривчлах, 14.1 буюу ялгаварлан гадуурхах, 21.12 буюу эрүү шүүлт тулгах гэмт хэргүүдийн тухай гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаар Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн мэдээгээр 2017 оны сүүлийн хагас жил 2018-2022 онд нийт 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэн 471 хүн шалгагдсанаас 359 гомдол мэдээлэлд буюу 93.2 хувьд хууль сахиулах байгууллагын албан хаагч холбогджээ.

2023 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн дээрх төрлийн хэргүүдэд 87 гомдол, мэдээллийн 64 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 20 гомдол,

мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 3 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж яллагчаар татагдсан байна.

Дээр дурдсан 87 гомдол мэдээлэлд мөн дийлэнхэд нь цагдаагийн байгууллагын албан хаагч холбогдон шалгагджээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиглэлээр хийж хэрэгжүүлсэн дээрх ажлын хүрээнд дараах саналыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж байгааг танилцуулъя.

3 багц саналыг бид авч үзэж Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж байна.

1.Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколд нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

2.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмэгтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ахмад настанд төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлэх.

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд заасан сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн үйлчилгээг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж, төрөлжсөн асрамжийн бүтэц бий болгох.

3.Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж цагдан

хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй байх тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийдэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх гэсэн эдгээр саналыг хүргүүлж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан, түүнд тусгасан асуудлын хүрээнд холбогдох шийдвэрийг гаргаж өгнө үү.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

Д.Цогтбаатар: Я.Цэлмэн даргад баярлалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсээс хийсэн шинжилгээг хэлтсийн дарга Г.Болорсүх танилцуулна.

Г.Болорсүх даргад микрофон шилжүүлье. 3 дугаар микрофон.

Г.Болорсүх: Эрхэм байнгын хорооны дарга, гишүүд ээ,

2023 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний танилцуулгыг танилцуулъя.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2023 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх 4 сэдэв бүхий тайланг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн байна.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээг хийсэн.

Уг шинжилгээг хийхдээ асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33-аас 34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон баримт бичгийн хүрээнд дүн шинжилгээ хийх арга замыг ашиглан шинжилгээ хийсэн.

Шинжилгээний тайлан бүхий 20 хуудас, 10 заалт бүхий зөвлөмжийг

Байнгын хорооны гишүүд Та бүхэнд хүргүүлсэн болно.

Шинжилгээтэй холбоотой дүгнэлтийг товч танилцууля.

Тайлант хугацаанд зохион байгуулсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүрсэн үр дүн, үйл ажиллагааны ахиц дэвшлийн талаар шинжилгээ хийж дүгнэхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй байсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, төсөвтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Хүний эрхийн Үндэсний Комисс дотор үүссэн дотоод үл ойлголцол тайлант хугацаанд мөн үргэлжилсэн хэвээрээ байсан. 2022 оны тайлант хугацаатай холбоотой.

Өөрөөр хэлбэл 2023 онд уг асуудлыг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайланд тодорхой дурдаагүй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь 2022 онд хуульд заасан бүх газарт шинжилгээ хийнэ гэсний дагуу бүрэн шинжилгээг хийгээгүй дутагдалтай ирүүлсэн байсан.

Өөрөөр хэлбэл хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар болон сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт, түр саатуулах болон хамгаалах байруудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй.

Мөн 2022 онд хяналт шинжилгээ хийсэн байгууллагуудад 2023 онд ямар үр дүн гарсан нь тодорхойгүй.

Хяналт шинжилгээ хийсний үндсэн дээр дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцөлийг бодитой, тодорхой ажил хийгдээгүй гэж үзэхээр байна.

Зөвхөн хяналт шинжилгээний хүрээнд зөвлөмж хүргүүлэх хэмжээнд ажилласан байна.

Харин цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх түр саатуулах байрны нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийсэн хэдий ч эдгээр байранд ажиллаж байгаа албан хаагчид болон үйлчлүүлж байгаа иргэдтэй ганцаарчилсан ярилцлага хийж, асуумж авах зэрэг аргачлалаар хийсэн судалгаа шинжилгээний талаар тодорхой юм тусгагдаагүй байгаа нь бас өмнөх онтой харьцуулахад энэ нь давтагдан гарсан байна.

Тайланд 2023 онд хэрэгжүүлэхээр 2022 онд төлөвлөн бэлтгэл ажил хангаж байсан зарим арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн, ямар үр дүнд хүрсэн талаар бас тодорхой тусгагдаагүй байна.

Хяналт шинжилгээний хүрээнд зохих зөвлөмжийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг тодорхой хэмжээнд хангуулан ажиллаж байгаа ч хяналт шинжилгээ тогтоогдсон зөрчилтэй нөхцөл байдлууд давтагдан гарсаар байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа мэдээ мэдээлэл, сурталчилгааны ажлын бодлого, чанар, хүртээмж, мөн үр дүнгүй хангалтгүй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх ном

сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл мөн хангалтгүй, тайлан тодорхойгүй, нарийвчлан тусгаагүй зэрэг дутагдалтай талууд байгаа гэж дүгнэсэн байна.

Товчхон дүгнэхэд байна. Дууссан. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны дүгнэлтийг танилцууллаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү?

Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Эрүү шүүлтийн эсрэг хараат бус комиссын маань жилийн ажлын тайлан гарсан байна.

Энэ дээр ингээд үзэхэд эрүү шүүлт тодорхой асуудлаар, тодорхой мөрдөн байцаах шат, эсвэл тодорхой төрийн албан хаагч буюу цагдаагийн хуультай холбоотойгоор байсаар байгаа нь үнэхээр харамсал төрүүлж байна.

Ер нь нэлээд ил олон гомдол иргэдээс ирсэн байна. Эрүүдэн шүүсэн асуудлаар.

Эдгээрийн нэлээд нь тэр Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн сахилгын хороонд ирсэн байна.

Тэгэхээр ер нь Монгол Улсад эрүүдэн шүүлтийн эсрэг механизм маань

яг ажиллаж байгаа боловч яг юу юу болохгүй байна аа?

Энэ дээр тодорхой албан хаагч, эсвэл Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, эсвэл мөрдөн байцаагч гэдэг юм уу, хувь хүний хүчин зүйлийн нөлөө байна уу? Эсвэл ер нь тогтолцоо нь өөрөө сайжруулах, өөрчлөх шаардлага байна уу?

Бид Эрүүдэн шүүлтийн эсрэг олон улсын конвенцын нэмэлт протоколуудад нэгдэн орсон. Түүний дагуу бид “хараат бус, эрүүдэн шүүлтийн эсрэг механизм байгуулан ажиллаж байгаа” гэж үзэж байгаа.

Гэтэл энэ механизм маань үйл ажиллагаа нь хэр байна гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын энэ өнгөрсөн жилийн түүхэн дэх хамгийн том ноцтой эрүүгийн хэрэгт яллагдаж, бүх шатын шүүхээс цаазаар авах ял заагдсан хүнд гэмт хэргийн сэжигтэн гэдгээр явж ирсэн нөгөө Чимгээ, Содномдаржаа хоёрын асуудал үнэхээр хүний эрхийн болон эрүүдэн шүүлтийг ашиглаж хэргийг тулган хүлээлгэсэн асар ноцтой том кэйс байгаа.

Энэ Монголын шүүх, Монголын хүний эрхийн нөхцөл байдлын хамгийн том хар толбо байна.

Тэгэхээр энэ хохирогч буюу Чимгээ маань саяхан Монголын төрөөс эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт тулган хүлээлгэсэн гэдгээр сэтгэл санааны болон амь амьдралынхаа төлөө асар хохирол учруулсан гээд 40 гаруй хэмжээний тэрбум төгрөг нэхэмжилсэн байгаа.

Энэ хохирлыг нөхөн барагдуулах тал дээр манай Эрүүдэн шүүлтийн эсрэг

үндэсний хараат бус комиссар маань хэрхэн хандаж, ямар байр суурьтай байгаа вэ?

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2022, 2023 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны харьцуулалтыг бид хийсэн. Тайланд байгаа.

Бидний үйл ажиллагаа өнгөрсөн оныхоос энэ онд 1.1-ээс 4.4 дахин бүх үзүүлэлтээр өссөн үзүүлэлттэй байгаа. Бүх үзүүлэлтээр өссөн.

Үүнийг хяналт шинжилгээ хийсэн хүрээнд тайланд хангалтгүй тусгасан байна гэж үзэж байх шиг байна.

Бид эргээд тайлангаа сайн тодруулъя.

Ерөнхийдөө бидний хүрэлцэж очих ёстой газар одоогийн байдлаар тогтоосон 843 газар байгаа. Монгол Улсад. Ингээд 21 аймагтай тойрон байрласан.

Гэтэл бид яг энд байгаа нийт 140 орчим мянган хүндээ жилдээ хүрч очих шаардлагатай.

Одоогийн байдлаар бид 5-уулаа үйл ажиллагаа явуулж байна. Анх Засгийн газар яг Эрүүдэн шүүхийн эсрэг энэ конвенцын хэрэгжилтийн тайланд тайлан хүргүүлэхдээ Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг гишүүн, түүнээс гадна 10

албан хаагчийн хамт төсвийн хараат бус төсөвтэйгөөр гээд тайлан явуулсан.

Тэр хүрээнд 10 албан хаагчийн орон тоо батлагдсан.

Ингээд хоёр дахь жилдээ бид 50 хувиараа л ажиллаж байгаа. Нэг ёсондоо Хүний эрхийн Үндэсний комиссын төсвөөс албан хаагчдын төсвийг одоо болтол тавьж өгөөгүй байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Энэ тогтолцоондоо байна. Энэ хүнтэй холбоотой асуудал биш байна.

Нэгүгээрт, бид Үндсэн хуульд заасны дагуу олон улсын гэрээний үүргээ шударгаар биелүүлэх шаардлагатай.

Бидний нэгдэн орсон гэрээ бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн байгууллагыг байгуулах ёстой гэсэн заалттай. Энд нэгдэж орсон.

Түүн дээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулахдаа дараах бүрэн эрхүүдийг гарцаагүй тухайн улс олгох ёстой гэдэг дээр хүний нөөц, санхүүгийн бие даасан хараат бус байдлыг хангах шаардлагатай гэсэн байсан гэдгийг хэлье.

Ингээд энэ бол тогтолцоондоо нийцүүлж өөрчлөх шаардлагатай гэдгээр хараат бус судлаачдын шинжилгээг Хууль зүйн байнгын хорооны өгсөн чиглэлийн дагуу хийлгэж хүргүүлсэн байгаа.

Энэ дээр хуулийн ямар ямар заалт нь конвенцын заалттай нийцэхгүй байгаа талаар тодорхой дүгнэлт гарсан байна.

Олон жилийн өмнө биш л дээ. Энэ саяхны асуудал. Эрүүдэн шүүгдсэн энэ

хүмүүстэй холбоотой кэйсийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Энэ дээр тодорхой байр суурьтай байдаг. Тэр байр сууриндаа хэвээрээ байгаа.

Хамгийн гол нь эрүү шүүлтийн аюул гэдэг бол өөрөө миний дүгнэж байгаагаар үндсэндээ хоёр аюултай байдаг.

Энэ нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны хувьд шууд илэрдэг.

Нэгдүгээрт, тухайн гэмт хэрэг үйлдээгүй хүнийг үйлдсэн мэт болгодог нь өөрөө хамгийн чухал хортой.

Дараа нь, хэдийгээр тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн байсан ч эрүүдэн шүүж тухайн нотлох баримтыг цуглуулсан бол тухайн нотлох баримт нь шүүхээр үнэлэгдэх хэмжээний нотлох баримтад тооцохгүй гэсэн энэ олон улсын зарчим үйлчилдэг.

Энэ асуудлыг бүгд сайн анхаарах нь зүйтэй.

Ингээд бид яг энэ чиглэлээр таны түрүүний хэлсэн цагдаагийн байгууллагын алба хаагчид дээр энэ асуудал үүсээд байна гэдэг асуудлыг 2022 онд хяналт шинжилгээ хийгээд 2023 онд Цагдаагийн ерөнхий газрын даргад алба хаагчдадаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдуулахгүй байх чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлээ гэсэн зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг тооцсон.

Энэ жил мөн Цагдаагийн ерөнхий газрын даргад яг энэ утга бүхий зөвлөмжийг хүргүүлж хамтран ажилласан.

Ингээд бид тодорхой сургагч багш бэлдэх чиглэлээр Улсын Ерөнхий прокурортой хамтран бүх хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг оролцуулан улсын хэмжээнд 70 гаруй.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофоныг өгчих. Гүйцээгээд хариулья.

Я.Цэлмэн: Ингээд зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллаж байгаа.

Мэдээж Цагдаагийн байгууллага хүн хүч ихтэй байгаа. Мэдээж хамгийн нийгмийн тулгамдсан асуудал дээр хүрч очиж хамгийн анхны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, мөрдөн шалгах ажиллагааг хийж байгаа.

Тийм учраас асуудал байгаа.

Гэхдээ тогтолцооны шинжтэй түрүүний хохирогч нартай холбоотой асуудал яг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулагдсаны хүрээнд бидний хяналт шинжилгээгээр илрээгүй.

Түүнээс бид урьдчилан сэргийлж ажиллаж чадаж байгаа гэж дүгнэж байна.

Гол нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэл, ялангуяа энэ эрүүдэн шүүлтэд өртөж хохирсон хүмүүсийн хохирлыг нэн даруй барагдуулах нь өөрөө хамгийн чухал байдаг.

Хэдийгээр хохирлыг бүрэн барагдуулж чадахгүй ч гэсэн энэ барагдуулах арга хэмжээг даруй авах шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгээд энэ хүрээнд бид саналдаа юу тусгасан бэ гэхээр Эрүү шүүлтийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг

Монгол Улс нэгдэж орсноо мэдэгдэж хүргүүлэхийг Эрүүдийн шүүхийн эсрэг хороонд хүргүүлэхийг уриалж байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Манай улс 2019 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчилж баталсан. Өмнөх парламент.

Тухайн үед энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа, зөвлөмжүүд их хангалтгүй байна.

Ялангуяа улс орныг цочроосон эрүүдэн шүүсэн асуудал болсон. Үүнтэй холбоотойгоор эрүүдэн шүүсэн нь тогтоогдсон төрийн өндөр албан тушаалтнууд Тагнуулын даргаасаа эхлээд шүүхээр орж ял шийтгэгдсэн.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын шүүх тодорхой иргэдийг эрүүдэн шүүсэн байна гэдгийг нотолж шийдвэрээ гаргасан.

Одоо энэ хүмүүс нь 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшинэ гээд яваад байгаа. Ямар нүүрээрээ.

Монгол Улсын иргэний үндсэн эрхийг хуулийн байгууллагад ажиллаж байхдаа гаргаж болдоггүй үйлдлийг гаргасан гэдэг нь шүүхээр тогтоогдсон хүмүүс.

Одоо би жинхэнээсээ хүний эрхийг нь хамгаална гээд яваад байгаа.

Үүнтэй холбоотойгоор иргэд, олон нийтэд олон асуудлууд яригдсан.

Тийм ч учраас 2019 онд баталсан Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд эрүүдэн шүүхийн эсрэг бие даасан, хараат бус комиссарыг байгуулсан.

Энэ хүнд онцгой эрх өгсөн.

Бусад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдэд байхгүй онцгой бүрэн эрхтэй хүн байгаа. Энэ хүн.

Анхны дарга хүн нь одоо энэ Я.Цэлмэг гишүүн ажиллаж байна.

Өнгөрсөн онд би яг энэ тайланг хэлэлцэхэд Байнгын хорооны даргаар ажиллаж байсан.

Ер нь өнгөрсөн онд оруулж байсан санал, дүгнэлт энэ онд оруулж байгаа санал, дүгнэлтэд нэг их ялгаа алга.

Санал, дүгнэлт дээр нэг юм яриад байна.

Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд өөрчлөлт оруулж өгөөч ээ гээд.

Би өнгөрсөн онд өөрт чинь уулзаж хэлсэн шүү дээ. Өрөөндөө. Яг ямар өөрчлөлт Та хүсээд байгаа юм гэсэн чинь би бие даасан мөнгө зарцуулдаг гарын үсэгтэй баймаар байна. Би бие дааж хүн томилдог эрхтэй баймаар байна гэж.

Би боль гэсэн шүү дээ. Өөрийг чинь.

Ажлаа хийх хэрэгтэй шүү дээ.

Монголд байхгүй онцгой бүрэн эрхт комиссар болчихоод би хүн томилдог эрх авмаар байна, би гарын үсэг авмаар байна.

Тэгээд түүндээ гадаад улсын зөвлөмж нь байгаа гэж нэр бариад, С.Одонтуяа гишүүнээр хууль санаачлуулаад, Засгийн газар энэ төслийг дэмжихгүй гэдгээ санал, дүгнэлтээ гаргаад Их Хуралд ирүүлчихсэн байгаа.

Энэ бие даах, салан тусгаарлах санаархалыг дэмжихгүй гэдэг санал, дүгнэлтээ ирүүлчихсэн.

Энэ санал, дүгнэлт буюу энэ хуулийн хэлэлцэх эсэхийг нь Байнгын хороо бараг ирэх долоо хоногт шийдэх байх.

Энэ хэлэлцээгүй байхад Засгийн газарт Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд өөрчлөлт оруулах санал бэлтгэх гэдэг үүрэг өгүүлмээргүй байна.

С.Одонтуяа гишүүн энэ үүргийг нь биелүүлээд ороод ирчихсэн байгаа асуудал байхгүй юу.

Тийм учраас би энэ 9 дүгээр заалтыг хасах саналтай байгаа юм. Энэ дагаж байгаа тогтоолын төслийн.

Хоёрт нь, таны хийсэн гол ажил өнгөрсөн онд С.Зоригийн хэрэгтэй холбоотой Ц.Амгаланбаатарын ял эдэлж байгаа хорих ангид очиж Ц.Амгаланбаатараар баахан асуудал яриулаад цахим орчинд цацсан.

Үүнийг би таныг хийсэн гэж ойлгож байгаа.

Та өөрийн санаачилгаар энэ үйл ажиллагааг зохион байгуулав уу? Хэн нэгний захиа даалгавраар хорих ангид онц ноцтой хэргээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофон Б.Энхбаяр гишүүнд гүйцээж өгье.

Б.Энхбаяр: Эсвэл өөр хэн нэгний захиас даалгавраар очиж энэ ярилцлагыг авч сошиал орчинд цацав уу?

Та мэдээж ямар ч хорих ангид хэнтэй ч хүлээгдэлгүйгээр уулзах, ярилцах эрхтэй байгаа.

Гэхдээ та бичлэг хийгээд, тэндээсээ өөрийн үзэмжээр сонгоод цахим орчинд түгээх эрх танд олгогдсон уу? Та тийм эрхтэй юу?

Өөрөөр хэлбэл тодорхой хэрэг учралын талаар ярьж байна шүү дээ.

Тэнд яригдсан асуудлууд нь тогтоогдоод Б.Хурц нар ял шийтгэгчигдсэн асуудал байна уу, эсвэл шүүхээр Б.Хурц нарыг ял шийтгэгдсэнээс өөр асуудал тэнд яригдсан уу гэдгийг иргэд, олон нийт яаж ялгаж салгаж мэдэх вэ гэсэн асуулт байна.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Б.Энхбаяр сайдын асуултад хариулъя.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хариуцсан энэ гишүүнийг томилж байхад Б.Энхбаяр гишүүн хэнээс ч хараат бусаар хэн нэгэн даргын үгэнд захирагдалгүй үйл ажиллагаа хараат бусаар явуулах механизмыг өөрөө авч явах нь ээ.

Тийм учраас үйл ажиллагааг хараат бусаар явуулахад чинь бид дэмжинэ гэсэн.

Ингээд би таны энэ дэмжлэгт маш их баярладаг.

Өнгөрсөн жил Хууль зүйн байнгын хороонд би бас мөн энэ асуудлыг танилцуулсан.

Гадаад улсын зөвлөмжийн асуудал яриагүй.

Энэ бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, түүний холбогдох Монгол Улсад удаа дараа ирүүлсэн Зөвлөмжийн нэгтгэлийг танилцуулсан.

Түрүүний хэлсэнчлэн Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод заасан үүргийг шударгаар биелүүлнэ гээд заасан.

Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зохицуулалт нь конвенцын зохицуулалтаас өөрөөр байвал конвенцынхоо зохицуулалтыг барьж хүний эрхийг хангаж хамгаална гэсэн зохицуулалт Хүний эрхийн комиссын тухай хуульд өөрт нь байдаг.

Ингээд бид нэгдэн орсон конвенц нь өөрөө энэ хараат бус механизмыг түрүүн хэлсэн, байгуулахдаа төсөв, хүний нөөцийн хувьд хараат бусаар байгуулах хамгийн анхны шаардлагыг тавьсан конвенцод Монгол Улс нэгдэн орсон.

Энэ нэгдэн орсон асуудлыг л би ярьж хуулийг биелүүлэх шаардлагатай гэж үздэг.

Мэдээж онцгой бүрэн эрхтэй гэж байна.

Гэтэл хараат бус байдал гэдэг бол өөрөө яг энэ төсөвтэй холбоотой байдаг юм байна. Яагаад гэхээр бүх үйл ажиллагаагаа явуулах, ялангуяа энэ

гэнэтийн хяналт шинжилгээг хүн өөрөө гарч явах боломжгүй газруудад хийх үед бүх төлөвлөлт санхүүтэй холбогдож учирдаг.

Гэтэл бид 21 аймаг, байгаа бүх газруудад очих шаардлагатай боловч өнөөдрийг хүртэл тодорхой санхүүгийн шууд өөрөө захиран зарцуулах эх үүсвэр байхгүй байгаа учраас үйл ажиллагаагаа хэрхэн төлөвлөх вэ гэдэг нь тодорхойгүй байгаа.

Ингээд үүнтэй холбогдуулаад 114 дүгээр тогтоолыг өнгөрсөн 12 сард Их Хурлаас баталсан.

Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хуулийн заалтуудтай яг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбогдох зохицуулалтад нь нийцэж байгаа эсэх дээр судалгаа хийхийг Хууль зүйн байнгын хороо Хүний эрхийн дэд хороонд даалгасан байдаг.

Энэ дагуу судалгаа хийгдэж гарсан.

Тэгээд таныг Байнгын хороон дарга байхад би мөн энэ асуудлыг өөрт чинь мөн танилцуулж учиртай байна гэдгийг хэлсэн байгаа.

Хүний нөөцийн хувьд хараат бус байхгүй бол өөрөө энэ маш их асуудалтай байдаг юм байна.

Ялангуяа эрүү шүүлттэй тэмцэх, энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа хүмүүс өөрөө сэтгэл зүйн болон бусад байдлаар бүрэн бие даасан байдалд байж ажиллаж чадахгүй бол манайд ажиллаж байсан 2-оос 3 хүн сайн дураараа ажлаасаа гарсан. Ажлын нөхцөл хүнд.

Байнгын хорих анги, бусад эрх зүйн нарийн туслалцаа шаардлагатай хүнд нөхцөлд байгаа хүмүүс дээр хүрч очиж ажилладаг, байнгын явж ажилладаг онцлог алба байна.

Энэ алба анх удаа бий болж байгаа учраас бидэнд алдаа дутагдал байгаа байх. Үүнийг хойшид засаж залруулья.

Конвенцоор олгосон бүрэн эрхийн хүрээнд бид хүн бүртэй ижил тэгш харьцах, хүн бүрийн эрхийг алагчлалгүйгээр хамгаалах үүргийг хүлээсэн.

Би ч мөн адил яг энэ чиглэлээр Үндсэн хуульд тангараг өргөсөн.

Тэгэхээр тэнд ялангуяа бидний ажилладаг газар хорих ангид ял эдэлж байгаа тэр хүмүүс байдаг.

Бид нарыг очиж хяналт шинжилгээ хийхэд тухайн хорих ял эдэлж байгаа хүн уулзах хүсэлт тавьж уулзсан. /минут дуусав/

Д.Цогтбаатар: Яах вэ, гүйцээж хариулах уу? Микрофоноо. 2 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Амь насанд нь эрсдэл учирдаг, эрүүдэн шүүх нь өөрөө хор аюултай гэдэг талаар ярилцаж энэ асуудлыг нийтэд дэлгэж өгөхийг хүссэн.

Конвенцод заасан бүрэн эрхийн дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хорих ангид болон өөрөө гарч явах боломжгүй газар байгаа бүх хүний мэдээллийг ямар ч саадгүйгээр нэгдүгээрт авах эрхтэй.

Хоёрдугаарт, өөрөө хүссэн тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтийг олон нийтэд дамжуулах үүрэгтэй байдаг.

Энэ эрх зүйн зохицуулалтын хүрээнд олон нийтийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ялангуяа эрүү шүүлт ямар хор аюултай вэ гэдгийг нийтэд таниулах зорилгоор олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.

Хойшдоо ч бид энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон нэлээдгүй хүнтэй өнгөрсөн жил уулзаж энэ чиглэлээр өөрсдийнх нь хүсэлтийнх нь дагуу нийтэд мэдээлэл өгье гэсний дагуу тодорхой асуудлуудыг судалж нийтэд мэдээлэл өгөх чиглэлээр ажиллаж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо энэ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү?

Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа
Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би дагаж байгаа тогтоолын төслийн 1.2-ын гээд байгаа “хүүхдийн тэтгэлгийн сан байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх” Засгийн газарт олгох гэж байгаа энэ үүрэг даалгавар байгаа.

Би үүнийг хасчихвал яасан юм бэ гэсэн саналтай байна.

Яагаад гэхээр шүүхийн шийдвэр гарчхаад байхад хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа хүмүүст хүлээлгэх хариуцлагатай холбоотой эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох гээд байгаа байхгүй юу.

Үүнийг бид Засгийн газраас Гэр бүлийн хууль өргөн бариад Их Хуралд хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн.

Ингээд ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа юм.

Энэ дотроо энэ асуудлыг нь шийдэх боломжтой байгаа юм.

Засгийн газар хүүхдийнхээ тэтгэлгийг төлдөггүй шүүхийн шийдвэр гарчихсан.

Хүүхдийн тэтгэлгээ төлдөггүй хүмүүсийн өмнөөс татвар төлөгчдийн хармаанаас хүүхдийнх нь мөнгийг нь өгнө гэж би байж болохгүй гэж үзэж байгаа.

Тэр аав, ээж өөрөө хариуцлагаа үүрэх ёстой шүү дээ.

Түүнээс биш бусад татвар тээгчид тэр үүргээ биелүүлдэггүй, хүүхдээ умартаж хаяж явсан, тэгээд мөнгийг нь өгдөггүй хүмүүсийн мөнгийг төлдөг сан байгуулна гэж.

Энэ концепцыг Засгийн газар дэмжихгүй бөгөөд Гэр бүлийн хууль дээр концепц оруулж ирээгүй юм.

Тийм учраас үүрэг даалгавар шуудхан хэлэхэд авмааргүй байна гэсэн нэг дэх санал байгаа юм.

Хоёр дахь санал нь, сая хэлсэнчлэн С.Одонтуяа гишүүн саяын Я.Цэлмэг гишүүний яриад байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ эрүүдэн шүүхийн комиссарыг тусад нь дахиад байгууллага болгож салгах гээд байгаа юм.

Энэ төсвөө захиран зарцуулах эрх, хүнээ томилох эрх гэдэг чинь энэ төсвийн ерөнхийлөн захирагч болох тухай яриад байгаа байхгүй юу. Энэ хүн чинь.

Хүний эрхийн Үндэсний Комисс гээд байгууллага бид байгуулаад одоо 6 гишүүнтэй, нэмэх нь энэ Эрүүдэн шүүхийн тусгай гишүүн, дахиад Хүний эрхийн хамгаалагчийн гишүүн. Энэ чинь 7 гишүүнтэй болчихоод байгаа шүү дээ.

Тэгээд одоо энэ дахиад тусдаа байгууллага байгуулах, салан тусгаарлах тухай яриад байгаа байхгүй юу.

Би энэ зарчмыг огт ойлгохгүй бөгөөд үүнийг Засгийн газар дэмжихгүй байгаа.

Үүнийг дэмжсэн санал ирүүлсэн яамд байхгүй.

Сая Засгийн газрын хурал дээр санал, дүгнэлт нь гараад ирчихсэн байгаа. С.Одонтуяа гишүүн дээр.

Тэгэхээр энэ нэгэнт Засгийн газрын байр суурь нь тодорхой болчихсон, дэмжихгүй байгаа асуудлыг Засгийн газарт үүнийг боловсруулж боловсронгуй болгож оруулж ир ээ гэдэг үүрэг авмааргүй байгаад байгаа юм.

Яагаад гэхээр байр суурь нь тодорхой болчихсон гэсэн үг. Засгийн газар.

Харин тэр 9-ийн “Б” заалт нь их хэрэгтэй заалт байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсад энэ эрүүдэн шүүсэн энэ асуудлыг эцсээ хүртэл яваад таг дүлий төр нь байгаад байх юм бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг

хороонд уламжлах энэ асуудлыг харин шийдэх нь зөв байна.

Би үүнийг, Б заалт нь харин чухал хэрэгтэй заалт байна гэж үзэж дэмжиж байгаа юм. саналтай байна.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайд наадах чинь дараа орж ирэх асуудал дээр бид хэлэлцэх юуг та түрүүлээд яриад явчихлаа. Тэглээ.

Гэхдээ ойлголоо. Наадхыг чинь дараагийн асуудал орж ирэхээр. Эдний асуудал чинь хамт орж ирэх байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ наадхыг чинь ярьдаг цагтаа яриад явчихъя. Тийм тийм. Зөв зөв.

Ингээд гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлж дууслаа.

Энэ дээр би ганц хоёр үг хэлчихье.

Я.Цэлмэн гишүүн ээ, өөрийг чинь Байнгын хорооноос ойлгоод дэмжээд явж байгаа.

Тэгэхдээ сая Байнгын хорооноос гарч байгаа дүгнэлтийг Та сонссон байх. Тийм.

Хяналт шалгалтын манайх дүгнэлтээ өөрсдөө уншиж танилцууллаа шүү дээ.

Тэгээд энэ дээрээс юу харагдаж байна гэхээр танай ажил дутагдалтай байна шүү.

Хийж байгаа үр дүнгээсээ ярьж байгаа яриа нь их байна гэсэн үг.

Яг ингээд бодит байдал дээр танай бичиг баримтыг уншаад л манай экспертүүд экспертийнхээ дүгнэлтийг өгч байна шүү дээ.

Жишээлбэл, үүнд би л лав оролцохгүй байгаа. Экспертүүд өөрсдийнхөө дүгнэлтийг хийхэд удирдлага оролцоод, үүнийг оруул, үүнийг оруулахгүй гэдэг ойлголт байхгүй.

Тэгээд энэ дээр гарч байгаа дүгнэлт сэтгэлд огт хүрэхээргүй байна шүү.

Тэгээд үүнийг Я.Цэлмүүн гишүүн өөрөө дотроо тунгааж бодно биз. Үүнийг ямар нэгэн өөрийг чинь сайлах гээд, муулах гээд ингэж байгаа биш.

Ажил сайжруулах тухай л асуудал яригдаж байгаа учраас манай тэр дүгнэлт дээр гарсан асуудлууд дээр маш тодорхой хариултууд юмнуудаа та нар бэлдэхээс гадна тэнд гарч байгаа зүйлсийг ажил хэрэг болгох тал дээр анхаарч ажиллаарай гэж хэлмээр байгаа юм.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.
/алх цохив/

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе.

Долоо.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэл /үргэлжлэл/

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэл үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Өнгөрсөн долоо хоногийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал, Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал, Хүүхдийн эрхийн зарим асуудал, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал, Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт, Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйл, шийдэл сэдвүүдийг хэлэлцсэн.

Өнөөдөр эдгээр сэдвүүдийн дүгнэлт болон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар товч танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид танилцуулна.

Д.Сүнжид даргад микрофон өгье.
1 дүгээр микрофон.

Д.Сүнжид: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, Хууль зүйн байнгын хорооны

гишүүд Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.12, 9.1, 17 дугаар зүйлийн 1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.3.5-д заасан чиг үүргийн дагуу комиссоос Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний талаарх 23 дахь илтгэлийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Энэ удаагийн илтгэлд комиссоос 2023 онд гүйцэтгэсэн судалгаа, хяналт шинжилгээ, хяналт шалгалт, гомдол, мэдээлэл болон бусад байгууллага, төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын албан ёсны тайлан мэдээлэл, бусад эх сурвалжид үндэслэн Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн зарим асуудал, Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал, Хүүхдийн эрхийн зарим асуудал, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал, Иргэний болон байгаль орчны чиглэлээр хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт, Хорих ял эдлэн суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засгийн, соёлын эрх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны асуудал гэсэн 7 сэдвийн хүрээнд 23 дахь илтгэлийг боловсруулсан.

→ Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн зарим асуудал:

Энэ бол их өргөн хүрээний суурь асуудал юм.

Хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад байгалийн, нийгмийн сөрөг нөлөөллөөс хамгаалагдах хэрэгцээтэй.

Тэр утгаараа байгалийн гамшиг, агаар, ус, хөрсний бохирдол, барилга байгууламж, авто зам, хот суурин газрын аюулгүй байдал, стандарт, цаашлаад химийн хорт бодис, аюулгүй байдлын менежментийн зохистой түвшинд шийдвэрлэх шаардлагатай нь зүй ёсны асуудал байдаг.

Хүрээлэн буй орчны талаарх 180 улсыг хамруулсан орчны индексийн үзүүлэлтээр үзэхээр Монгол Улс 155 дугаар байранд байгаа.

Агаарын бохирдлын, хөрсний бохирдлын, усны бохирдлын, хог хаягдлын менежментийн үндэсний болоод олон улсын стандартын үзүүлэлтээр ноцтой түвшинд байгаа учраас орчны чанарыг зохистой түвшинд хүргэх, аюулгүй орчны стандартын эрсдэлийг хангах асуудал нь нэн тулгамдсан асуудал байгаа болохыг энэхүү сэдэвт дүн шинжилгээ хийсэн.

Энэ агаар орчны бохирдлын улмаас хүн амын эрүүл мэндэд тодорхой өвчлөл ихсэж байна, хүрээлэн буй орчны тэнцвэртэй байдал алдагдаж байна, Эрүүл, аюулгүй орчинд байх эко системийн тэнцвэртэй байдал алдагдаж байна.

Түүнээс гадна эдийн засагт шууд үр нөлөө зардал бүтээмжийн алдагдал

болж тусаж байна. Нийгмийн үр нөлөө үзүүлж байна.

Тийм учраас энэ бүлэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нарийвчлан зохицуулсан байгаль орчны салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын дүн шинжилгээний үр дүн, давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлсон, нийтдээ нийцүүлэх ёстой 115 хуулийн нийцэл, давхардал, хийдэл зөрчлийн асуудал байна гэдгийг тодорхойлж дүн шинжилгээ хийлээ.

→ Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос сурч боловсрох эрхийн хүрээнд гаргасан **4A**_[available, accessible, acceptable, adaptable]-ийн буюу

- **хүрэлцээтэй байх,**
- **хүртээмжтэй байх,**
- **хүлээн зөвшөөрөгдөх,**
- **нийцэн зохицсон байх**

гээд энэ 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалтын байгууллага, дээд боловсролын байгууллагад дүн шинжилгээ хийсэн.

2023 оны боловсролын багц хуульд орсон цогц шинэчлэлтээр хүүхэд бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдэнэ. Иргэд насан туршдаа суралцах эрх баталгаажиж, багш тасралтгүй хөгжих боломж нээгдэж, чадахуйн зарчимд суурилсан удирдлага, засаглалын тогтолцоо бэхжиж, чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан

санхүүжилтийг нэвтрүүлж, орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахим боловсролын тогтолцоотой болж байгааг онцолсон.

Гэвч энэхүү боловсролын салбарт тухай бүрт нь шийдэх ёстой асуудал байгаа бөгөөд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын түвшин, түүнээс гадна мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хувьд ялангуяа хүртээмжтэй байх, орчныг бүрдүүлэх, хангах, тоног төхөөрөмж, сургуулийг барих, байгуулах, нэг анги дүүргэлтийг хангах, багшийг нөхөн гүйцээх, хөгжлийг дэмжих гээд энэ асуудлыг бүх талбарт шийдэх шаардлагатай байна.

Түүнээс гадна энэ дөрвөн боловсролын түвшинд шийдэх шаардлагатай асуудалд дүн шинжилгээ хийгээд дөрвөн салбараар нь нарийвчлан тодорхойлж дүгнэсэн.

→ Хүүхдийн эрхийн зарим асуудал:

Монгол Улс хүүхдийн эрхийн чиглэлээр хууль тогтоомжийг 1992 оны Үндсэн хуульдаа хүүхдийн эрх нэн тэргүүн төрийн анхаарах ёстой дээд ашиг сонирхол болохыг баталсан.

Үүнээс хойш хүүхэд хамгааллын чиглэлээр, хүүхдийн эрхийн чиглэлээр бүх л хууль тогтоомжид тусгаж байгаа боловч хэрэгжилт дээр доголдлууд байсаар байна.

Ялангуяа эмзэг, эрсдэлтэй бүлэгт хамаарах хагас болон бүтэн өнчин хүүхэд, байнгын асаргаанд шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлын хувьд энэ хөгжих, сурч боловсрох, нийгмийн хамгаалал авах, эрүүл мэндээ хамгаалуулах, асрах, гэр бүлийнх нь хөгжилд нийгмийн

хамгааллын асуудал хамтад нь шийдэх шаардлагатай байна гэдэг 52 мянга орчим хүүхдийн тухай энэ асуудлыг тухайлан анхаарах шаардлагатай байна гэж үзсэн.

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие дааж гүйцэтгэх чадваргүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд асрамж, халамжийн төвүүдэд амьдардаг хагас ба бүтэн өнчин хүүхдүүд, түүнээс гадна хамаатан садан, асран хамгаалагчдын түвшинд амь амьдардаг хагас ба бүтэн өнчин хүүхдүүдийн асуудалд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж, түүний үр дүнд цаашдаа бид төрийн зүгээс хэрэгжүүлэх хөтөлбөр, бодлого, орчныг тод, тодорхой болгох шаардлагатай байна, тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэдгийг дүгнэсэн.

→ Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал:

Сүүлийн жилүүдэд гарч байгаа гэмт хэрэг зөрчлийн дийлэнх нь гэр бүл, ахуйн орчинд үйлдэгдэж байна.

Тэгээд хамгийн их гардаг гэмт хэргийн 4-т нь гэр бүлийн орчин дахь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэдтэй холбоотой дуудлага мэдээлэл эзэлж байгаа болохыг статистик мэдээлэл харуулдаг.

Хэдийгээр төрөөс гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сүүлийн жилд эрчимтэй арга хэмжээ авч бодлогын түвшинд, хууль тогтоомжийн түвшинд, хэрэгжилтийн түвшинд анхаарч байгаа хэдий ч энэхүү хэрэг маргаан, зөрчил буурахгүй байгаа.

Тийм учраас урьдчилан сэргийлэн таслан зогсохоос гадна урьдчилан

сэргийлсэн бодлого хэрэгтэй, үр дүн гаргах хэрэгтэй, ахиц гаргах хэрэгтэй.

Үүнийг үүсгэж байгаа шалтгаан, хүчин зүйлд нь илүү анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзсэн.

Энэ тухайд шүүхээр эцэг, эх тогтоолгох, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан иргэдийн тухайд хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар хэдийгээр шүүхийн шийдвэр гарчихсан боловч тэр эрх нь хангагдахгүй, хамгаалагдахгүй байгаа тухайд энэхүү маргааныг шийдвэрлэсэн тоон үзүүлэлт жил бүр өсөж байгаа учраас цаашид энэ хүрээнд ер нь хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн олон талт орчин үед үүсэж байгаа гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзаад гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх асуудал, эцэг, эхийн хамтын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх асуудал, нөхөн үржихүйн асуудлыг шийдэх хүрээнд энэхүү 4 дэх бүлэгт дүн шинжилгээ хийж сэдвийг бэлтгэсэн.

→ Иргэний болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт:

Тэгэхээр 1600 орчим байгаль орчны чиглэлээр ажилладаг байгаль хамгаалагчид байна.

Тэгэхээр эдгээр хүмүүст тулгамдаж байгаа асуудлыг шүүхийн шийдвэрийн хүрээнд, мөн түүнээс өөрсдөөс нь авсан санал асуулгын хүрээнд боловсруулсан.

Ингээд үзэхээр нэн тэргүүнд тэдэнд ажлын байр орчин хэрэгтэй байна. Лаборатори тоног төхөөрөмж хэрэгтэй байна.

Түүнээс гадна эрх зүйн хувьд өөрсдийнхөө эрх зүйн байдлыг баталгаажуулж, **“байгаль орчныг хамгаалагч”** гэж хэн бэ, эрх зүйн байдал нь юу вэ, нийгмийн хамгаалал, цалин хөлс, бусад баталгааны асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг хийсэн.

Мөн байгаль орчны чиглэлээр ажилладаг болон ер нь хүний эрх хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа хүмүүст бодитой заналхийлэл тулгардаг юм байна. Зөрчилд.

Тийм учраас үүнээс хамгаалах, аюулгүй байдлыг нь хамгаалах энэ асуудлыг авч үзсэн.

→ Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт:

Энд гэмт хэрэг үйлдээд хорих ангиас суллагдаж байгаа хүмүүсийн 40 орчим хувь нь 2 жилийн дотор эргээд гэмт хэрэг үйлддэг статистик байна.

Тийм учраас нийгэмшүүлэх, ажилд зуучлах, хэвийн ажил амьдралдаа эргэн орох боломжийг нь бүрдүүлэх чиглэлээр одоо батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төлөвлөгөө гаргах, санхүүжилтийг нь шийдвэрлэх энэ чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай байна гэдэг хүрээнд энэ илтгэлийг авч үзсэн.

→ Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйл, шийдэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 70 орчим хувь нь амьжиргааны чанарын түвшний хувьд доогуур, бие дааж хөгжих, нийгмийн

амьралд оролцох боломж тааруу байдаг учраас 82 мянган орчим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай асуудал, ялангуяа энэ сонгох сонгогдох эрхийн тухай асуудал яригдаж байна.

Тэгэхээр улс төрийн эрхийг ярихаасаа өмнө амьдралын чанар, амьдралын баталгаажих түвшнийг сайжруулах шаардлагатай. Сурах, боловсрох, нийгмийн баталгаагаар хангагдах энэ эрхийг ярьсны дараагаар бид улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд буюу намын түвшинд дэмжих, тэр улс төрийг сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд дэмжих шаардлагатай байна гэдэг энэ дүн шинжилгээг хийсэн.

Эрхэм гишүүд ээ,

Энэ хүрээнд хууль Хүний эрхийн Үндэсний Комиссоос сая танилцуулсан 7 бүлэг сэдвийн хүрээнд 54 саналыг Улсын Их Хуралд тогтоолд тусгуулахаар уламжилсан.

Тийм учраас Та бүхнийг энэ талаар анхааралдаа авч, хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

2023 оны байдлаар Хүний эрхийн комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг товч тоймлож танилцуулья.

Нийтдээ 145 хяналт шалгалтыг хийсэн.

Тэгээд ихэнхийг нь гишүүд өөрсдийн санаачилгаар буюу 119 нь гишүүний санаачилгаар хийсэн хяналт шалгалт байгаа.

Гомдол, мэдээллийн мөрөөр бид 26-г нь хийсэн.

Ингээд 145 хяналт шалгалт хийгээд нийтдээ бид 26 шаардлага, 61 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Ингээд нийт заалтуудыг нь аваад үзэх юм бол 452 заалт болох юм.

Саяын 87 шаардлага, зөвлөмжийн агуулга нь аваад үзвэл хамгийн их давтагдсан шаардлага, зөвлөмжийн агуулга юу вэ гэхээр хөдөлмөрлөх эрх, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх хамгийн олонтоо давтагдсан байна.

Тэгээд хүүхдийн эрх байгаа юм.

Сурч боловсрох эрх, хүүхдийн хөгжих эрхтэй холбоотой асуудлууд мөн дараа нь олонтоо давтагдсан асуудал дээр давтамжаараа их байна.

Үүнтэй холбоотой сурч боловсрох орчин, нөхцөл, дотуур байрны хангамж, хүртээмж, стандартын асуудал хөндөгдөж байгаа юм.

Тэгээд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тухай тоон мэдээлэл нь хамгийн их байна.

Энэ дээр комиссын гишүүний шаардлага зөвлөмжийг хүлээж авсан байгууллагаар нь аваад үзэх юм бол

➤ Засгийн газар яам, агентлаг, түүний салбар нэгжид **9**,

➤ хууль сахиулах байгууллагын чиглэлээр **16**,

➤ нийслэл болоод орон нутгийн Засаг дарга **62**,

➤ төрийн үйлчилгээ, төрийн өмчит аж

ахуйн тооцоот байгууллага 25,

➤ хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад 11 шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

Хэрэгжилтийн байдлыг нь зөвхөн 2023 оны байдлаар таслаад аваад үзвэл 81 шаардлага, зөвлөмжийн

- бүрэн хэрэгжсэн 43,
- хэрэгжих шатдаа 30,
- хэрэгжилт хангалтгүй 6,
- хэрэгжээгүй 8

гэсэн үзүүлэлттэй байна.

Товч танилцуулж дууслаа. Асуулт байвал хариулъя. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан. Ирсэн гэж тэмдэглэгдээгүй учраас би уншилгүй өнгөрчихлөө шүү.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг, Г.Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга, Б.Дэлгэрмаа Хүний эрхийн Үндэсний Комиссын Хяналт шалгалт, үнэлгээ хариуцсан референт

гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуралд оролцож байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов гишүүн ирсэн байна.

Ингээд хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй биелүүлсэн, эсвэл биелүүлэхтэй холбогдсон тодорхой асуудлууд гаргасан байгууллагуудын албан тушаалтан, төлөөллүүдийг энэ Байнгын хороонд урьж оролцуулж байгаа.

Энэ удаа бид нарын урьсан бүх хүмүүс онлайнаар болон энд байгаа ирэх боломжтой хүмүүс бүгд ирсэн байгаа.

Ирээгүй нөхдүүд байсан бол би улс орон даяар зарлах байсан.

Өнөөдөр ирсэн. Бид Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн комиссын тайланг хэлэлцүүлэх процедурт шинэ соёл, шинэ хандлага нэвтрүүлж байна.

Юу гэвэл Хүний эрхийн комиссын тавьж байгаа шаардлагуудыг цаг тухайд нь биелүүлэхгүй байгаа, эсвэл ямар нэгэн байдлаар асуудал гарч байгаа энэ байгууллагуудыг бид анх удаа урьж оролцуулж байгаа.

Энэ цаашдаа үргэлжлээд явах ёстой. Биелүүлэхгүй байгаа нөхдүүдийг улс орон даяар зарлаж байх ёстой. Хүний эрхийн асуудал дээр юм байна шүү гээд.

Тэгэхээр одоо энд оролцож байгаа хүмүүсээс, би яг энэ байдлаар уригдаж ирсэн хүмүүсээс юу хүсэж байна гэхээр

яг энэ хүний эрхийн асуудлаар энэ тайланг хэлэлцэж байхыг бүгдээрээ сонсоод энд ямар асуудлууд гарч байна гэдэгтэй танилцаад, энэ бол төрийн албан хаагчийн нэгдүгээрт тавьж хэрэгжиж байх ёстой асуудал шүү. Хүний эрхийн асуудал.

Та нар хүний төлөө л төрийн алба, нийтийн албыг хашиж байгаа.

Түүнээс аль нэг даргын төлөө биш. Та нарыг томилсон хүмүүсийн төлөө биш гэдгээ л хамгийн сайн ухамсарлаж ажиллах шаардлагатай.

Яг энэ Байнгын хорооны хүрээнд хүний эрхийн асуудлыг нь хэлэлцэж байгаа энэ явцтай, хэлэлцэж байгаа асуудлуудтай би сайн танилцаад аваасай гэж бодож байгаа юм.

Энд хэлэлцэх явцад манай гишүүд энэ уригдсан байгууллагуудаас асуух асуулттай гишүүд байвал асуух биз ээ гэж бодож байна.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Ц.Сандаг-Очир, Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Энэ чинь нөгөө авах арга хэмжээнийхээ тогтоолтой хамт яваа юу?

Д.Цогтбаатар: Дараа нь тогтоол тусдаа орно.

Ц.Сандаг-Очир: Бас тусдаа байгаа юу?

Би хүний энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар тодруулж асууя.

Эрүүл, аюулгүй орчинд гээд. Тэгсэн хэрнээ энд болохоор үндсэндээ байгаль орчин, агаар, ус, хөрсний асуудал яригдаад байна.

Дөнгөж саяхан хэд хоногийн өмнө өнгөрсөн долоо хоногт Нийгмийн бодлогын байнгын хороо эмийн асуудлаар нээлттэй сонсгол хийсэн.

Энэ дээр үндсэндээ монгол хүн, монголчууд бид 3.4 саяулаа эрүүл байх эсэх асуудал хөндөгдөж байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр Монгол Улсаар орж ирж байгаа, гаалиар орж ирж байгаа эм баталгаатай байж чадаж байна уу, үгүй юу? Орж ирж байгаа эм болгоныг бид хянаж чадаж байна уу, үгүй юу? Шинжилж, судалж чадаж байна уу, үгүй юу? Тогтолцоо нь ямар байна вэ? Орж ирж байгаа эм болгоныг бүртгэж чадаж байна уу, үгүй юу? Бүртгэлийн систем нь ямар байна.

Монгол Улсад бүртгэлгүй эм ороод ирчихсэн байна. Орж ирсэн эм болгоныг тэр үзүүлэлт шаардлагаар нь шинжиж судалж чадахгүй байна.

Үндэсний ганц лаборатори нь байх ёстой тоног төхөөрөмжийн 50 хувь нь байна. Байгаа нь шаардлага хангахгүй байна гэхээр нийтдээ улсын хэмжээнд жилд нийтдээ 8.4 мянган тонн эм орж ирж байна.

Энэ эмийг монголчууд идэж байна л гэсэн үг.

Энэ хүний амаар орж байгаа нэг бол хүнс, нэг бол эм.

Хуурамч эм, дуураймал эм, хугацаа нь дууссан эм КОВИД-ын үеэр орж ирээд ашиглаагүй 11 тэрбум төгрөгийн эм хугацаа нь дуусаад устгал хийх гээд байж байна.

Гаалиар тэс хөлдүү дуслын шингэн орж ирчихсэн лабораторид өгөхөөр хөлдүү байна, шаардлага хангахгүй гэсэн. 21 хоногийн дараа гэсгээгээд шинжилгээнд өгөөд тэнцүүлээд яасан нь мэдэгдэхгүй Монгол Улсад байгаа 2-хон эм, эмнэлгийн хэрэгслийг устгах устгалын газарт бүртгэгдээгүй.

Тэгээд энэ хаачсан бэ? Ашиглагдсан уу, хэрэглэгдсэн үү гэдэг.

Гэх мэтчилэн ноцтой асуудлууд илэрсэн. Илэрсэн.

Үүний цаана нийт ард түмний иргэдийн эрүүл байх. Төр, засгаас зээл, тусламж үзүүлээд байдаг. Хөнгөлөлттэй эмийн үнэ жил болгон нэмээд байдаг. Төсөв санхүүг нь.

Гэтэл өнөөдөр монголчууд бид хамгийн үнэтэй эмийг, хамгийн чанар муутай эмийг хэрэглэж байна гэдэг дүгнэлтэд хүрч байгаа юм.

Эмийн чанарын хяналтын тогтолцоо алдагдсан байна гэдэг дүгнэлтэд сая нээлттэй сонсгол үндсэндээ дүгнэлтэд хүрсэн.

Тэгэхээр энэ монгол хүний эрүүл, аюулгүй байдалтай холбоотой асуудал уу? Хүний эрхийн комисс анхаарлаа хандуулах шаардлагатай юу?

Тэгэхээр энд огт хөндөгдөхгүй байна.

Тэгэхээр би яагаад энэ асуудлыг зөвхөн агаар, ус, хөрсний хүрээнд асуудал яригдаад байна? Энэ асуудлыг яагаад хөндөж ярихгүй байна.

Зайлшгүй Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ асуудлаар хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагуудад нь зөвлөмжөө өгөх.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Ц.Сандаг-Очир: Орж ирж байгаа эмийг уг нь шинжилдэг лабораторийн засвар, тоног төхөөрөмж нь гэхэд 5 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа байхгүй юу.

Энэ бол улсын төсөв дээр дааж давшгүй асуудал биш.

Тэр дундаа КОВИД-ын үеэр асуудлуудыг шийдсэн бол бололцоо боломж байсан.

Иж бүрэн олон улсын хэмжээний стандарттай больё гэвэл 20 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гээд тухайн зохицуулалтын газрынхан ярьж байх жишээтэй.

Энэ бас дааж давшгүй асуудал мөн үү гэвэл зохицуулчхаж болох хэмжээний асуудал. Гагцхүү сэтгэл.

Тэгээд энэ дээр яагаад холбогдох байгууллагууд дээр хяналт шалгалт хийж, үзлэг хийж, зөвлөмж өгч, дүгнэлт гаргаж, ард түмнээ эрүүл байлгах асуудал дээр анхаарал хандуулахгүй байна вэ?

Энэ дээр Хүний эрхийн комисс үзэж харсан зүйл байна уу? Энэ дүгнэлтэд орсон зүйл байна уу? Хяналт

шалгалт хийсэн зүйл байна уу гэдгийг би асууя.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон. Д.Сүнжид даргын хариултыг сонсьё.

Д.Сүнжид: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Хүний эрхийн комиссын стратеги дээр 2020 онд дүн шинжилгээ хийгээд үзэхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бид бүгдийг нь авч үзэх шаардлагатай байна.

Тэгээд энэ хүрээнд бид 20, 21 дэх илтгэлээ хөдөлмөрлөх эрхийн зарим асуудлуудыг хэсэгчилж аваад илтгэсэн.

23 дахь илтгэл дээр боловсрох эрхийг.

Тэгээд 22 дахь илтгэл дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ зөвхөн КОВИД-ын үед яаж хүрч вэ гэдгийг авч үзсэн юм.

Тэгээд өрхийн эрүүл мэндийн түвшин буюу анхан шатын түвшинд яаж хүргэж байна вэ гэдэг хүртээмжийн асуудлыг хэсэгчилж авч үзсэн юм.

Тэгээд одоо бид комиссын хуралдаанаараа ярилцаад энэ бол үнэхээр нийтэд нь өргөн хүрээнд яг салбараар нь авч үзэх ёстой асуудал мөн.

Тийм учраас 2024 онд бүхэлд нь хэсэгчилж биш. Өмнө бид анхан шат гээд ингээд хэсэгчлээд явж байсан. КОВИД-ын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гээд. Одоо бол бүхэлд нь энэ эм, эмнэлгийн тэр хэрэгсэл, хяналт, тоног төхөөрөмж, чанар, ханган нийлүүлэлт, эмч нарын өөрсдийнх нь нөөц боломж, ажиллах нөхцөл, санхүүжилтийн асуудал,

даатгалын асуудал гээд иж бүрнээр нь авч үзье гээд удирдамж гаргаад явж байгаа юм.

Тэгэхээр бид үүнийг энэ жилдээ бүтэн хийгээд хяналт шалгалт, судалгаа, шинжилгээ, гадаад болон дотоод зөвлөхүүдийн хамтаар, тэгээд өөрийн энэ салбарынх нь мэргэжилтнүүдийг уриад оролцуулаад. Одоо бол бид удирдамжаа гаргаад эхэлж байна л даа.

Тэгээд энэ жилдээ дуустал нь хийгээд 24 дэх илтгэлдээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийн хүртээмжийн асуудлыг бүхэлд нь оруулъя гээд төлөвлөчихсөн явж байгаа.

Энэ үнэхээр таны хэлж байгаа асуудал мөн. Судлах ёстой. Энэ нөхцөл байдлыг дүгнэх ёстой.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг.

Ц.Сандаг-Очир: Би энэ эрүүл, аюулгүй байх орчны асуудлыг л яриад байгаа юм л даа.

Одоо ингээд сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот 20-оос дээш давхрууд баригдаж байна. Барилгууд.

Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комисс, гал унтраах ангиудад 20-оос дээш давхарт гарсан гал түймэрт ажиллах, гал унтраах автомашин, нөгөө крантай машин байхгүй л байгаа байхгүй юу.

Сая оны өмнө болсон дэлбэрэлт. Сая сүүлийн гал түймэр. Ингээд олон хүний амь нас эрсдээд байх уу? Тэр орон сууцын байшинд гал гарсан тохиолдолд тэр олон хүний амь нас эрсэдсэн бол яах вэ гэдэг.

Энэ чиглэлээр та нар маань иргэдийн аюулгүй байхын үүднээс хяналт шалгалт тэгж холбогдох газрууд нь. Төсөв, мөнгөний л асуудал байгаа шүү дээ. Цаанаа дандаа.

Зөвлөмж, дүгнэлт гаргасан зүйлүүд байна уу? Төлөвлөж байгаа зүйлүүд байна уу гэдэг дээр нэг хэлээдхээч.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон өгье.

Д.Сүнжид: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нөгөө хүрээлэн буй орчны индексийн олон улсын үзүүлэлтээрээ 4 үзүүлэлтээр авч үздэг юм билээ.

Бид тэр хүрээнд нь буулгахыг хичээсэн. Нэмсэн зүйл нь юу вэ гэхээр Ц.Сандаг-Очир гишүүний сая дурдсан стандартын асуудал.

Улаанбаатар хотын стандарт. Уулын уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах гэдэг дэд сэдвүүдийг бас авч үзсэн юм. Энэ хүрээнд.

Тэгэхээр стандартын тухайд ямар үзүүлэлт гарч байгаа вэ гэхээр зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд бид үндэсний хэмжээнд 6589 стандарт батлагдаад мөрдөгдөж байна.

Гэхдээ сургуулиуд, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, шатахуун түгээх станц, үерийн аманд бууж байгаа оршин суугчид гээд. Шинээр баригдаж байгаа барилгууд. Яг таны дурддаг. Энэ дээр стандарт хангалтгүй барилгууд тоотойгоо, мэдээтэйгээ ирж байна.

Тийм учраас зөрчлийг нь таслан зогсоож, стандартыг сахиулахын тулд

юун түрүүн нэгдүгээрт нь илрээд байгаа зөрчлийг таслан зогсоож асуудал чухал юм байна. Хяналт тавиад шууд зогсоох.

Д.Цогтбаатар: Микрофон нэмж өгөх үү? Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг нь өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдалтай холбоотой тайлан илтгэлийн нэг хөндсөн асуудал маань яг комиссын гишүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тавьсан шаардлагуудыг биелүүлэх тухайд манай төрийн байгууллага, төрийн албан тушаалтнууд үйл ажиллагаа зарим нь хангалтгүй байгаа юм байна.

Тухайлан өнөөдрийн манай Байнгын хороон дээр дурдагдсан төрийн албан тушаалтнуудаас Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг дарга Ө.Бат-Өлзийгөөс асуулт асуумаар байна.

Ер нь Ө.Бат-Өлзий даргын болон Завхан аймгийн Цагаанхайрхан сумын ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн чиглэлээр 9 зөрчил байгаа юм байна.

Хөдөлмөрлөх эрх, тэгээд хүүхдийн эрхтэй холбоотой. Жишээлбэл, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалтууд.

Мөн хөдөлмөрийн харилцаан дахь дарамт хүчирхийлэл, Хөдөлмөрийн тухай хуулийн дотоод журмыг шинэчлэх гэсэн заалтууд байна.

Мөн сургуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн урсгал нь хангалтгүй байсан байна.

Мөн багш, ажилчдын итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийн

асуудал тодорхой хэмжээнд хангалтгүй байсан байна.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.1 дэх хэсэгт байдаг хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэсэн байгаа.

Тэгэхээр хүүхэд хамгааллын чиглэлээр танай суманд “Хүүхдийн төлөө зөвлөл” хамтарсан багийн төсөв нь ерөөсөө сумын төсөвтөө батлагдаж чадаагүй гээд байгаа байхгүй юу.

Тэгээд яагаад энэ ингээд батлагдаж чадахгүй байгаа вэ?

Тэгээд энэ хүний эрхийн зөрчилтэй асуудлуудаа хэрхэн засаж сайжруулсан бэ гэдгийг нь Цагаанхайрхан сумын Засаг дарга Ө.Бат-Өлзийгөөс асууя.

Д.Цогтбаатар: Онлайнаар цахимаар хариулах боломж олгоё. Тайлбараа.

Ө.Бат-Өлзий: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Цагаанхайрхан сумын Засаг дарга Ө.Бат-Өлзий байна. Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Ер нь эхлээд тодорхой ойлголт өгье гэж бодож байна.

Энэ зөвхөн Засаг даргаас үүсээд байгаа юм гэсэн асуудал биш юм байгаа юм. Яг эхнээс нь нэг тодорхой оршил хэлж өгье.

Энэ сургууль дээр би 2020 оны сонгуулийн үр дүнгээр Засаг даргын ажлыг эрхэлж байна.

Ингээд ороод боловсролынхоо салбар луу ажлаа эхлүүлсэн. Энэ дээр манай сургуулийн захирлын ажил хоёр, гурван удаа солигдчихсон. тогтвор суурьшилгүй байсан.

Үндэслэл бол мэдээж одоо энэ жинхлэгдээгүй, шаардлага хангахгүй асуудлууд байсан л даа. Тэгээд ер нь яах вэ, бид өөрөө “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн даргын тэргүүний хувьд, хамтарсан багийн ахлагчийн хувьд энд тухайн ажиллаж байсан Г.Мягмарсүрэн гээд энэ захиралтай эхнээсээ ажлаа төлөвлөөд ингээд явсан.

Энэ хугацаанд яг таны яг асууж байгаа шиг энэ хүүхдийн эрх зөрчигдөж эхэлсэн юм байгаа юм. Тэгээд тухайн захиралд албан шаардлага хүргүүлээд, манай дотуур байранд хүүхдийн ноцтой зөрчил бас үүсэж хүүхэд нь сургуулиас гарах, тийм ээ тодорхой хэмжээний ял эдлэх асуудлууд үүссэн учраас эхний ээлжид энэ хүнтэй хариуцлагын ярьсан юм.

Ингээд хариуцлага яриад явсан энэ хүн маань Иргэний шүүхэд хандсан. Энэ хугацаанд яах вэ байгууллага, хамт олных нь саналаар нэг хүнийг дотроос ингээд тавиад явж байсан юм.

Ингээд шүүхийн шийдвэр нь одоо яах вэ, процедурын алдаа би гаргасан байдаг юм билээ. Яах вэ, энэ дээр шүүх тэгж дүгнэсэн. Өөрөөр хэлэх юм бол мэдэгдэх энэ тэрээ өгөөгүй, тийм ээ сонсох ажиллагаа явуулаагүй гэдэг үүднээс энэ дээр ялагдсан байдаг юм.

Тэгэхээр тухайн тухайн захирал маань энэ хүүхдийн эрх хамгаалах, энэ дотуур байр, тэр таатай орчинд амьдрах асуудал хяналтгүй, хангалтгүй байсан учраас хүүхдийн эрх зөрчсөн асуудлаар би чөлөөлсөн байдаг.

Хоёр дахь асуудал дээр энэ хүн маань дахиж яах вэ, иргэний хэргээр шүүх нь буцаагаад тавигдсан байж байгаа. Буцаагаад тавигдаад энэ ажлаа хоёулаа ингээд явах ёстой гээд хамтарч нэлээн явсан.

Мөн энэ хугацаандаа дахиад ажлын байранд архи дарс хэрэглэж, архи согтууруулах ундаа хэрэглэж бүр бичлэг юугаараа дахиад чөлөөлөгдсөн байдаг юм.

Ингээд хоёр удаа чөлөөлөгдсөн хүн маань Хүний эрхийн комисст нэлээн олон асуудлаар, нэг талдаа өс хонзол ч гэдэг юм уу, иймэрхүү байдлаар танил талаараа энэ гомдлыг гаргасан байна лээ.

Энэ хүрээнд би процессын хувьд энэ шүүхийн процесс нэлээн удаан явсан учраас наад 9 зөвлөмж ирсэн байж байгаа.

Тэгээд энэ хооронд ирэхдээ энэ хүний эрхийн ажлын хэсэг гэдэг юм уу, ирэхдээ энд нэг талдаа тухайн багш нарын нэг талыг барьсан сонсох ажиллагаа ч гэдэг юм уу, дүгнэлт гаргаад явсан байна лээ.

Мэдээж Засаг даргын хувьд ч гэсэн бас зориудаар хүний эрхийг зөрчихгүйн мэдээж шүү дээ. Энэ хүүхэд, энэ сургуулийн боловсролын асуудлаа сайжруулахын төлөө л ингэж явж байгаа.

Тэгээд энэ дээр ямар нэг жендэрийн асуудал зөрчсөн, одоо нам, улс төрөөр ялгаварлан гадуурхсан зүйл байхгүй байсан.

Тэгээд яах вэ, одоо болбол яаж засарсан бэ гэхээр энэ хүн маань захиргааны хуулиараа буцаад энэ сонгон

шалгаруулалтынхаа юмаар ингэж эргэж ажилдаа ороод ингээд явж байгаа.

Тэгээд энэ дээрээс хойш энэ хүний эрхэд хандах комисс энэ гомдол эд нар нь тасарсан байж байна.

Ер нь одоо ч гэсэн бас ингээд л хүүхдийн эрх зөрчих асуудлууд гараад л байж байгаа.

Ер нь л хариулт ерөнхий өгье гэж бодож байна. Дараа нь тодруулж хариулъя.

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүн тодруулж асууя гэж байна.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр нэг сургуулийн захирлын буюу нэг хүнээс шалтгаалаад тэнд хүний эрхийн, хүүхдийн эрхийн, хөдөлмөрлөх эрхийн зөрчлүүд удаа дараа гараад байгаа нь үнэхээр харамсалтай байна.

Тэгээд Хүний эрхийн комиссын хүний эрхийн зөрчлийн талаарх дүгнэлтийг Засаг дарга маань нэг талыг барьсан, танил талаа ашигласан ч гэдэг юм уу, иймэрхүү байдлаар Монгол Улсад хүний эрхийг хамгаалах хараат бус комиссын нэр хүндэд халдсан мэдээллийг хийж байгаа нь бас харамсалтай.

Тийм учраас энэ дээр Хүний эрхийн комиссын тайлбарыг авъя.

Хоёрдугаарт нь, Засаг дарга чинь тэр хүүхэд хамгааллын хамтарсан багийн төсвийг сумын хурлаар батлуулах ёстой шүү дээ. Тэрийгээ баталж чадаагүй дээрээ тайлбар өгөх хэрэгтэй гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс Г.Ууганбаатар.

Г.Ууганбаатар: Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар.

Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Хүний эрхийн Үндэсний Комисст жил дунджаар мянга орчим гомдол ирж байгаа.

Тэгэхээр ямар нэгэн байдлаар комиссын зүгээс тухайн гомдол гаргагчид үйлчлэх гэдэг юм уу, хараат бус байдлаа алдагдуулсан гомдол шалгах ажиллагааг хэзээ ч явуулж байгаагүй.

Тэгэхээр Завхан аймгийн Цагаанхайрхан сумын иргэнээс ирүүлсэн гомдлын мөрөөр комиссын гишүүний баталсан удирдамжтай хяналт шалгалтыг хийгээд ингээд 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн комиссын гишүүний зөвлөмжийг тухайн сургуулийн удирдлагыг томилдог эрх бүхий албан тушаалтан буюу Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг даргад хүргүүлсэн.

Ингэхдээ тухайн Засаг даргын өөрийнх нь бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Тухайлбал, төсвийн асуудлыг шийдвэрлэх энэ бүрэн эрх сумдын хувьд сумдын Засаг дарга нарт байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлээч ээ. Энэ төсвөөс үүдэлтэйгээр гарч байгаа хүний эрхийн зөрчлийг таслан зогсоо, дахиж гаргуулахгүй байх арга хэмжээ аваач ээ.

Мөн хоёрдугаарт нь сургууль дээр үүсээд байгаа энэ тогтворгүй байдал, энэ талцал хуваагдлыг арилгах талаар арга

хэмжээ аваач ээ гэдэг л агуулга бүхий 9 заалттай зөвлөмж явсан.

Тэгээд Ө.Бат-Өлзий Засаг даргын өөрийнх нь албан бичгээр хариу ирсэн.

Энэ хариу албан бичиг дээр бид үндэслээд тухайлбал комиссын гишүүний зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна гэж үзэж одоо энэ зөвлөмжийн хэрэгжилтийг гаргасан байгаа.

Д.Цогтбаатар: Засаг даргаас тэр төсөв батлаагүй асуудал дээр Ц.Мөнхцэцэг гишүүн тодруулга хүсэж байна.

Ө.Бат-Өлзий: Төсвийн хувьд аймгаас яах вэ чиглэл ирдэг л дээ. Тэгээд манай сумын төсөв өөрөө их бага. Давсан орлого бага байдаг.

Гэхдээ бид одоо ингээд “Хүүхдийн төлөө зөвлөл” тийм байна гээд хуралдаа оруулна. Мэдээж хурлын төлөөлөгч нарын асуудал учраас энэ дээр тийм үр дүнтэй оролцдоггүй л дээ.

Тэгээд ер нь цааш цаашдаа үр дагавар гардаг гээд ирэх жилээс арай илүү төлөвлөж ингэж явахаар тодотголоор оруулахаар ингэж явж байна.

Ер нь төсөв багатайдаа л ингэж явдаг юм. Зориулалтын давсан орлого энэ тэр байхгүй.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Би нэг асуулт асууна.

Энэ дээр “Монгол шуудан” компанийн төлөөлөл, гүйцэтгэх захирал Г.Тэлмэн ирсэн байгаа юу?

Танай дээр нэлээн хэдэн асуултууд гарсан байна л даа. Тэгээд энэ дээр миний харж байгаагаар нэлээн олон зүйлүүдэд энд зөвлөмжүүдийг өгсөн байна.

Тэгээд зарим зөвлөмж дээр зүгээр л “тэг” байна л даа. Юу ч хийгээгүй гэсэн. Энэ зөвлөмжийг нь хүлээж аваагүй.

Тэгээд энэ Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүргийг шуудангийн үйлчилгээний газрын удирдлагаас зохих ёсоор хэрэгжүүлж, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид орчин бүрдүүлэх, энэ дээр хяналт тавих дээр “тэг” гэсэн байна.

Энэ одоо тэгээд ажлын байрны дарамт гэдэг үнэхээр жинхэнээсээ Монголд нэлээн хавтгай байгаа зүйл шүү дээ. Хөдөлмөрийн харилцаа нь.

Тэгэхээр энэ зүйл дээр онцгой анхаарах ёстой. Ялгаварлан гадуурхалт гэдэг бол ажлын байран дээр ерөөсөө байж болохгүй зүйл байхгүй юу.

Эсвэл одоо энэ Хөдөлмөрийн хуулийн 7 дугаар зүйлтэй холбогдсон зөвлөмжүүд өгсөн байна л даа. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүргийн дагуу хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулан баталж хэрэгжилтэд хяналт тавих гэдэг дээр “тэг” гэж байгаа байхгүй юу.

Үгүй ээ, одоо тэр журмыг гаргачхаж. Энэ чинь аягүй жижигхэн шаардлага байгаа байхгүй юу.

Тэгээд энэ журмыг гаргачхаж болдоггүй юм уу? Энэ чинь яагаад энэ дээр байна аа?

Эсвэл компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн урсгалыг сайжруулж, бүх ажилтнууд мэдээллийн тэгш хүртээмжтэй авч байх нөхцөлийг бүрдүүлэх, компанийн дотоод журам, бусад дотоод хэм хэмжээг нийт ажилтнуудад танилцуулж, ил тод байдлыг хангаж, нээлттэй байршуулах гээд.

Түүн дээр бас “тэг”. Энэ жендэрийн эрх тэгш байдал. Энэ дээр “тэг” гээд.

Би тэгээд энэ жендэрийн эрх тэгш байдал дээр ялангуяа би нэлээн яриад байгаа. Энэ ажлын байрны бэлгийн дарамт гэдэг бол яг энэ дээр та нар бодлогоо гаргаж, жигд хэрэгжүүлж, тэр соёлыг нэвтрүүлж ажиллахгүй бол харагдахгүйгээр энэ байнга ялгаварлан гадуурхсан, ажлын байрны дарамт бэлгийн дарамт чинь хавтгай байгаа.

Тэгэхээр энэ дээр танайх ямар ач холбогдол өгч, одоо энд ингээд “тэг” гээд заагдчихсан байна шүү дээ.

Тэгэхээр яагаад энэ байгаа юм? Цаашдаа яая гэж бодож байгаа вэ? Энэ асуудлууд дээр. Түүн дээр хариулт авъя.

3 дугаар микрофон дээр суучих. 3 дугаар микрофон өгье.

Г.Тэлмэн: Сайн байцгаана уу? “Монгол шуудан” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Тэлмэн.

Байнгын хорооны даргын саналтай санал 100 хувь нэгдэж байна.

Тэгээд миний хувьд 2024 оны 04 сарын 01-нд ажлаа хүлээж авсан.

Өнгөрсөн долоо хоногт Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирсэн, Байнгын хорооноос ирсэн. Энэ хуралд оролцох тухай мэдээлэлтэй танилцаад ер нь өмнө болсон бүх мэдээллүүдээ танилцаж байгаа.

Тэгээд 7 агуулга бүхий зөвлөмжүүдийг өгсөн байсан. Та сая ерөнхий агуулгаар нь дурдчих шиг боллоо.

Зарим зүйл, заалт дээр хангалтгүй байгаа нь үнэн юм билээ.

Тэгээд эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр арга хэмжээ авна гэсэн бодолтой байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа.

Тэгвэл энэ дээр би өөрт чинь яг тодорхойлоод юу өгмөөр байна? Яг энэ арга хэмжээнүүд дээр юу юу авч, ямар хугацаанд, яаж хэрэгжүүлэх талаар та товчхон одоо нэг төлөвлөгөө гаргаад над руу нэг хувь ирүүлчхээрэй. Нөгөө хувийг нь Хүний эрхийн Үндэсний Комисс руугаа явуулаарай.

Өөрөөр хэлбэл би Хүний эрхийн Үндэсний Комисс руу явуулж байгаа шалтгаан нь танайх хяналт тавьж ажиллаарай. Энэ дээр та нарын шаардлагууд, танай л хийх ажил шүү дээ.

Бид танай ажил дээр өөрсдийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллаж байна гэсэн үг.

Тэгээд та нар энэ дээр нь хяналт тавиад, ажил яаж явж байна гэдгийг Хүний эрхийн Үндэсний Комиссынхон

надад мэдээлээд явчхаарай гэж хэлмээр байна.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөг хангах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц болон дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хүний эрхийн нөхцөлд дүгнэлт хийх хараат бус гол байгууллага бол Хүний эрхийн комисс байгаа.

Хүний эрхийн комисс эрх мэдлийн хүрээнд бүх төрийн байгууллагуудад ажиллаж дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргас ёстой.

Энэ байгууллагын гаргасан зөвлөмжүүдийг тухайн төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй байгаа.

Тийм учраас өнөөдрийн энэ хурал дээр хэлсэн шиг зарим төрийн засаг захиргааны нэгжийн дарга нөхдүүд маань бас энэ хүний эрхийн хараат бус комиссын зөвлөмжийг үл тоосон байдалтай, эсвэл энэ зөвлөмжид гарсан дүгнэлтүүдийг нэг талыг барьсан гэх мэтийн хуульд нийцэхгүй хандлагаар, хувийн байр суурь хандаж авах нь буруу шүү.

Монгол Улс хүний эрхийг дээдэлдэг ардчилсан улс орны хувьд бид олон улсын чиг хандлагаар явна.

Хэрэвээ тухайн албан тушаалтан тэр хүний эрхийн зөрчлийг арилгаж чадахгүй байгаа бол албан тушаалаа сайн дураар болон бусад байдлаар өгөх шаардлагатай гэдгийг онцолж хэлмээр байна.

Тэгээд хүний эрхийн нөхцөл байдал Монгол Улсын хувьд эрх зүйн хүрээндээ томоохон реформ, шинэчлэлүүд хийгдэж сайжирч байна.

Тэгэхдээ улс орны хэмжээнд, тодорхой байгууллагууд дээр, тодорхой орон нутаг дээр бас нэлээд олон асуудлаар зөрчил, хүний эрхийн асуудлууд байгаа нь энэ 23 дахь илтгэлээр. Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны илтгэлүүд дээр харагдлаа.

Тийм учраас Улсын Их Хурлын зүгээс Улсын Их Хурал дахь Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо энэ баталсан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтэд хяналт шалгалт хийж ажиллана.

Тэгээд шаардлагатай асуудлаар бид тусгайлан Нийтийн сонголт болон асуулга, зөвлөмжийг нь хийж ажиллаж байгаа.

Тэгэхээр хүний эрхийг хамгаалах үйлсэд Хүний эрхийн комисс, Улсын Их Хурал гэхээс гадна бүх төрийн байгууллага, албан тушаалтнууд, хувийн байгууллагууд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л хуулийн этгээдүүд хамтран зүтгэх шаардлагатай байна гэдгийг онцлон хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Би энэ дээр бас нэг үг нэмж хэлье гэж бодож байна.

Энэ дээр бид нэг том шинэчлэл хийж байна. Юу гэвэл энэ зөвлөмжүүдийг гүйцэд хэрэгжүүлээгүй байгаа байгууллагуудыг бид урьж оролцуулаад эд нарын тайлбар үгийг сонсьё гэж байгаа бол одоо энэ ингээд анхны, юу гэдэг юм бэ дээ, шанг тавьж байна гэсэн үг.

Цаашдаа Хууль зүйн байнгын хороон дээр илтгэл тайланг хэлэлцэж байх явцад цаашдаа үүнийг ч гэсэн ингээд үргэлжлүүлээд явна гэж би итгэж байна.

Тэгээд энэ дээр зүгээр хэдэн зүйл хэлмээр байна.

Яг одоо энд ингээд уригдсан аймгийн төлөөллүүд гээд гэх юм бол Ховд аймаг, Архангай аймаг, Завхан, Увс, Дорноговь гээд аймгууд дээр асуудлууд гарсан байгаа. Энэ хүмүүсийг урьсан байгаа.

Та нар харин ингээд бид нарыг урихад онлайнаар ч гэсэн ирээд оролцож байгаа нь маш чухал шүү.

Яагаад гэвэл амьдрал ажилд наанатай цаанатай дутагдлууд гарч байдаг. Хамгийн гол нь энэ Хүний эрхийн комиссынхоо тавьж байгаа шаардлагуудыг та нар биелүүлж ажиллаж байгаарай.

Цаашдаа энэ бусад бүх аймгуудад сургамж болно гэсэн үг.

Өөрөөр хэлбэл хотоос хэчнээн зайдуу оршиж байгаа ч гэсэн энд яригдаад байгаа тэр хүний эрхийн асуудал чинь зөвхөн Улаанбаатарын асуудал биш бүх аймаг, сумдад хамаатай шүү гэдгийг ойлгож ажиллах хэрэгтэй.

Энэ дээр бас өөр хэд хэдэн байгууллагууд уригдсан байгаа. Мянганы сорилтын сан, “Монгол шуудан” гэсэн байгууллагууд энд дурдагдаад эд нар бүгдээрээ ирсэн байгаа.

Харин би бүгдээрээ эд нар ингээд зориг гаргаад хүрээд ирсэнд би талархаж байна.

Мэдээжийн хэрэг Улсын Их Хурал урьж байхад ирэх ёстой.

Гэхдээ л бас энэ дээр бүгдээрээ тайлбараа бэлдээд хүрээд ирчихсэн байгаа нь шинэ соёл шүү.

Энэ дотор Засгийн газар ч явж байгаа. Засгийн газрын хувьд энэ асуудлыг би өнөөдөр горимын санал гаргаад Улсын Их Хурал дээр энэ илтгэл тайланг Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлнэ гэж байгаа.

Тэгээд Ерөнхий сайд өөрөө ирж нэгдсэн чуулган дээр хүний эрхийн асуудлаар үг хэлнэ гэсэн учраас одоо энэ дээр ямар нэгэн Засгийн газрын төлөөллийг урьж тайлбар авсангүй.

Яагаад гэвэл нэгдсэн чуулган дээр Ерөнхий сайд өөрөө үгээ хэлээд, өөрөө байр сууриа хэлээд энэ дээр явна гэж байгаа учраас.

Тэгэхээр өөрөөр хэлбэл хүний эрхийн энэ асуудал дээр том дарга гэдэг ойлголт байхгүй.

Яг хүний эрхийн хуулийн өмнө бүгдээрээ үүрэг хүлээсэн. Ялангуяа төрийн хүмүүс бүгдээрээ үүрэг хүлээсэн албан тушаалтнууд.

Энэ дээр бид компаниудыг ч ярьж байгаа.

Яагаад гэвэл хүний эрх бол компанид үйлчлэхгүй гэсэн үг биш. Бүх компаниудад, хувийн хэвшилд ч гэсэн жишээлбэл хөдөлмөрийн харилцаа үйлчлээд явж байгаа. Тэнд хүний эрх үйлчлээд явж байгаа.

Хүний эрхийн комисс аль ч байгууллагын хаалгыг очоод тогших эрх бүхий байгууллага шүү гэдгийг бүгдээрээ тал талдаа санаад явах хэрэгтэй гэж хэлмээр байна.

Гишүүд энэ асуудалтай холбогдуулж үг хэлж дууслаа.

Хүний эрхийн комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцэж дууслаа.

Гэхдээ одоо би горимын санал энэ дээр оруулна.

Горимын санал нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Түр хүлээж байгаарай. Манай Байнгын хорооны гишүүд суудал дээрээ ирж сууцгаагаарай.

Сая саналаа уншаад танилцуулчихсан байгаа. Тэгээд энэ уншиж танилцуулсан томъёоллоор дэмжье гэж санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувиайр санал дэмжигдлээ.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулна.

Ингээд энэ 23 дахь тайланг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе.

Найм. “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн комиссын бүх гишүүд энд ирчихсэн сууж байна.

Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Ж.Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Б.Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Х.Мөнхзул Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Г.Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, С.Дондов гишүүн сууж байна. Я.Цэлмэн гишүүн нэмэгдэж орж ирсэн байна. Тэгээд ажлын албаны дарга Ш.Үнэнтөгс.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ц.Сэргэлэн гишүүнд микрофон өгье.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Тогтоолын төсөлтэй танилцлаа.

Түрүүн Б.Энхбаяр гишүүн ярьж л байсан. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, тэгээд хүүхдийн тэтгэлгээ төлдөггүй, үүргээ ухамсарладаггүй эцэг, эхчүүдийн хүүхдийн тэтгэлгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй хүүхдийн тэтгэлгийн сан байгуулах замаар шийдэх нь зүйтэй юм уу гэсэн ийм юу энэ тогтоолын төсөлд явж байна.

Зүгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй гэдэг нь буруутай этгээдүүдээс нөхөн гаргуулна гэсэн санаа юу л гэж би асуух гэж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь энэ шүүхийн шийдвэртэй холбоотой хохирсон хэрэг гэдэг нь шүүхээр тогтоогдчихсон. Төлөх ёстой гэдэг нь шүүхээр бас тогтоогдчихсон ийм хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах.

Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой. Тэр цаг хугацааны хувьд ч тэр, янз бүрийн нөхцөлөөс болоод энэ нь удаад байдаг, ингээд л хохироод явдаг. Хөдөлмөрийн маргааны улмаас ч явж л байдаг, эрүүгийн хэргийн улмаас ч байдаг, зөрчлийн хэргийн улмаас ч ингээд хохирсон иргэд байж байдаг.

Тэр шүүхийн шийдвэр нь гарчхаад эрх нь зөрчигдсөн гэдэг нь батлагдчихаад тэгээд хохирол нь төлөгдөж өгөхгүй яваад байгаа иргэдийн эрхийг хамгаалах тал дээр Та бүхэн бас нэг юм анхаараач ээ л гэдгийг хэлэх гээд байгаа юм. Энэ дээр юм байна уу, үгүй юу гэдэг. Өөр юмгүй. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? 2 дугаар микрофон уу?

Ц.Адъяахишиг: Гишүүний асуултад хариулья.

Хүүхдийн эрхийн тухай конвенцоор мэдээж хүүхдийн эрх ашиг дээд ашиг сонирхол. Хүүхдийн эрхийг бид төрийн байгууллага холбогдох түвшинд нэн тэргүүнд авч үзэх ёстой.

Тэгэхээр энэ хүүхдийн тэтгэвэр төлөх энэ асуудлын цаана маш их хүүхдийн эрх зөрчигдөж байгаа.

Тэгэхээр үнэхээр эцэг, эх нь тэтгэлэг төлөх боломжгүй. Одоо ёстой хоёр чихээ аваад өгөхөөс доор тийм амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур ажилгүй ийм эцэг, эх тэтгэвэр төлөгч, тэтгэлэг төлөгчийн цаана хүүхдийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдөж байна.

Тэгэхээр энэ дээр юу гэдэг юм анхан шатынхаа суурь хэрэгцээг хангахгүй байна, хоногийн хоолоо ч идэж чадахгүй ийм олон хүүхдүүд байна.

Тийм учраас энэ асуудлыг бид анхаарч энэ нөхөн төлөгдөх нөхцөлтэй ийм сан бүрдүүлээд, тэгээд тэр эцэг, эхээр буруутай хүүхдийнхээ тэтгэлэг төлж чадахгүй эцэг, эхээр нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх ч гэдэг юм уу, албадан хөдөлмөрлө эрхлүүлэх замаар мэдээж тэр тэтгэлгийг нь нөхөн төлүүлэх ийм асуудлыг гаргаж тавьсан байгаа.

Хоёрдугаарт нь, тэтгэвэр төлөх асуудал маш хангалтгүй байгаа. Өнөөдөр хүүхдийн тэтгэлэг төлөх Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын мэдээллээс үзэхэд 50 хувьдаа ч хүрэхгүй байна.

Тэгэхээр Зөрчлийн тухай хуулиар нэг баривчлах ч гэдэг юм уу. Тийм ээ. Энэ шийтгэлээ л аваад явчхаж байна. Тэтгэл үүний хариуцлагыг бид маш чангатгах хэрэгтэй байна л даа. Энэ асуудлыг хөндсөн байгаа юм.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Ц.Сэргэлэн гишүүн ээ? Ц.Сэргэлэн гишүүнд микрофон өгье.

Ц.Сэргэлэн: Нэгдүгээр асуудлын хувьд ойлгомжтой юм байна.

Ер нь тэгэхдээ тэр өөрөө хэллээ шүү дээ. Хүүхдийн тэтгэврийг төлөх ямар ч боломжгүй хүмүүс байгаад байна гэж.

Тэгээд эдгээр хүмүүсийн төлөхгүй байгаа, боломжгүй байгаа тэр тэтгэврийг төлүүлэхдээ энэ сангаас төлүүлье. Тэгээд эргээд нөхөн төлүүлье гээд. Энэ эрх зүйн орчин бүрдүүлэх учраас их сайн анхаарч

яах вэ гэдгийг л бодох хэрэгтэй л байх л даа.

Нэгдүгээр асуудлын хувьд ойлгомжтой боллоо.

Хоёрдугаар асуудлын хувьд би энэ хүүхдийн тэтгэврээс гадна юм яриад байгаа юм. Эрүүгийн, иргэний. Тийм ээ. Өөр хөдөлмөрийн маргааны явцад үүссэн эрх нь зөрчигдсөн иргэний эрхийг хамгаалах.

Тэгсэн мөртлөө энэ нь зөрчигдсөн гэдгийг нь шүүх тогтоочихсон. Үүнийг нь эрхийг нь сэргээгээд заагаад өгчихсөн. Ийм зүйлийн эрхийг нь хамгаалах тал дээр л Та бүхэн анхаараач ээ л гэдэг юм хэлээд байгаа юм.

Ер нь нарийн ярих юм бол энэ хүний эрх.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон өгье.

Д.Сүнжид: Ц.Сэргэлэн гишүүний хэлж байгаатай санал нийлнэ.

Бид хэд энэ хохирогчийг хамгаалах, хохирол нөхөн төлөх тогтолцоо гээд дүн шинжилгээ хийж үзсэн.

Тэгэхээр эрүү шүүхийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөгдөж байгаа байдал гэхээр 50 хүрэхгүй хувь байдаг. Ингээд 200 тэрбумын хохирол учирсан бол 100 л төлөгддөг ийм л дүнтэй л яваад байдаг юм билээ.

Тэгээд эрүү, иргэний журмаар шүүхийн шийдвэр гарчихсан. Биелэгдэнэ гэхээр хэзээ ч 100 хувь биелж чаддаггүй.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр адилхан. 60 хувь биелэгдсэн бол бид өндөрт тооцдог ийм статистиктай.

Тэгээд нэмээд ажил эрхлэлт, хөдөлмөрийн хүрээнийх, захиргааны дотоод механизм, ажил олгогч гээд явах юм бол бид яг үнэндээ хохирогчийг бүрэн төлж чадахгүй байгаа үнэн.

Хэдийгээр урьдчилан шийдвэрлэх ажиллагаа шүүхийн шатдаа шийдвэр нь гарчхаад байхад гэм буруутай этгээдэд шийтгэлийг ногдуулчихсан боловч яг хохирлыг нөхөн төлсөн үү гэдэг дээр манай тогтолцоо дутагдалтай байгаа.

Тийм учраас Хүний эрхийн Үндэсний Комисс энэ дээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг нь өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр хүний эрхийг хангах гол газар дээр орон нутаг дээр нь ажиллаж байгаа гол иргэн буюу хүний эрхийн хамгаалагчийн талаарх энэ заалтуудаас их чухал заалтууд орсон байна.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн ажлын хэсэг яг энэ цаг мөчид ажиллаж байгаа.

Ингээд бидний ажиллаж байх явцад гэрч, хохирогчийг хамгаалах асуудал бас л их түвэгтэй байгаа юм бмлээ.

Бид Цагдаагийн ерөнхий газар болон холбогдох байгууллагуудаар ажиллаж байна.

Тэгэхээр энэ тогтоолын төслийн 5-ын 6 дээр гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан механизмыг бий болгоно гэж орсон байгаа. Энэ яг ямар институтийг хэлж байна? Хуучны нөгөө татан буулгасан Тахарын албыг хэлж байна уу? Энэ дээр тодорхой мэдээллийг авах хэрэгтэй байна.

Тэгээд энэ 7 дугаар зүйл дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо гээд. Энэ бол их чухал асуудал. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын 8 удаагийн сонгууль явагдаад парламент бүрдэхэд нэг ч хөгжлийн бэрхшээлтэй гишүүн орж ирээгүй юм.

Тийм учраас манай Улс төрийн намын тухай хуулийн ажлын хэсэг энэ дээр онцгойлон анхаарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог дэмжих төрийн механизм, санхүүжилтийг бий болгосон байгаа. Намд олгож байгаа төсөл санхүүжилтийн 20-иос доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон залуучууд гээд нийгмийн бүлгүүдийг дэмжих чиглэлээр.

Тэгэхээр энэ 7-гийн б-д дээр бүх шатын сонгуульд нэр дэвшиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдийн сурталчилгааны зардал болон хүртээмжтэй тээврийн хэрэгслийг нэмэлтээр гаргах энэ зохицуулалтыг бий болгоно гэж байна.

Тэгэхээр энэ маань яг тухайлан Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хуульдаа орохыг хэлж байна уу? Эсвэл бүр тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны тал дээр хуулийн юу оруулах гээд байна уу?

Яах вэ, бид ямар ч байсан улс төрийн намуудад үүрэг болгочихсон байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжих. Тэгээд намд олгож байгаа төсвийн санхүүжилтийг.

Энэ маань одоо ингээд 2024 оны шинэ Улсын Их Хурлаар бүрдсэн парламентад хэрэгжээд явна.

Зүгээр миний хувьд ямар ч байсан энэ удаагийн парламентаар нэгээс доошгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж ирнэ гэсэн итгэлтэй байгаа.

Тэгээд цаашдаа мэдээж парламентын дэг болон бусад механизмд хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ оролцоог дэмжих талын механизм явна гэж бодож байна.

Тэгээд энэ хоёр асуултынхаа хариултыг авъя.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье. С.Дондов гишүүн.

С.Дондов: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаад үндсэндээ 3 дахь жилдээ орох гэж байна.

Тэгээд энэ шинэ механизм хэрэгжих явцад хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах асуудал энэ хуулийг батлагдсантай холбогдуулаад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.

Үүнтэй уялдаад хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хангах асуудал чухлаар тавигдаж ирсэн. Ингээд Цагдаагийн ерөнхий газрын дэргэд 4

хүний бүрэлдэхүүнтэй гэрч, хохирогчийг хамгаалах ийм хэлтэс ажиллаж байна.

Орон нутагт цагдаагийн байгууллагын нэг мөрдөгч өөрийнхөө ажил үүргийг нь давхар хариуцаад явж байна.

Тэгэхээр бүхэлд нь харахаар ер нь гэрч, хохирогчийг хамгаалах тухай энэ чухал хуулийг бид нарын хэрэгжилт төдийлөн хангалттай биш байна гэж үзэхээр байгаа.

2015 онд гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг 2015 онд Засгийн газрын 346 дугаар тогтоолоор баталсан хэдий ч өнөөдрийг хүртэл нэг ч төгрөг төсөвлөж хэрэгжээгүй. Энэ хэрэгжээгүй хөтөлбөр бидний судалгаанд тодорхой дурдагдсан байгаа.

Тэгэхээр Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг дагалдаж гарч байгаа хөтөлбөр, мөн гэрч, хохирогчийг хамгаалах, түүнд дагалдан гарч байгаа Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль. Удахгүй Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль гээд гараад ирэх юм бол энд эдгээр хүмүүсийн шүгэл үлээж байгаа, хүний эрхийг хамгаалах чиглэл тэр үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагчдад аюултай, эрсдэлтэй нөхцөл байдлууд гарах нь ойлгомжтой. Гарсаар байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг шийдэхэд зөвхөн энэ гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн ажилтнууд хүрэлцээгүй, хамгаалах байр огт байхгүй. Ийм тохиолдолд хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хангах асуудал гэрч, хохирогчийг хамгаалах механизмыг бүхэлд нь бий болгосноор, тэр дотор хүний эрхийн хамгаалагчийг, шүгэл

үлээчийн аюулгүй байдлыг хангах асуудал өнөөдөр тулгамдсан асуудал юм.

Тийм учраас гэрч хохирогчийг хамгаалах механизмыг бүхэлд нь байгуулах асуудал бодлогын шинжтэй асуудал байх ёстой. Энэ дээр төрөөс тусгайлан анхаарч аюулгүй байдлыг нь хангах асуудал дээр анхаарах ёстой гэсэн ийм саналыг оруулсан.

Ингээд бид бүхний 5 дахь бүлэг буюу Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, мөн иргэний нийгмийн байгууллага болон байгаль орчны асуудлаар ажилладаг хүний эрхийн хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаанд гэрч, хохирогчийг хамгаалах механизм яагаад хэрэгтэй вэ гэдгийг нэлээн тодорхой тоо баримтуудтай, кэйсүүдтэйгээр оруулсан байгаа.

Тийм учраас Их Хурлын чуулганаар хэлэлцэх үед бид үүнийг илүү бодитой танилцуулах боломж байгаа гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 2 дахь асуулт. 1 дүгээр микрофон өгье.

Д.Сүнжид: Ц.Мөнхцэцэг гишүүний хоёр дахь асуултад хариулъя.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо, сонгох сонгодог эрхийн хэрэгжилтийн дүн шинжилгээ үзэхээр 70 хувь нь нийгмийн амьдралд өөрсдөө бие дааж оролцох тийм санхүүгийн болоод чадавх байдаггүй.

Тийм учраас одоогийн байгаа Улс төрийн намын тухай хуульд оруулсан зохицуулалт олон талын төлөөллийг хангана гээд зогсохгүй яг энэ хүмүүсийг тодорхой дэмжих тэр сонгуулийн зардал,

анхан шатын төсөв, дэмжлэг. Үүнийг шийдэхгүйгээр бид ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгогдох эрхийг нь хангах бэрхшээлтэй юм байна.

Тийм учраас хуулиар тусгайлан зохицуулаач ээ л гэдэг санал өгч байгаа юм.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо тогтоолтой холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Санал. Ц.Мөнхцэцэг гишүүн.

Тогтоолын тексттэйгээ холбогдуулсан санал байвал. Тийм. Тэрийг харин би гаргах гэж байгаа юм. Тийм.

Түрүүн Б.Энхбаяр гишүүний ярьсан саналыг. Би тэр саналуудыг нь хэлэх гэж байгаа юм.

Одоо энд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Б.Энхбаяр сайдын гаргасан хоёр санал байгаа.

Энэ тогтоолын төслийн 4.а, 9.а хоёрыг хасъя гэсэн саналтай байгаа.

Тэгээд нэгэнт Байнгын хорооны гишүүн ийм санал гаргасан учраас үүгээр санал хурааж шийдэхээс өөр.

Надад “а” гээд тэгж байх юм. 4-ийн “г”. Тийм.

Б.Энхбаяр гишүүн өөрөө байхгүй байгаа болохоор саналыг нь би өмнөөс нь гаргаад явж байна шүү.

Тэгэхээр энэ хоёроор тус тусад нь санал хураана. Ингээд тэр тогтоолын төслөөс 4-ийн “г” хэсгийг хасъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Байхгүй болохлоор. Би чинь энэ асуудлыг нь оруулж байгаа Байнгын хороо дарга хүн чинь. Тийм. Оруулж байгаа сайд өөрөө байх ёстой шүү дээ.

Тэгвэл хоёр дахь нь ч яг ийм л ер нь болох нь. Тэгэхдээ хураахаас өөр үггүй.

Тогтоолын төслийн 9-ийн “а”-г хасъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Улсын Их хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Оролцсон гишүүддээ талархлаа. /алх цохив/

Хуралдаан 5 цаг 06 минут үргэлжилж, 16 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД